

ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН БАТАТГАХ СУРГАЛТЫН АВЛАГА

ИТХ-ын төлөөлөгчдөд зориулав.



Улаанбаатар хот
2018 он



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

**Swiss Agency for Development
and Cooperation SDC**



*Empowered lives.
Resilient nations.*

Швейцарын Хөгжлийн Агентлаг, Монгол дахь НҮБ-ын Хөгжлийн
Хөтөлбөр, УИХ-ын Тамгын газар хамтран хэрэгжүүлж буй “Монгол
улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь” төсөл

АГУУЛГА

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР, ШИЙДВЭР ГАРГАХ ҮЙЛ ЯВЦ	5
1.1. ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭРИЙН МӨН ЧАНАР, ОНЦЛОГ, ОРОЛЦОГЧ ТАЛУУД, ТЭДГЭЭРИЙН ҮҮРЭГ	6
1.1.1. ИТХ-ын шийдвэр, түүний онцлог	6
1.1.2. Асуудал санаачлах, өргөн мэдүүлэх	7
1.1.3. ИТХ-ын хороо	8
1.1.4. Нам, эвслийн бүлэг	9
1.1.5. ИТХ-ын хуралдаан	9
1.1.6. ИТХ-ын ажлын алба	10
1.1.7. ИТХ-ын төлөөлөгч	11
1.2. ХЭЛЭЛЦҮҮЛЭГ. ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР: ПРАКТИКТ ГАРЧ БУЙ ЗӨРЧИЛ, ШИЙДЭЛ	13
Нэмж судлах эх сурвалж	13
ХОЁРДУГААР БҮЛЭГ. ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЛЭЭ	14
2.1. ХУУЛЬ ЗҮЙН ТЕХНИКИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ	15
2.1.1. Хууль бүтээх хууль зүйн техник	16
2.1.2. Хууль хэрэгжүүлэх хууль зүйн техник	17
2.2. ИТХ- ҮНДСЭН ХУУЛИЙН БАЙГУУЛЛАГА БОЛОХ НЬ	17
2.2.1. Монгол Улсын Үндсэн хуулийн 62.2	17
2.2.2. Бие даасан хэм хэмжээний акт гаргах	18
2.3. ИТХ-ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА БОЛОХ НЬ	20
2.3.1. Захиргааны шийдвэр гаргах ажиллагаа	22
2.3.2. Захиргааны хэм хэмжээний акт гаргах	24
Багшийн дүгнэлт	26
Нэмж судлах эх сурвалж	26
ГУРАВДУГААР БҮЛЭГ. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙГ ТӨЛӨВЛӨХ, ХЯНАХАД ИТХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ	27
3.1. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БА ТӨСВИЙН УЯЛДАА	28
3.1.1. Орон нутгийн хөгжлийн бодлогын баримт бичгүүд, тэдгээрийн ангилал	31
3.1.2. Кейс, хэлэлцүүлэг: Орон нутгийн хөгжлийн дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүд болон төсвийн уялдааг хангаж буй байдалд үнэлгээ өгөх	33

3.2. ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭРЭГЦЭЭГ ТОДОРХОЙЛОХ, ЭРЭМБЭЛЭХ, ШИЙДВЭР ГАРГАХ ҮЙЛ ЯВЦАД ИТХ-ЫН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ	41
3.2.1. Хэлэлцүүлэг: Орон нутгийн төсвийн үйл явцын үндсэн үе шатууд ба ИТХ-ын үүрэг	41
3.2.2. Дасгал ажил: Орон нутгийн хөрөнгө оруулалтын хэрэгцээг тодорхойлох, эрэмбэлэх, шийдвэр гаргах үйл явцыг зураглах	41
3.2.3. Кейс, хэлэлцүүлэг: Орон нутгийн хөрөнгө оруулалтыг төлөвлөх, шийдвэр гаргах үйл явцад ИТХ-ын Төлөөлөгчийн гүйцэтгэх үүргийг тодорхойлох.....	42
3.3. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТ, ТҮҮНИЙ ИЛ ТОД БАЙДАЛД ИТХ-ААС ХЭРЭГЖҮҮЛЭХ ХЯНАЛТ	46
3.3.1. Орон нутгийн төсвийн зарцуулалт, ил тод байдалд ИТХ-аас хяналт тавих шаардлага.....	46
3.3.2. Дасгал ажил, хэлэлцүүлэг: Орон нутгийн төсвийн зарцуулалт, түүний ил тод байдлыг хянах чиглэлээр ИТХ-аас хэрэгжүүлж буй ажлын талаарх туршлагаа хуваалцах	57
3.3.3. Кейс, хэлэлцүүлэг: Орон нутгийн болон байгууллагын төсвийн ил тод байдлыг үнэлэх.....	57
Багшийн дүгнэлт.....	59
Нэмж судлах эх сурвалж.....	59
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. БАЙГАЛЬ ХАМГААЛАЛ, ГАЗРЫН ХАРИЛЦАА – ИТХ болон ИРГЭДИЙН ОРОЛЦОО.....	60
СУРГАЛТЫН ҮНДСЭН КЕЙС	72
Кейс 1. Тариалангийн зориулалтаар газар эзэмшүүлэхэд багийн иргэдийн санал хүчинтэй.....	72
Кейс 2. Багийн ИНХ-ын нэхэмжлэл хүчингүй болсон нь	74
Кейс 3. Дүүргийн ИТХ-ын тогтоол, Засаг даргын захирамж юуны учир буруудав?77	
Кейс 4. Малчид, тариаланчдын үйл ажиллагааны зохицуулалт	80
Кейс 5. Дархан цаазат Богдхан уулын тусгай хамгаалалттай газрын хил заагын тухай.....	86
Кейс 6. Орон нутгийн тусгай хамгаалалтад авахад гарсан алдаа, сургамж.....	89
Дасгал 1: Мал аж ахуй: бэлчээр, усалгаа, өвөлжөө, хаваржаа, намаржаа, зуслангийн хуваарийг хийж буй арга ажиллагаа, туршлага	92
Кейс 7. Бэлчээрийн менежмент - иргэдийн оролцоо	92
Кейс 8. Нөөц бэлчээр ашиглалт	92
Кейс 9. Өвөлжөө, хаваржааны нутаг хуваарилсан	92
Дасгал 2: Газар тариалан: хөрсний элэгдэл, хамгаалал, сэлгэлт, химийн бордооны хэрэглээ, эерэг болон сөрөг нөлөөлөл, туршлага	92

Кейс 10. Нишингэ, рапс тариалахыг дэмжсэн шийдвэр /ИТХ-ын тогтоол, Засаг даргын захирамж, тариалсан талбай, ургац, хөрс газарт үүссэн өөрчлөлт/	92
Кейс 11. Нишингэ, рапс тариалахыг хориглосон шийдвэр /ИТХ-ын тогтоол, Засаг даргын захирамж, тариалсан талбай, ургац, хөрс газарт үүссэн өөрчлөлт/	92
Кейс 12. Химийн бордооны хилээр орох хяналт, хэрэглээ, бордоог хэрэглэх стандарт, бороо хэрэглэсэн үеийн ургац, бордоог хэтрүүлэн хэрэглэсэн үеийн ургац зэргийг баримтжуулж, хэлэлцэх	92
Дасгал 3: Хот байгуулалт: хот суурингийн төлөвлөлт, хог хаягдлын асуудлыг шийдэж буй туршлага, арга ажиллагаа, үр дүн	92
Кейс 13. Малтай өрхийн талаар баримтлах бодлого.....	92
Кейс 14. Ногоон байгууламжийн ашиглалт, хамгаалалт	93
Кейс 15. Хог тээвэрлэлт, ангилах, устгах үйл ажиллагаа.....	93
Кейс 16. Хог хаягдлын цэгийн менежмент - иргэдийн оролцоо.....	93
Дасгал 4: Тусгай хамгаалалт, ойжуулалт, түймэр, нөхөн сэргээлтийн ажил, туршлага .	93
Кейс 17. Ойн хамгаалалт, ашиглалт, цэвэрлэгээ, нөхөн сэргээлт.....	93
Кейс 18. Ойн сан бүхий газраас цэвэрлэгээний журмаар мод ашиглуулах.....	93
Кейс 19. Тусгай хамаалалтад авах	94
Кейс 20. Орон нутгийн тусгай хамгаалалтад авах	94
Дасгал 5: Уул уурхай: хайгуул, олборлолт, нөхөн сэргээлтийн ажил, үр дүн	94
Кейс 21. Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул, ашиглалт.....	94
Кейс 22. Уул уурхай ашиглалт, нөхөн сэргээлт	94
Кейс 23. Уул уурхайн нөхөн сэргээлт хийх	94
Кейс 24. Түгээмэл тархацтай ашигт малтмал	94
Нэмэлт дасгал.....	95

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР, ШИЙДВЭР ГАРГАХ ҮЙЛ ЯВЦ

Сургалтын зорилго: Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийн мөн чанар, онцлог, шийдвэр гаргах үйл явц, оролцогч талууд, тэдгээрийн үүрэг, оролцооны талаар цэгцтэй мэдлэг олгоход чиглэнэ

Хүрэх үр дүн: Суралцагч нь ИТХ-ын төлөөлөгч хүний хувьд шийдвэр гаргах үйл явцад оролцохдоо саналаа гаргах, саналаа шийдвэрт тусгах, гарсан шийдвэрийг сурталчлах, хэрэгжилтийг тооцох, хариуцлагаа ухамсарлах талаар арга барил, ур чадвар эзэмших боломж бүрдэнэ.

Хүснэгт 1.1. Хичээлийг зохион байгуулах төлөвлөгөө

№	Үйл ажиллагаа	Цагийн хуваарилалт	Хичээлийн хэлбэр	Сургалтын хэрэглэгдэхүүн
1	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийн мөн чанар, онцлог, оролцогч талууд, тэдгээрийн үүрэг	30 минут	лекц	Слайд, цагаан самбар, самбарын үзэг
2	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэр: практикт гарч буй зөрчил, шийдэл	20 минут	хэлэлцүүлэг	Дэлгэц цаас, цаасны маркер
	НИЙТ	50 минут		

Багшид өгөх зөвлөмж

- Энэ сэдвийн үндсэн агуулга нь суурь сургалтын агуулгад багтсан учир ИТХ-ын төлөөлөгчдөд энэ сэдвээр лекц уншихдаа аль болох мэдлэгийг эргэн сэргээх, асуудлын чухалд анхаарлыг нь хандуулах зорилгоор бэлтгэх нь зүйтэй.
- Лекцийн слайдыг нэгбүрчлэн унших бус, харин тухайн агуулгын хүрээнд тохирсон жишээ, тохиолдол, шийдлийг ярих (гэхдээ зүгээр нэг хүүрнэх бус, хууль зүйн болон шинжлэх ухааны үүднээс тайлбарлахыг чухалчлах) нь зүйтэй.

1.1. ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭРИЙН МӨН ЧАНАР, ОНЦЛОГ, ОРОЛЦОГЧ ТАЛУУД, ТЭДГЭЭРИЙН ҮҮРЭГ

Лекц, 30 минут

1.1.1. ИТХ-ын шийдвэр, түүний онцлог

Шийдвэр нь “...хэрэгжүүлэх боломжтой хэд хэдэн хувилбаруудаас хийх сонголт...” (Я.Шуурав нар, 2017, 216 дахь тал) бөгөөд үүний дотор Хурлын шийдвэр нь хэд хэдэн онцлогтой юм.

Юуны өмнө Хурлын шийдвэр нь *хамтын шийдвэр* юм. Хамтын шийдвэр гэдэг нь тухайн асуудалд шууд хамааралтай хэд хэдэн этгээд (2 ба түүнээс дээш тооны) тэгш эрхтэйгээр оролцож гаргасан шийдвэр юм. Хамтын шийдвэрийн жишээ нь, эрхэлсэн сайд, Төрийн албаны зөвлөлийн хамтарсан тушаал, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэр гэх мэт. Тэгш эрхтэйгээр оролцохын зэрэгцээ шийдвэр гаргагч этгээдүүд бүгд уг шийдвэрийн хариуцлагыг хамтаараа хүлээдэг нь хамтын шийдвэрийн нэг онцлог юм.


Нутгийн өөрөө удирдах байгууллага нь хамтын шийдвэр гаргадаг этгээд болохынхоо хувьд хуралдах нь түүний шийдвэрээ гаргах үндсэн арга бөгөөд нийт төлөөлөгчдийн олонх нь хуралдаанд оролцсоноор хүчин төгөлдөр болж (өөрөөр хэлбэл, шийдвэр гаргах хууль ёсны бүрэлдэхүүн бүрдэж) шийдвэрээ гаргадаг байна. Нутгийн өөрөө удирдах байгууллагын шийдвэрийг хэн нэгэн этгээд, түүний дотор ИТХ-ын дарга, төлөөлөгч дангаараа буюу хэсэг бүлгээрээ төлөөлөн гаргах эрхгүй бөгөөд хуулийн дагуу иргэдээс сонгогдсон бүрэлдэхүүн хуралдаж байж, сая шийдвэр гаргах эрх нь үүсдэг. Өөрөөр хэлбэл, Хурлын хуралдаан нь түүний үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь юм.

Хурлын шийдвэрийн нэг онцлог бол Хурлын шийдвэр гаргах үйл явцад Хурлын Тэргүүлэгчдийн хүлээх үүрэг юм. Хурлын Тэргүүлэгчид нь Хурлын шийдвэр гаргах үйл явцад хоёр өөр үүрэгтэй оролцдог. Нэг талаас, Тэргүүлэгчид нь Хурлын байнгын тасралтгүй ажиллагааг нь хангах үүргийнхээ дагуу Хурлын хуралдааныг зарлах, Хурлаар хэлэлцэх асуудлыг товлох, урьдчилан хэлэлцэж, санал дүгнэлт гаргах хэлбэрээр Хурлын шийдвэр гарах үйл явцад оролцдог. Гэхдээ нөгөө талаас, Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу Хурлын Тэргүүлэгчид нь тухайн Хурлын хуралдааны чөлөө цагт нутгийн өөрөө удирдах байгууллагын үүргийг гүйцэтгэх (Монгол Улсын Үндсэн хууль, Тавин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэг) бөгөөд гаргасан шийдвэр нь Хурлын шийдвэрийн нэгэн адил хүчин төгөлдөр хэрэгжинэ. Өөрөөр хэлбэл, Хурлын Тэргүүлэгчдийн шийдвэр нь Хурлын шийдвэрийн нэгэн төрөл юм. Тэргүүлэгчид хуулиар олгогдсон өөрийн бүрэн эрхийн хүрээнд шийдвэр гаргахын зэрэгцээ Хурлын 12 бүрэн эрхийг Хуралд дараа тайлагнахаар Хурлын хуралдааны чөлөө цагт хэрэгжүүлж болно (Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, 20 дугаар зүйл).

Социализмын үеэс Тэргүүлэгчдийг аливаа хурлын удирдах бүрэлдэхүүн хэлбэрээр ойлгож, ажиллуулж ирсэн болохоор өнөөдөр ч орон нутгийн Хурлын Тэргүүлэгчдийг түүний адил удирдах бүрэлдэхүүн хэмээн ойлгох нь түгээмэл байна. Хэрэв Тэргүүлэгчдийг удирдах бүрэлдэхүүн хэмээн үзэх нь Хурлын төлөөлөгчид, улмаар Хурлын өөрийнх нь ач холбогдлыг бууруулж, цөөхөн хүн нутгийн өөрөө удирдах байгууллагыг төлөөлөн шийдвэр гаргахад хүрч, төлөөллийн ардчиллын зарчим зөрчигдөх билээ.

Тэргүүлэгчдэд хэдийгээр Хурлыг удирдах үүрэг байхгүй ч, Хурлын хамгийн зохион байгуулалттай, идэвхтэй хэсэг нь байж, нутгийн өөрөө удирдах ёсыг төлөвшүүлэхэд манлайлагчид нь байх учиртай. Иргэдийн санаа бодлыг сонсох, Хурлын шийдвэрийг иргэдэд сурталчлах, орон нутгийн хэмжээний бодлого боловсруулах зэрэг ажилд тэргүүлэн оролцож, иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах гол хүч нь байвал зохино.

Зураг 1.1. Хурлын шийдвэр гаргах үйл явц



Зураг №1-д Хурлын шийдвэр гаргах үйл явцын дарааллыг дүрслэн үзүүлсэн бөгөөд шийдвэр гаргахад Хурлын бүрэлдэхүүн хэсэг бүрийн үүрэг уг зурагнаас тод харагдана. Хурлын шийдвэр гаргах үе шат бүрт Хурлын бүрэлдэхүүн хэсгийн оролцоог өнгөөр ялган үзүүлсэн бөгөөд Хурал нь энэ үе шат бүрийг, түүнчлэн Хурлын бүрэлдэхүүн хэсгүүдийн үйл ажиллагааг хуулийн хүрээнд журамлан зохицуулах шаардлагатай юм.

1.1.2. Асуудал санаачлах, өргөн мэдүүлэх

Хуралд асуудал санаачлан өргөн мэдүүлж хэлэлцүүлэх эрх нь Хурлын төлөөлөгч (дангаараа буюу хамтаараа), Тэргүүлэгчид, хороо, тухайн шатны Засаг даргад

хадгалагдана. Гэхдээ Хурлаас гарч байгаа шийдвэрийн дийлэнх хувийг Засаг даргаас санаачлан өргөн мэдүүлсэн асуудал эзэлдэг нь практикаас харагддаг. Энэ нь нэг талаас төсөв, төлөвлөгөө гээд Засаг даргаас зайлшгүй өргөн мэдүүлж хэлэлцүүлэх асуудал олон байдагтай холбоотой боловч нөгөө талаас Хурлын төлөөлөгчид, хороодын идэвх санаачлагатай ч холбоотой юм.

Асуудал санаачлан өргөн мэдүүлэх горимыг хуульд тодорхой заагаагүй бөгөөд үүнийг Хурал өөрөө журамлан зохицуулах учиртай. Энэ журамд асуудал өргөн мэдүүлэхэд шийдвэрийн төслөөс гадна ямар мэдээллийг дагалдуулж ирүүлэхийг тусгайлан зааж болохоос гадна өргөн мэдүүлэх хугацааг тогтоох нь чухал. Хуралдаан болохоос өмнө өргөн мэдүүлж буй асуудлыг Хурлын хороод, намын бүлгүүд хэлэлцэж, санал дүгнэлтээ боловсруулахад хангалттай хугацаа байх хэрэгтэй. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 3-т заасан “хуралдаан болохоос 1 хоногийн өмнө төлөөлөгчдөд тараах” шаардлага нь өргөн мэдүүлэх хугацааг Хурлаас тогтоох асуудалтай хамааралгүй юм. Энэ заалтаар хэлэлцэх асуудалтай холбоотой мэдээллийг төлөөлөгчдөд хуралдаан болохоос хамгийн багадаа 1 хоногийн өмнө хүргүүлсэн байх шаардлагыг тогтоосон болохоос хороо, намын бүлгээр урьдчилан хэлэлцэх асуудлыг зохицуулаагүй юм. Тэгэхээр өргөн мэдүүлсэн хороо, намын бүлгээр урьдчилан хэлэлцэж, санал дүгнэлт гаргах хугацааг Хурал өөрөө тогтоох нь зүйтэй.

1.1.3. ИТХ-ын хороо

Хороо нь Хурлын тодорхой эрхлэх асуудлыг дагнан хариуцах дотоод зохион байгуулалтын нэг хэлбэр юм. Хороо нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд Хурлаас гарах шийдвэрийн төсөл боловсруулах, шийдвэрийн төсөлд санал өгөх, эрхлэх асуудлаараа иргэдийн санаа бодлыг судалж хэлэлцэх, дүгнэлт гаргах, тодорхой байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд дүгнэлт өгөх зэргээр Хурлын шийдвэрийг үндэслэлтэй, мэргэших магадлалтай гаргахад дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа эрхлэн явуулна.

Хороог байгуулахдаа анхаарах нэг зүйл нь уг хороонд хэдий хэр өргөн хүрээтэй асуудал хариуцуулж байгаагаа эргэн харах зүйтэй. Хэт их өргөн хүрээтэй асуудал хариуцан авсан хороо нь идэвхтэй ажиллахын оронд “нуугдмал” байдалд шилжин орох нь элбэг байгаа талаар мэргэжилтнүүд, судлаачид ярьдаг. Тэгэхээр ИТХ нь бүрэн эрхийнхээ хугацааны эхэнд үйл ажиллагааныхаа тэргүүлэх чиглэлүүдийг тогтоож, тэр чиглэлээрээ хороод байгуулан ажиллах нь хэт их өргөн хүрээтэй асуудлыг хариуцан аль ч үгүй үлдэх явдлаас сэргийлсэн, түүний зэрэгцээ “амалсан” ажлаа хийж гүйцээх сайхан боломж олгосон явдал гэж ойлгож болно.

Хороодын тоо, нэг хорооны гишүүний тоо хэд байхыг Хурал нь өөрөө л тогтоох бөгөөд нийт төлөөлөгчөө тэнцүү хуваан 4-5 хороотой болгон зохион байгуулж байгаа өнөөгийн нийтлэг практикаас зайлсхийж, нэг төлөөлөгч хэд хэдэн хорооны гишүүн байж болохоор зохион байгуулах боломж бий. Ингэснээр хороодын үйл ажиллагааны уялдаа сайжрах ба хороодын дунд хариуцан ажиллах асуудлын давхцал, хийдэгдэл гарахгүй байх магадлал нэмэгдэх юм.

Зайлшгүй байх хороодод төсөв санхүүгийн, нутгийн захиргааны асуудал эрхэлсэн хороодыг нэрлэж болох ба харин нийгмийн бодлогын болон ХАА-н бодлогын асуудлаар тус тус хэд хэдэн хороо байгуулж болох юм. Тухайлбал, тухайн Хурлын бүрэн эрхийн хугацаанд тэргүүлэх чиглэлээ тодорхойлохдоо нийгмийн халамжийн

асуудлаар, эсвэл хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр гэх мэтчилэн нийгмийн бодлогын тодорхой асуудлаар дагнасан хороо байгуулж ажиллуулж болно.

1.1.4. Нам, эвслийн бүлэг

Нам, эвслийн бүлгийн талаар Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд 1 л удаа дурдсан байдаг (26 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт тухайн Хурал дахь нам, эвслийн бүлэг нь Засаг даргад нэр дэвшүүлэх саналаа гаргах талаар заасан) ч нам, эвслийн бүлгийг байгуулах болон зохион байгуулалт, үйл ажиллагааных нь талаар огт дурдаагүй. Энэ нь нам, эвслийн бүлгийн үйл ажиллагааг Хурал өөрөө зохицуулах шаардлагатайг харуулж байгаа хэрэг. Хэт их намчирхдаг, талцдаг, Хурлын үйл ажиллагааг гацаадаг гэх мэтээр нам, эвслийн бүлгийг шүүмжилдэг тул зарим Хурал нам, эвслийн бүлгийн үйл ажиллагааг хязгаарлах, хориглох оролдлого хийж байсан тохиолдол бий. Хориглож, хязгаарласнаар нам, эвслийн явуулж байгаа үйл ажиллагаанд эерэг өөрчлөлт орно гэж найдах хэрэггүй юм. Харин ч зохион байгуулалт, үйл ажиллагааг нь цэгцтэйгээр журамлан зохицуулах нь хавьгүй илүү ач холбогдолтой болох билээ.

Нам, эвслийн бүлгийг байгуулах, хуралдах, шийдвэр гаргах, Хурлын хуралдааны өмнө хэлэлцэх асуудлыг урьдчилан хэлэлцэж, санал дүгнэлтээ боловсруулах зэрэг Хурлын үйл ажиллагаанд холбогдох зохицуулалтыг олонхиор “түрүү” барилгүйгээр хийх нь чухал.

Намын бүлгийн бүрэлдэхүүн, түүний ажиллах хэлбэр, намын бүлгээс ИТХ-ын хуралдаанд саналаа гаргах асуудлыг Хурал өөрийн онцлогийг харгалзан бие даан тогтоох нь зүйтэй. Намын бүлэг нь тодорхой албан тушаалтан (ИТХ-ын дарга, Тэргүүлэгчид, Засаг дарга)-ыг томилох, сонгох, чөлөөлөх, огцруулахтай холбоотой асуудал, түүнчлэн тухайн нэгжийн төсөв, түүний гүйцэтгэл, нутгийн хөгжлийн бодлогын асуудал, газар эзэмших, өмчлөх, байгалийн баялаг ашиглах, олборлохтой холбоотой асуудал зэрэг чухал ач холбогдолтой, нутгийн иргэдийн язгуур эрх ашигтай шууд холбоотой асуудлуудад саналаа намаараа нэгтгэн оруулж, ИТХ-аар хэлэлцүүлэх боломжтой байх учиртай. Харин асуудал бүрээр намын бүлэг бүр саналаа илэрхийлэх албагүй бөгөөд энэ асуудлыг шийдвэрлэх талаар саналаа гаргахдаа юуны өмнө намын бус, харин нутгийн иргэдийн эрх ашгийг урьтал болговол зохино.

1.1.5. ИТХ-ын хуралдаан

Хуралдаан нь нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь юм. Нутгийн өөрөө удирдах байгууллага нь хамтын шийдвэр гаргадаг этгээд болохынхоо хувьд хуралдах нь түүний шийдвэрээ гаргах үндсэн арга бөгөөд нийт төлөөлөгчдийн олонх нь хуралдаанд оролцсоноор хүчин төгөлдөр болж (өөрөөр хэлбэл, шийдвэр гаргах хууль ёсны бүрэлдэхүүн бүрдэж) шийдвэрээ гаргадаг байна. Нутгийн өөрөө удирдах байгууллагын шийдвэрийг хэн нэгэн этгээд, түүний дотор ИТХ-ын дарга, төлөөлөгч дангаараа буюу хэсэг бүлгээрээ төлөөлөн гаргах эрхгүй бөгөөд хуулийн дагуу иргэдээс сонгогдсон бүрэлдэхүүн хуралдаж байж, сая шийдвэр гаргах эрх нь үүсдэг.

Хуралдаанаар тухайн Хурлын эрх хэмжээнд хамаарах бүхий л асуудлыг, түүний дотор тухайн Хурлын Тэргүүлэгчдийн бүрэн эрхэд хамаарах асуудлыг ч хэлэлцэн шийдвэрлэж болно. Хурлын эрх хэмжээнд хамаарах бүхий л асуудал гэдэгт хуулиар заасан Хурлын бүрэн эрхээс гадна хуулиар хориглоогүй болон бусад байгууллага, албан тушаалтны бүрэн эрхэд хамааруулаагүй асуудлаас бусад асуудлыг ойлгоно.

Тэргүүлэгчдийн бүрэн эрхэд хамаарах асуудал нь ч тухайн Хурлын хуралдаанаар хэлэлцэж болох асуудалд хамаарна. Учир нь Тэргүүлэгчид нь зөвхөн Хурлын хуралдааны чөлөө цагт бүрэн эрхээ хэрэгжүүлж, нутгийн өөрөө удирдах байгууллагын үүргийг гүйцэтгэдэгт оршино.

Хуралдааныг тухайн Хурлын дарга удирдан явуулна. Хурлын даргын түр эзгүйд аль нэг Тэргүүлэгч удирдан явуулахаар хуулинд заасан. Харин чухам аль Тэргүүлэгч удирдах учиртайг Хурал өөрөө тогтоох учиртай. "Өөрөө" гэсний учир нь хуулиар бус, нутгийн өөрөө удирдах байгууллага журамлан зохицуулах нь зүйтэй гэсэн үг. Хэрхэн зохицуулах нь тухайн Хурлын өөрийнх нь асуудал мөн боловч хуулийн хүрээнд зохицуулах хэд хэдэн боломж байгааг энд хөрвүүлбэ. Нэгд, Хурлын дарга түр эзгүйд хуралдааныг зохион байгуулах нь тодорхой болбол Тэргүүлэгчдийн хурлаар урьдчилан хэлэлцэж, аль нэг Тэргүүлэгчийг хуралдаан даргалуулахаар томилж байхаар тогтоож болно. Хоёрт, Хурлын дарга хүрэлцэн ирээгүй тохиолдолд хуралдааны эхэнд аль нэг Тэргүүлэгчийг хуралдаан даргалуулахаар нийт төлөөлөгчдийн ердийн олонхийн саналаар сонгож байхаар тогтоож болно. Гуравт, Хурлын даргыг орлон ажиллах нэг Тэргүүлэгчийг байнга ажиллуулахаар Тэргүүлэгчдийн шийдвэрээр буюу Хурлын шийдвэрээр томилж болно. Гэвч энэ нь төсөв санхүүгийн утгаараа ч (орлогчид ажлын хөлс, урамшуулал олгох хэрэгцээ гарна), ёс зүйн утгаараа ч (Тэргүүлэгчид дундаас бас нэгэн илүү "эрхтэй" хүн гарч ирнэ) шууд аваад хэрэгжүүлчихмээр сайхан санаа биш юм.

Анхдугаар хуралдааныг тухайн Хуралд сонгогдсон нийт төлөөлөгчдийн насаар хамгийн ахмад нь даргалах учиртайг хуулинд заасан. Харамсалтай нь хэд хэдэн аймаг, сумын ИТХ энэхүү хуулийн заалтыг зөрчиж, Хурлын даргаа сонгомогц шинэ дарга нь хуралдааныг удирдан явуулж байсан тохиолдол бий.

"Хуралдаан даргална" хэмээх үүрэг нь хамтын шийдвэр гаргадаг байгууллагын хувьд онцгой үүрэг бөгөөд юуны өмнө шийдвэр гаргах үйл явцыг хууль болон холбогдох бусад эрхийн акт (тухайлбал, Хуралдааны дэг)-ын хүрээнд удирдан явуулах, хэлэлцүүлэг, санал хураалтыг удирдах, хуралдааны дэг сахиулах ажил үүнд хамаарна. Энд "даргалах" хэмээх үүрэгт "өмнөөс нь шийдвэр гаргах" үүрэг огт хамаарахгүй. Харин хууль дээдлэх, цөөнхийг сонсох, зарчимч, шударга байхыг шаардана.

Хуралдааныг хуулиар тогтоосон хэм хэмжээний хүрээнд, тухайн Хурлаас тогтоосон "Хуралдааны дэг"-ээр хуралдааныг явуулна. Хуралдааны дэг нь хуралдааны үед үүсэх эрх зүйн харилцааг зохицуулах баримт бичиг юм. Хуралдааны дэгийг өөрийн онцлогийг тусган тухайн Хурал өөрөө тогтоож мөрдөнө. Дэг боловсруулахдаа хуулийн заалтыг хуулж бичих бус, харин тухайн хуулийн хүрээнд дэлгэрүүлж, тодорхой болгох замаар хуралдааныг аливаа саадгүй явуулах боломжийг бүрдүүлэхэд анхаарах учиртай. Өөрөөр хэлбэл, дэг нь ямагт "онгойлгоод гарч болох гарц" байх ёстой.

1.1.6. ИТХ-ын ажлын алба

ИТХ-ын ажлын алба нь Хурлын өдөр тутмын үйл ажиллагаанд бүх талын дэмжлэг үзүүлж, хэвийн явагдах нөхцөлийг хангах үүрэг бүхий Хурлын бүтцийн байнгын нэгж юм. Өмнө дурдсан зохион байгуулалтын үндсэн 5 хэлбэрээс ялгарах гол шинж нь ажлын алба бол Хурлын үндсэн нэгж гэдэгт оршино. Ажлын албаны үндсэн чиг үүрэгт:

- ИТХ-ын дарга, Тэргүүлэгчдийн өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн явуулахад туслах, дэмжлэг үзүүлэх, мэдээллээр хангах;
- ИТХ-ын төсөв санхүүг захиран зарцуулах;

- ИТХ-ын шийдвэрийн төсөл боловсруулах, ИТХ-ын болон Тэргүүлэгчдийн хуралдааны бэлтгэл ажил хангах ажлыг зохион байгуулах, хэлэлцэх асуудалтай холбоотой асуудлаар мэдээлэл цуглуулах, боловсруулалт хийх, хууль эрх зүйн лавлагаа гаргах, нийгэм, эдийн засгийн тооцоо гаргах;
- ИТХ-ын албан хэргийг хөтлөн явуулах, архив, бичиг хэргийн ажил үүрэг;
- ИТХ-ын шийдвэрийг түгээх, сурталчлах, нийтэд мэдээлэх, хэрэгжилтийг тооцох ажлыг зохион байгуулах;
- ИТХ-ын нэрийн өмнөөс байгууллага, албан тушаалтан, иргэдтэй харилцах, мэдээлэл түгээх, цуглуулах, боловсруулалт хийх;
- ИТХ-д хуулиар ногдуулсан бусад үүргээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг туслалцаа үзүүлэх;
- Иргэдийн санаа бодлыг судлах ажлыг зохион байгуулах, тэдгээрийг нэгтгэн боловсруулах, ИТХ ба Тэргүүлэгчдэд дүнг танилцуулах, холбогдох шийдвэр гаргуулах ажлыг зохион байгуулах зэрэг ажил хамаарна.

Энэ бүхнээс харахад өнөөгийн түвшинд ИТХ-ын ажлын албаны (ялангуяа сумдын ИТХ-ын ажлын албадын) бүтэц, орон тоо нь дээр дурдсан ажил үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай бус байгаа нь харагдаж байна. Ийм ч учраас сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга нар нь хийх ёстой ажлынхаа талыг ч хийх боломжгүй (физик болон физиологийн утгаараа) болдог тул ихэнх тохиолдолд шаардлагын түвшинд ажиллахгүй байх нь элбэг байна. Нутгийн өөрөө удирдах ёсыг төлөвшүүлэхийн тулд ИТХ-ын ажлын албаныг бэхжүүлж чадавхжуулах нь тун чухал билээ. Ялангуяа ИТХ-ын төлөөлөгчөөр сонгогдон ажиллаж байгаа төлөөлөгчдийн нутгийн өөрөө удирдах ёсны талаарх мэдлэг чадвар, туршлага хомс, үүний зэрэгцээ идэвх оролцоо сулхан байгаа өнөө үед ажлын албад нь хангалттай орон тоотой, мэдлэг чадвартай байх нь чухал билээ.

1.1.7. ИТХ-ын төлөөлөгч

Орон нутгийн Хурлын Төлөөлөгч нь юуны өмнө тухайн нутгийн иргэдийг төлөөлөх үүрэгтэй. Орон нутгийн хэмжээний бодлого, шийдвэрт иргэдийн санаа бодлыг тусгах, тэдний эрх ашгийг хамгаалах ажлыг төлөөлөгч гүйцэтгэнэ. Хэдийгээр өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөж байгаа хуулийн дагуу төлөөлөгч нь Хуралд улс төрийн тодорхой намыг төлөөлөх боловч үндсэн үүрэг нь өөрийг нь сонгосон нутгийн иргэдийг төлөөлөх явдал билээ.

Нутгийн иргэдийг төлөөлнө гэх энэхүү хүндтэй үүрэгт ихээхэн хэмжээний хичээл зүтгэл, идэвх санаачлага хамаарах бөгөөд зүгээр ч нэг ард түмний нэрийн өмнөөс “цээжээ дэлдэн” хоосон ярих явдал үүнийг хэлж байгаа хэрэг биш юм. Иргэдийг төлөөлөх гэдэгт юуны өмнө тэднийг сонсох явдал хамаарна. Иргэдийг сонсохгүйгээр тэдний өмнөөс Хурал дээр тэдний санаа бодлыг хэрхэн дамжуулах вэ? Сумдын ИТХ-ын дарга нартай уулзаж ярилцаж байхад иргэдийн санаа бодлыг судлан нэгтгэж, ИТХ-ын хуралдаан дээр танилцуулах ажлыг санаачилсан төлөөлөгч гарахгүй байгааг тэд хүлээн зөвшөөрч байсан. Иргэдийг сонсох ажлыг хэд хэдэн хэлбэрээр зохион байгуулж болох юм. Үүнд:

- *Иргэдийн цуглаан зохион байгуулах:* Ойролцоо нутаглаж буй малчид, эсвэл хот суурин газарт нэг гудамж, байранд оршин суугчдыг тусгайлан зар түгээж, хэсэгчлэн цуглуулан тодорхой сэдвээр ярилцлага зохион байгуулж болно. Ярилцах сэдэв, цуглах өдөр, цаг, газраа урьдчилан зарлахын зэрэгцээ өөрөө ч тухайн сэдвээр ярих, бусадтай санаа бодлоо солилцох, Хурлын үйл ажиллагааны талаар мэдээлэхэд бэлтгэх нь зүйтэй. Өнөөдөр тодорхой сэдвээр

иргэдийг цуглуулан санаа бодлыг нь сонсох, ярилцахад оролцооны асуудал хүндрэлтэй нь мэдээж байгаа ч тодорхой сэдвээр сонгогдсон тойрогтоо тогтмол иймэрхүү уулзалт зохион байгуулж хэвшвэл иргэдийн идэвх оролцоог нэмэгдүүлж болох юм. Гагцхүү иргэдээс гаргасан саналыг Хурлын шийдвэрт тусгуулах талаар санаа тавьдаг, энэ талаар иргэдэд эргэж мэдээлдэг, гарсан шийдвэрийг иргэдэд тайлбарладаг байж гэмээ нь энэ оролцоо нэмэгдэх билээ.

- *Иргэдээс санал асуулга авах:* Өөрийн сонгогдсон тойрогтоо иргэдээс тусгайлан бэлтгэсэн асуулгаар тодорхой асуудлын хүрээнд саналыг нь авч болох юм. Иймэрхүү асуулга нь иргэдээс нэг их цаг зарцуулалгүйгээр саналаа өгч болох оролцооны хялбар арга боловч асуулгын боловсруулалтын түвшин, хамрах хүрээ, цуглуулсан мэдээллийн боловсруулалт зэргээс шууд хамааралтай учир үр дүн нь бодит байдлаас зөрөөтэй гарах нь бий. Энэ аргыг Хурлаар хэлэлцүүлэхээр санаачилж байгаа асуудлыг боловсруулахад юм уу, эсвэл Хурлаар хэлэлцэхээр төвлөсөн асуудлаар өөрийн саналаа бэлтгэхэд ашиглах нь тохиромжтой юм.
- *Иргэдтэй уулздаг байр бэлтгэж, тогтмол өдөр, цагт уулздаг байх:* Иргэдийн санаа бодлыг ямар нэгэн шүүлтүүргүй сонсож, тухайн асуудлаар өөрийн саналаа харилцан ярилцах, түүнчлэн Хурлын үйл ажиллагааг ч сурталчлахад тохиромжтой нэг арга нь энэ юм. Заавал долоо хоног бүр биш юмаа гэхэд сард нэгээс хоёр удаа тодорхой цаг гарган иргэдийг хүлээн авч уулзах хуваарь гарган зарлахаас энэ ажлыг эхлэх нь зүйтэй. “Хүн ирэхгүй байна” гэсэн шалтгаанаар өөрөө уулзалтад ирэхгүй байх нь цаашид нь энэ ажлыг унтраах үндэслэл болно. Уулзах газраа тогтмол цагт байж, нэг хүн ирсэн ч Хурлын болон өөрийн үйл ажиллагааны талаар мэдээлдэг, тухайн хүний санаа бодлыг хүндэтгэн сонсдог, тухайн асуудлаар Хуралд асуудал санаачилдаггүй юм аа гэхэд тодорхой албан тушаалтанд асуулга тавих, саналаа холбогдох байгууллага, албан тушаалтанд бичгээр илгээх зэргээр иргэн хүнд туслахыг хичээдэг байх нь оролцоог нэмэгдүүлэх гол хүчин зүйл болох билээ.
- *Баг, хорооны ИНХ-ын хуралдаанд оролцож, иргэдийн санаа бодлыг сонсох:* Баг, хорооны ИНХ-ын хуралдаанд оролцох нь зардал багатайгаар иргэдийг сонсох, түүний зэрэгцээ боломж олдвол санаа бодлоо ч илэрхийлэх хялбар арга юм. Баг, хорооны ИНХ-ын хуралдаанаар хэлэлцсэн асуудлаар тодорхой баримт бичгийн төсөл боловсруулж, ИТХ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэж болох юм.

Үүний зэрэгцээ ИТХ-ын төлөөлөгч нь Хурлын үйл ажиллагаанд идэвхтэй оролцох үүрэгтэй. Харамсалтай нь ИТХ-ын төлөөлөгчид, нутгийнхаа иргэдийг төлөөлөн шийдвэр гаргахад оролцох үүргээ умартан асуудалд намын байр сууринаас хандах явдал цөөнгүй байсаар байна. “Цөөнх болсон” гэх шалтгаанаар хуралдаандаа ч оролцдоггүй, “олонх болсон” гэх шалтгаанаар цөөнхөө сонсохыг ч хүсдэггүй, “эрх мэдэл байхгүй” гэх шалтгаанаар зоригтой шийдвэр гаргадаггүй, “урамшуулал байхгүй” гэх шалтгаанаар асуудал санаачлан хэлэлцүүлдэггүй байх нь Хурлын төлөөлөгч үндсэн үүргээ биелүүлэхгүй байгаагийн илрэл юм.

Идэвхтэй оролцоо гэдэгт хуралдаанд оролцож, үг хэлэх, саналаа илэрхийлэх, асуулт асуухаас гадна дангаараа буюу төлөөлөгчидтэй хамтран асуудал хэлэлцүүлэхээр санаачлах, Хурлын хорооны бүрэлдэхүүнд ажиллах, Хурлаас байгуулсан түр хороо, ажлын хэсэгт ажиллах, Хурлын үйл ажиллагааны талаар байгууллага, албан тушаалтан,

иргэдэд мэдээлэл хийх, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр Хурлын үйл ажиллагааны талаар болон өөрийн саналын талаар мэдээлэл хийх, тодорхой байгууллага, албан тушаалтнаас асуулга авах, өөрийн эрх хэмжээний хүрээнд хяналт шалгалт хийх, шаардлага тавих, үүрэг өгөх, өөрийн саналаа холбогдох дээд байгууллагад илгээх зэрэг хамаарна.

Нутгийн өөрөө удирдах байгууллагын идэвхтэй үйл ажиллагаа, цаашилбал нутгийн өөрөө удирдах ёсны хэрэгжилт ИТХ-ын төлөөлөгчийн үйл ажиллагаанаас хамааралтай.

1.2. ХЭЛЭЛЦҮҮЛЭГ. ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР: ПРАКТИКТ ГАРЧ БУЙ ЗӨРЧИЛ, ШИЙДЭЛ

Хэлэлцүүлгийн удирдамж

Лекцийн явцад хөндөж ярьсан сэдвийн хүрээнд (тухайлбал, төлөөлөгч бие даан асуудал санаачлан өргөн мэдүүлэх, Тэргүүлэгчдээр хэлэлцүүлэх, хороод хэлэлцэж, санал дүгнэлт гаргах, хуралдаанаар хэлэлцэх дараалал гэх мэт) ангид нээлттэй хэлэлцүүлэг явуулна. Эхлээд яриа өдөхийн тулд багшаас зарим нэг тодруулах хэлбэрийн асуулт асууж болох юм. Тухайлбал,

- Бүрэн эрхийнхээ хугацаанд асуудал санаачлан өргөн мэдүүлсэн төлөөлөгчдийн талаар;
- Хороод хуралдаанаар болон Тэргүүлэгчдээр хэлэлцэх гэж байгаа асуудлыг хэлэлцэж, санал дүгнэлт боловсруулж байгаа туршлага;
- Тэргүүлэгчдээр болон хороод, намын бүлгээр хэлэлцэх үед үүсдэг зөрчил, түүнийг шийдсэн тухай жишээ;
- Хурлаас гаргасан дүрэм, журам, бусад шийдвэрийг хүчингүй болгосон тохиолдол, түүний учир шалтгаан

Хэлэлцүүлгийг явуулахдаа оролцогчдоос бусдыг сайн сонсох, хүлээцтэй хандахыг шаардах бөгөөд зэрэгцэж ярих, бусдын санаа бодлыг шууд үгүйсгэх, бусдын санаа бодолд хүндэтгэлгүй хандах, намын харьяалал, үзэл бодол, гарал үүсэл, нас, хүйс, боловсролоор нь ялгаварлахгүй байхыг анхааруулах хэрэгтэй.

Оролцогчдыг яриулахдаа тодорхой дараалал, хугацаатайгаар яриулах нь зөв болно. Хэлэлцүүлгийг явуулахдаа дараалал, хугацааг чанд мөрдөхөд тус болох сургалтын арга ашиглаж болно. Тухайлбал, жижиг зөөлөн тоглоом, бөмбөгийг хамгийн эхний хүнд өгөөд яриад дуусмагц дараагийн хүндээ шилжүүлдэг байх, ярих хугацааг мөрдүүлэхдээ жижиг элсэн цаг ашиглах гэх мэт.

Хэлэлцүүлэг учир багшаас асуулт асуух нь зохимжгүй. Гэхдээ тодорхой шийдэл буюу зөв, бурууг ялгах нь хэлэлцүүлгийн нэг үр дүн болох учир хэлэлцүүлгийн төгсгөлд багшаас хэлэлцүүлгийн явцад гарсан шийдэгдээгүй жишээ, тохиолдлын талаар өөрийн санаа бодол буюу шийдлийн хувилбарыг хэлж болно.

Нэмж судлах эх сурвалж

- Монгол Улсын Үндсэн хууль – www.legalinfo.mn
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль – www.legalinfo.mn
- Я.Бямбаяр, О.Тунгалаг “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, төлөөлөгч хэрхэн ажиллах вэ?”, УБ. 2011, Бүлэг 2
- Я.Бямбаяр “Тэргүүлэгчид: Социализмаас уламжилсан гажиг уу?”, Төрийн захиргаа сэтгүүл, 2013, №3

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЛЭЭ

Сургалтын зорилго: Иргэдийн Хурлын Төлөөлөгч хууль тогтоомжид заасан бүрэн эрхээ хэрэгжүүлж хуульд үндэслэсэн, бодит нөхцөл байдлыг тогтоосон шийдвэр гаргахад нь туслах хууь хэрэглээний чадвар эзэмшүүлнэ.

Хүрэх үр дүн: ИТХ-ын шийдвэрт иргэний оролцоо сайжрах, хууль зөочихгүй байх, нөхцөл байдлыг судалгаа, шинжилгээнд тулгуурлан тогтоох, ингэснээр хууль, бодлогын шийдвэр хэрэгжиж, улс орны хөгжил, иргэдийн амьдралд эерэг үр дагавар үүснэ.

Хүснэгт 2.2. Хичээл зохион байгуулах төлөвлөгөө

№	Агуулга	Сэдэв	Сургалтын арга	Цагийн хуваарилалт	Сургалтын хэрэглэгдэхүүн
1	Хууль зүйн техникийн тухай ойлголт	Хууль бүтээх ба хууль хэрэгжүүлэх хууль зүйн техник	лекц	20 минут	Лекцийн слайд, компьютер, проектор
2	ИТХ- Үндсэн хуулийн байгууллага болох нь	Монгол улсын Үндсэн хуулийн 62.2	лекц	20 минут	Лекцийн слайд, компьютер, проектор
		Бие даасан хэм хэмжээний акт гаргах	лекц	30 минут	Лекцийн слайд, компьютер, проектор
			Хэлэлцүүлэг	40 минут	Чиглүүлэх асуулт, дэлгэц цаас, үзэг
3	ИТХ-Захиргааны байгууллага болох нь	Захиргааны шийдвэр гаргах ажиллагаа	лекц	20 минут	Лекцийн слайд, компьютер, проектор
			Тохиолдол шинжлэх	20 минут	Дасгалын аргачлал, жишээ, дэлгэц цаас, үзэг
		Захиргааны хэм хэмжээний акт гаргах	лекц	30 минут	Лекцийн слайд, компьютер, проектор
			Хэм хэмжээний актын төсөл бичих даалгавар өгөх	40 минут	Дасгалын аргачлал, жишээ, дэлгэц цаас, үзэг
	Багшийн дүгнэлт			10 минут	
	Нийт			230 минут	

2.1. ХУУЛЬ ЗҮЙН ТЕХНИКИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ

Нийгмийн харилцааг зохицуулж буй хамгийн дээд хүчин чадалтай хэм хэмжээ бол эрх зүйн хэм хэмжээ юм. Эрх зүйн хэм хэмжээ нь хууль, УИХ-ын бусад шийдвэр (хууль тогтоомж гэж нэрлэдэг), мөн хуулиар эрх олгогдсон захиргааны байгууллагын хэм хэмжээ тогтоосон актаар илэрхийлэгддэг. Эрх зүйн хэм хэмжээг хууль зүйн техникийн тусламжтайгаар бүтээж, хэрэгжүүлнэ.

Хууль зүйн техник бол хууль зүйн шинжлэх ухааны харьцангуй шинэ салбар юм. Хууль зүйн техникийн явцуу хандлага эхлээд тогтсон. Үүнийг баримт бичгийн хандлага гэж нэрлэж болно (Кашанина. Т.В, 2016). Гэхдээ хууль баримт бичгийн стандартыг төгс хангасан гээд нийгмийн харилцааг төгс зохицуулж чадна гэсэн үг биш. Жишээлбэл, Хамтын тэтгэврийн тухай хуулийг (хүчингүй болсон) баталсны дараа уламжлал, соёлд нийцэхгүй байна гэсэн үндэслэлээр ахмад настнууд эсэргүүцэж байсан. Энэ хуулийг хэм хэмжээнд заасан журмынх нь дагуу эрх бүхий байгууллага баталсан байхад яагаад иргэд хүлээж авсангүй вэ?

Өнөөдөр ихэнхи хууль, захиргааны хэм хэмжээний болон захиргааны акт нь шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулагддаггүй, социологийн судалгаагүй, олон нийтийн оролцоог хангахгүй гарч байна. Энэ нь хууль, шийдвэрийн хэрэгжилтэнд сөргөөр нөлөөлж, нийгэм зохион байгуулалтгүй байх, иргэдийн ухамсар, соёлын хөгжил доогуур түвшинд байхад хүргэдэг. Иймд шийдвэр гаргагч нь хууль бүтээх, хэрэгжүүлэхийн тулд бодит нөхцөл байдлыг судлах, шийдвэр гаргахын эерэг нөлөөллийг шинжлэх ухааны үндэслэлтэй нотлох, шийдвэрт хамаатай хүмүүсийн саналыг сонсох зэрэг ажлуудыг хийх хэрэгтэй. Харин хууль зүйн техник энэ үйл явцыг журамлаж, тодорхой логик уялдааг ханган хэлбэржүүлэх ажиллагаа юм. Мэдээж баримт бичгийн стандартыг хангах ажиллагаа зайлшгүй хийгдэнэ. Товчхондоо, хууль зүйн техник гэдэг бол эрх зүйн актын агуулга ба бүтцийг боловсруулах, тэдгээрийг амьдралд хэрэгжүүлэхэд хэрэглэгддэг тодорхой арга, хэрэглүүр, журмын нийлбэр цогц (Нарангэрэл. С, 2011).

Эрх зүйн хэм хэмжээг бүтээх, хэрэгжүүлэхэд хууль зүйн техникийн ерөнхий дүрэм буюу агуулга тодорхой байх нь хууль, шийдвэрийн хэрэгжилтэнд чухал ач холбогдолтой. Хууль зүйн техникийн агуулга нь дараах зурагт үзүүлсэн журмуудаас бүрдэнэ.

Зураг 2.2. Хууль зүйн техникийн ерөнхий дүрэм



- Агуулгын дүрэм бол хууль санаачлагч, шийдвэр гаргагч нь тухай эрх зүйн хэм хэмжээг бүтээх, хэрэгжүүлэхийн зорилго, хүрэх үр дүн, зайлшгүй батлах хэрэгцээ шаардлага зэргийг тодорхойлох явдал юм. Жишээлбэл: ижил хүйстнүүдийн гэрлэлтийг зөвшөөрөх зайлшгүй нөхцөл байдал үүссэн гэдгийг хууль зүйн техникийн үүднээс шийдвэр гаргагч нотолж, нийтэд мэдээлэх үүрэгтэй (нотолгоонд социологийн судалгаа, хүний эрхийн зөрчлүүдийг тоо баримттай гаргах гэх мэт).
- Логик уялдааг хангах дүрэм нь нэр томъёог нэгдмэл, тогтсон байдлаар ойлгох (жишээлбэл, эрх зүйн бүрэн чадамжтай иргэн гэдэгт 18 насанд хүрсэн, сэтгэцийн хувьд өөрийгөө бүрэн жолоодож чадах чадвартай хүнийг хэлдгийг шууд ойлгох), эрх зүйн хэм хэмжээний хийдэл, зөрчил, давхардлыг арилгах, шалтгаан, үр дагаврын хоорондын хамаарлыг олж тогтооход чиглэгдэнэ. Жишээлбэл: үерийн аман дээр буусан айлыг албадан нүүлгэж болно гэсэн заалт нь хоёрдмол утга буюу нүүлгэхгүй ч болно гэсэн ойлголтыг иргэдэд төрүүлнэ. Нэгэнт иргэд ингэж ойлгоод нүүхгүй байсаар амь нас, өмч хөрөнгөө эрсдэлд оруулдаг.
- Бүтцийн дүрэмд эрх зүйн хэм хэмжээний бичгийн дотоод зохион байгуулалтыг тусгадаг. Эрх зүйн хэм хэмжээг бүтээх, хэрэгжүүлэх баримт бичгийн үндсэн хэлбэр нь оршил, үндсэн, төгсгөлийн хэсгээс бүтдэг.
- Хэл зүйн дүрэм: эрх зүйн хэм хэмжээг хэлээр дамжуулж хүмүүсийн ухамсарт нөлөөлөн тодорхой зан үйл хийхийг шаарддаг. Жишээлбэл: удаа дараа ажил таслах гэсэн заалт байвал дундаж боловсролтой хүний ойлголтоор 2-ээс дээш удаа гэж шууд ойлгоно.
- Хэлбэржүүлэлтийн дүрэм бол хууль, шийдвэрийг батлах, ёсчлох, нийтлэх үйл явцыг тусгана.
- Ажиллагааны дүрэм бол хууль, шийдвэрийн хэрэгжилтийн үр дагаврыг хэрхэн тооцох журам юм. Батлагдсан хууль, шийдвэр нь амьдралд нийцэхгүй, бусад хуультай зөрчилдөж байгааг нээн илрүүлэх ажиллагаа гэж хэлж болно.
- Хууль зүйн техникийг дотор нь хууль бүтээх ба хууль хэрэгжүүлэх гэж хоёр хуваадаг.

2.1.1. Хууль бүтээх хууль зүйн техник

Хууль бүтээх хууль зүйн техникийн хувьд Хууль тогтоомжийн тухай хуулиар зохицуулж өгсөн.

Зураг 2.3. Хууль бүтээх ажиллагаан дах хууль зүйн техникийн агуулга



2.1.2. Хууль хэрэгжүүлэх хууль зүйн техник

Хууль хэрэгжүүлэх гэдэг нь тогтоосон эрх зүйн хэм хэмжээг (хууль, захиргааны хэм хэмжээний акт) эрх бүхий байгууллага үйл ажиллагаандаа баримтлахыг хэлнэ. Тодруулбал, хууль биелүүлэх буюу хэрэгжүүлэх (хууль хэрэглэх гэж ч нэрлэдэг) гэдэг нь хуулиар эрх олгосон эрх зүйн хэм хэмжээний заалт (хуулийн заалт), зарчмыг удирдлага болгон хууль зүйн тодорхой асуудлыг шийдвэрлэхийн тулд эрх зүйн шийдвэр гаргахад чиглэгдсэн ажиллагаа юм (Лүндээжанцан. Д, 2017).

Зураг 2.4. Хууль хэрэгжүүлэх буюу захиргааны шийдвэр гаргах ажиллагаан дахь хууль зүйн техникийн агуулга



2.2. ИТХ- ҮНДСЭН ХУУЛИЙН БАЙГУУЛЛАГА БОЛОХ НЬ

2.2.1. Монгол Улсын Үндсэн хуулийн 62.2

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр хэрэгжинэ гэж Үндсэн хуульд зааж өгсөн нь ИТХ-ыг Үндсэн хуулийн байгууллага мөн болохыг баталж байна. Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээний асуудлыг дээд шатны байгууллага нь шийдвэрлэж үл болно гэж Үндсэн хуулийн 62.2-д заасан.

ИТХ-ын эрх хэмжээний асуудал гэж юу вэ? Эрх хэмжээ гэдгийг судлаачид олон янзаар тодорхойлж өгсөн. Нийтлэг ойлголтоор хуульд заасан бүрэн эрх гэж хэлж болно.

Монгол улсад хүчин төгөлдөр үйлчилж буй 600 гаруй хуулиас ИТХ-ын бүрэн эрхийг хуульчилсан 90 хууль байна. ИТХ-ын төлөөлөгчдийн эрх, үүрэгтэй холбоотойгоор нийтлэг чиг үүргийг МУЗЗНДНТУТХ-д зааснаар ангилав. Үүнд:

- хурлын зохион байгуулалт, хяналт шалгалтын талаар
- нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн талаар
- орон нутгийн өмчийн талаар,
- нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний акт гаргах болно.

Дээд шатны байгууллага гэдэгт Төрийн эрх мэдэл хуваарилах зарчмаар бол УИХ, Засгийн газар, Шүүх, Үндсэн хуулийн Цэц, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн дагуу хуваарилагдсан дээд шатны Хурлууд орно. Жишээ: баг, хорооны Хуралдаанаар гаргасан шийдвэрт сум, дүүргийн Хурал нөлөөлөхгүй юм. Хэрэв Хурлаас гаргасан тогтоол, бусад шийдвэр нь хууль тогтоомж, Засгийн газар, тухайн асуудлыг харьяалах дээд шатны байгууллагаас гаргасан шийдвэрт нийцээгүй бол түүнийг тухайн Хурал өөрчлөх буюу хүчингүй болгоно (Нэгжийн тухай хуулийн 25.4).

2.2.2. Бие даасан хэм хэмжээний акт гаргах

Төрийн эрх мэдэл хуваах онолын дагуу зөвхөн УИХ-аас хууль буюу эрх зүйн хэм хэмжээ гарах ёстой. Гэвч хууль батлах үйл ажиллагааны олон үе шаттай, нийгэмд гарсан асуудлыг түргэн шийдвэрлэхэд хугацаа алддаг тул эрх зүйн хэм хэмжээ тогтоох эрхийг эрх бүхий байгууллагуудад *хуулиар* олгодог. Улсын Их Хурал, Засгийн газраас шаардлагатай хэмээн үзсэн тохиолдолд өөрийн бүрэн эрхэд хамаарах зарим асуудлыг шийдвэрлүүлэхээр аймаг, нийслэлийн Хурал, Засаг даргад шилжүүлж болно (Үндсэн хуулийн 62.3, 1992).

Эрх шилжүүлэн авсан байгууллага захиргааны хэм хэмжээний акт гаргана. Захиргааны хэм хэмжээний актыг хуулийг нөхөн гүйцээсэн хэм хэмжээний акт ба хуулийг хэрэгжүүлэх хэм хэмжээний акт гэж ангилдаг (П.Одгэрэл, 2016). Тодруулбал, захиргааны хэм хэмжээний актыг батлан гаргаж буй субъектээр нь 1. Хуулиар тусгайлан эрх шилжүүлсний үндсэн дээр гаргасан хэм хэмжээний акт, 2. Бие даан гаргасан хэм хэмжээний акт 3. Захиргааны дотоод журам гэж ангилж болно. Бие даасан хэм хэмжээний актыг гаргахад салбар мэргэжлийн хуулиар тусгайлан эрх олгосон байх шаардлагыг тавьдаггүй (Одгэрэл, П, 2016).

Монгол улсын Үндсэн хуулийн 62.2-т “..Хэрэв нутаг дэвсгэрийн амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэх талаар хууль, төрийн зохих дээд байгууллагын шийдвэрт тухайлан заагаагүй бол нутгийн өөрөө удирдах байгууллага Үндсэн хуульд нийцүүлэн бие даан шийдвэрлэж болно.” гэж заасан нь ИТХ-ын Үндсэн хуулиар олгогдсон бүрэн эрх юм. нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудал юм. Эндээс нутаг дэвсгэрийн амьдралын тодорхой асуудал гэж юу вэ? гэсэн асуулт гарч ирнэ.

Энэ нь өргөн хүрээний шууд тоочих боломжгүй нийгмийн харилцаа юм. Тухайн цаг үед бий болсон асуудлыг шинжилж үзээд хуулиар зохицуулсан байна уу үгүй юу гэдгийг ИТХ тогтооно. Жишээ нь:

Нэгэн ИТХ-д иргэдийн зүгээс оршуулгын зан үйлтэй холбоотой асуудлыг зохицуулахгүй бол сөрөг үр дагавар үүсч байна гэсэн хүсэлт өргөдөл ирсэн байна. Уг асуудлыг шийдвэрлэхдээ нутаг дэвсгэрт нь оршин суудаг тодорхой ястан бүлэгт хамаарах иргэдийн уламжлагдан ирсэн оршуулгын зан заншлыг хориглосон агуулга бүхий тогтоол гаргажээ.

Энэ шийдвэрт дүн шинжилгээ хийх замаар хууль зүйн техникийг ашиглаж зөвлөмж өгье.

Уг хүсэлтийг хүлээн аваад ИТХ дараах алхмуудыг хийж шийдвэр гаргана. Үүнд: Нэгдүгээр алхам: хуулиудыг эрэмбээр авч үзэх

1. Монгол улсын Үндсэн хууль
2. Оршуулгын зан үйлтэй холбоотой зохицуулалт байгаа эсэхийг өмнө нь дурдсан 660 гаруй хууль (www.legalinfo.mn-ээс харах), захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн санд бүртгэлтэй захиргааны байгууллагаас гаргасан актуудаас шалгана.
3. Ийнхүү шалгасны дараа хэрэв тухайн асуудлыг хуулиар, Засгийн газрын тогтоолоор зохицуулаагүй бол Хурал Үндсэн хуульд нийцүүлэн бие даан шийдвэрлэж болно. ИТХ тухайн нутаг дэвсгэртээ бие даасан захиргааны хэм хэмжээний акт гаргах эрхтэй. Тодруулбал, Монгол улсын Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24-т: Хуралд асуудал оруулах эрх, 23.14-т: Хуралдааныхаа дэгийг тухайн Хурал өөрөө тогтоож тогтоолоор батална, 25.4. Хурлаас гаргасан тогтоол, бусад шийдвэр нь хууль тогтоомж, Засгийн газар, тухайн асуудлыг харьяалах дээд шатны байгууллагаас гаргасан шийдвэрт нийцээгүй бол түүнийг тухайн Хурал өөрчлөх буюу хүчингүй болгоно гэсэн заалтууд нь ИТХ-ыг парламенттай адилтган үзэж байгаа юм. Сонгуулийн үр дүнд бий болдог байгууллага УИХ, ИТХ байдаг. Тиймээс Хурлын шийдвэр харьцангуй бие даасан байна.

Гэхдээ бие даан шийдвэр гаргахдаа хууль дээдлэх зарчмыг хэлбэрэлтгүй дагана. Энэ зарчмын гол шаардлага:

- Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид заасан заалтыг зөрчихгүй байх
- Үндсэн хууль болон бусад хууль тогтоомж нь хүний жам ёсны эрхийг хамгаалсан, шударга ёсыг тогтоосон зорилготой байх ёстой.

Хувь хүний болон нийгмийн үнэт зүйлсийг зөрчихгүй, уламжлал, шинэчлэлийг тэнцвэртэйгээр авч үзэх, хүйсийн тэгш бус байдлыг гаргахгүй байх зэргийг дурьдаж болно. Жишээбэл: орон нутагт амьдарч буй угсаатны зан заншил, хэл, соёлыг хүндэтгэх, гэхдээ Монгол улс нэгдмэл улс мөн тул улсын нийтлэг эрх ашиг, албан ёсны хэл болох монгол хэлний тухай хуулийг зөрчихгүй байх зэргийг тухай Хурал сайтар судалж, хангаж ажиллах үүрэгтэй. Иймд ИТХ бие даасан захиргааны хэм хэмжээний акт гаргахдаа хууль бүтээх хууль зүйн техникийг (Зураг 1-ээс харна уу) ерөнхийд нь баримтална. Ингэхдээ хууль бүтээх ажиллагааны хууль зүйн техникийн агуулга буюу ерөнхий дүрмийг Дэгд тодорхой заадаг. Гэхдээ ихэнхи ИТХ-ын Хуралдааны Дэгд хууль зүйн техникийн агуулгыг бүрэн зохицуулаагүй байна. ИТХ хууль бүтээх хууль зүйн техникийг ашиглаж гаргасан шийдвэрээ хууль гэж нэрлэхгүй, хуулиас давсан хэм хэмжээ тогтоохгүй гэдгийг хатуу ойлгох ёстой. Харин хуулийг хэрэгжүүлэхдээ холбоотойгоор гаргасан ИТХ-ын шийдвэр нь хууль хэрэгжүүлэх хууль зүйн техникийг баримтална (энэ тухай дараагийн сэдэвт авч үзнэ).

ДАСГАЛ 1*үргээжлэх хугацаа 40 минут*

Багш холбогдох мэдээлэл танилцуулсны дараа нутаг дэвсгэрийнхээ нийгэм – эдийн засгийн тулгамдсан асуудлуудыг хэрхэн шийдвэрлэж байна бэ? гэдгийг тодруулах зорилгоор дараах чиглэлээр хэлэлцүүлэг хийнэ. Үүнд:

- Орон нутагт хуулиар зохицуулаагүй нийгэм- эдийн засгийн асуудал байна уу?
- Уг асуудлаа Үндсэн хуулийн 62.2-т заасан үндэслэлээр шалгах
- Хэрэв бие даасан хэм хэмжээний актаар зохицуулна гэж үзсэн бол Хурал ямар үйл ажиллагаа явуулах вэ?

Аргачлал: Оролцогчид 4 хүнтэй нэг баг болно. Багууд хэлэлцүүлгийн сэдвийн хүрээнд асуудлаа дасгал ажлын цаасан дээр бичээд багаас нэг хүн гарч бусад багуудад танилцуулж тайлбарлана.

2.3. ИТХ-ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА БОЛОХ НЬ

ИТХ нь тухайн нутаг дэвсгэртээ нийгэм эдийн засгийн асуудлыг бие даан асуудлыг шийдвэрлэхээс гадна хууль тогтоомжийг хэрэгжүүлж, хэрэглэдэг байгууллага юм.

ИТХ-ын шийдвэр нь захиргааны хэм хэмжээний акт, захиргааны акт, захиргааны гэрээ гэсэн хэлбэртэй. Жишээлбэл, Агаарын тухай хуулийн 8.1.8-д “хот, тосгон, бусад суурин газрын агаарын бохирдлын хэмжээ, урьдчилсан мэдээг өдөр тутам нийтэд мэдээлэх нь ИХТ-ын бүрэн эрх юм. Энэ бүрэн эрхээ хэрэгжүүлэхийн тулд ИТХ захиргааны шийдвэр гаргах ажиллагаа буюу хууль хэрэгжүүлэх хууль зүйн техникийг ашиглана. Хууль хэрэгжүүлж шийдвэр гаргахдаа мөн дараах зарчмыг баримтална.

1. Тухайн захиргааны байгууллага зөвхөн хуульд заасан үндэслэлээр шийдвэр гаргах
2. Шийдвэр гаргахдаа хуульд заасан зарчмыг удирдлага болгох
3. Захиргааны хэргийг хянан шийдвэрлэх замаар хууль хэрэглэх

Тухайн захиргааны байгууллага зөвхөн хуульд заасан үндэслэлээр шийдвэр гаргах

ИТХ- нь хуульд үндэслэж шийдвэр гаргана. Эрх зүйн нийтлэг зарчмыг баримтлан захиргааны акт, захиргааны гэрээ, захиргааны хэм хэмжээний акт гаргахдаа баримтлах суурь хууль нь Монгол Улсын Үндсэн хууль байна. Түүнчлэн ИТХ- хууль хэрэгжүүлж шийдвэр гаргахад эрх зүйн эх сурвалжийн эрэмбийн хувьд суурь хууль нь Захиргааны ерөнхий хууль. Гэхдээ захиргааны шийдвэр гаргах ажиллагааг холбогдох салбарын хуульд нарийвчлан зохицуулсан бол Захиргааны Ерөнхий хууль үйлчлэхгүй юм. ИТХ-ын шийдвэр гаргах ажиллагааг ЗЗНДНТУТХ-д нарийвчилж заагаагүй тул Захиргааны Ерөнхий хуульд заасан журмыг Хурал баримтална. Мөн Хурал салбарын хуулийг хэрэглэж шийдвэр гаргах явцад бусад хуулийг зөрчих асуудал гарвал Монгол Улсын Иргэний хуулийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь заалтыг харгалзана. Өөрөөр хэлбэл, хууль зүйн хүчин чадлын хувьд адил хэм хэмжээнүүд хоорондоо зөрчилдвөл тухайн харилцааг илүү нарийвчлан зохицуулсан хуулийн хэм хэмжээг хэрэглэнэ.

Захиргааны байгууллага, албан тушаалтны тухайд зөвхөн батлагдсан хуулийг ёсчлон дагаж мөрдөхөөс гадна тэдгээрээс “хуулиар тодорхойлсон, хуулиар олгосон хүрээ хязгаарын дотор шийдвэр гаргах эрх хэмжээ”-ний хүрээнд үйл ажиллагаа явуулж,

шийдвэр гаргадаг. Захиргааны Ерөнхий хуулиар “хуулиар тодорхойлсон, хуулиар олгосон хүрээ хязгаарын дотор шийдвэр гаргах эрх хэмжээ”-ний хүрээнд шийдвэр гаргах харилцааг **сонгох боломж** хэмээн нэрлэж Захиргааны Ерөнхий хуулийн 42 дугаар зүйлд “Захиргааны байгууллагаас тодорхой асуудлыг шийдвэрлэхдээ хууль, захиргааны хэм хэмжээний актаар зөвшөөрөгдсөн боломжит хувилбаруудаас аль нэгийг нь хэрэглэх, эсхүл хэрэглэхгүй байхыг сонгох боломж” хэмээн тодорхойлсон. Жишээлэхэд, Зөвхөн Монгол Улсын Газрын тухай хуулийн заалтаас үзэхэд “болно” хэмээн Иргэдийн хуралд эрх олгосон заалт даруй 30 гаруй байна (Сүнжид. Д, 2016).

Мөн Хурал захиргааны хэм хэмжээний акт гаргахдаа Монгол Улсын ЗЗНДНТУТХ-ийн 20 дугаар зүйлийн 20.1.7, /20.1.7. хуульд өөрөөр заагаагүй бол нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн амьдралын тулгамдсан асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх/, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 /нийслэлд хэв журам сахиулах, хотын аж ахуй, оршин суугчдын нийгэм, соёлын асуудлаар нийтээр дагаж мөрдөх журмыг хууль тогтоомжид нийцүүлэн гаргаж, биелэлтэд хяналт тавих/ заалтуудыг удирдлага болгосон байх нь нийтлэг байгаа бөгөөд эдгээр нь тодорхой нэг асуудлаар жишээлбэл, газар өмчлөлийн талаар энэ хэмжээний зохицуулалт хийх эрхийг хуулиар тусгайлан олгогдсон зохицуулалт болж чадах эсэх нь маргаан” дагуулах үндэстэй (Сүнжид. Д, 2016). Жишээ нь: Х аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор “тус аймгийн нутаг дэвсгэрт хууль бусаар ашигт малтмал эрэх, хайх, олборлох зорилгоор болон эрх бүхий этгээдийн зөвшөөрөлгүйгээр бүх төрлийн металл хайгч, түүнтэй ижил төстэй багаж хэрэгслэл ашиглах, авч явахыг хориглосон” байна. Энэхүү шийдвэрийг гаргахдаа Монгол Улсын ЗЗНДНТУТХ-ийн 20 дугаар зүйлийн 20.1.3-д “нутаг дэвсгэртээ сахилга, дэг журмыг бэхжүүлэх ажлыг нэгдсэн удирдлагаар хангах”, 20.1.7-д “хуульд өөрөөр заагаагүй бол нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн амьдралын тулгамдсан асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх”, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 5-д төр нь байгаль орчныг хамгаалах чиг үүргээ хэрэгжүүлэхдээ “байгалийн нөөц, баялгийн халдашгүй байдлыг хангах” зарчмыг баримтална гэсэн зохицуулалтуудыг баримтласан байна.

Нэг талаас ашигт малтмал хайх, олборлох харилцааг тухайлсан хуулиар зохицуулж байгаа төдийгүй түүнд орон нутгийн захиргааны болон өөрөө удирдах ёсны байгууллагуудын эрх үүргийг тодорхойлсон байдаг. Нөгөө талаас, дээрх хуулийн заалтууд нь аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд “ашигт малтмал эрэх, хайх, олборлох” асуудлаар нийтээр заавал дагаж мөрдүүлэхээр хэм хэмжээний акт гаргах эрхийг тусгайлан олгосон байж чадахааргүй байна. Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1-д зохицуулсанчлан хэм хэмжээний акт гаргах эрх бүхий захиргааны байгууллагыг хязгаарлах боломжгүй бөгөөд харин хууль тогтоогч бүрэн эрхээ шилжүүлэхдээ аль байгууллагад, ямар харилцааг, хэр хэмжээнд зохицуулалт хийх талаар тодорхой заасан байхыг шаардсан байна. Ингэснээр дээр дурьдсан жишээ дэх хэм хэмжээний актууд шиг маргаантай байдал үүсгэхгүй байх боломж бүрдэх юм (Сүнжид. Д, 2016).

Шийдвэр гаргахдаа хуульд заасан зарчмыг удирдлага болгох

ИТХ нийтийн ашиг сонирхлыг илэрхийлсэн шийдвэр гаргахдаа юуны өмнө хууль дээдлэх зарчмыг ханган холбогдох хууль тогтоомжийг хэрэглэх нь ойлгомжтой. Энэ зарчмын хүрээнд захиргааны байгууллагын тухайд дараах шаардлага тавигддаг байна. Үүнд:

- Захиргаанаас хуулийг зөрчсөн ямарваа нэг үйлдэл хийхийг хориглоно.
- Захиргаанаас хуульгүйгээр дур мэдэн аливаа үйлдэл хийхийг хориглоно.
- Захиргаанаас хууль ёсны зорилгын үүднээс иргэний эрхэд шаардлагатайгаас илүү
- хэмжээгээр халдахыг хориглоно (Сүнжид. Д, 2016)

Харин үүний дараа гаргасан шийдвэрийнхээ үр нөлөө болон зорилгодоо хэрхэн амжилттай хүрэх эсэхээ урьдчилан тооцох ёстой. ИТХ-ын шийдвэр үр нөлөөтэй байхын тулд захиргааны байгууллага хяналт шинжилгээ, үнэлгээг заавал хийдэг байх ингэснээр нийгэм эдийн засгийг тогтвортой хөгжүүлэх, хүний эрхийг бодитой хангах баталгаа юм (Алтанзул. А, 2017). Өөрөөр хэлбэл захиргааны байгууллага албан тушаалтан аливаа шийдвэрийнхээ үр дагавар, үр нөлөөг тооцно гэсэн үг. Тухайлбал, ИТХ нь ЗЗНДНТУТХ-ийн 18.12.а-д “нутаг дэвсгэрийн хөгжлийн дунд хугацааны бодлого болон жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг батлах, тэдгээрт нэмэлт, өөрчлөлт оруулах”-даа Захиргааны Ерөнхий хуулийн 4.2.4-т заасан үр нөлөөтэй байх зарчмыг удирдлага болгох хэрэгтэй.

Захиргааны хэргийг хянан шийдвэрлэх замаар хууль хэрэглэх

Захиргааны байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагааг иргэн эс зөвшөөрвөл захиргаанд өөрт нь эсвэл дээд шатны байгууллагад гомдол гаргадаг. Хурлын шийдвэрийг иргэн эс зөвшөөрвөл Захиргааны Ерөнхий хуулийн 93.2-т зааснаар өөрт нь гомдол гаргана. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2002) гарснаас хойших 15 жилийн практикт ИТХ захиргааны хэргийн урьдчилан хянан шийдвэрлэх ажиллагааг хуульд заасан журмын дагуу явуулсан нь цөөн байна. ЗЗНДНТУТХ-ийн 25.4-д “Хурлаас гаргасан тогтоол, бусад шийдвэр нь хууль тогтоомж, Засгийн газар, тухайн асуудлыг харьяалах дээд шатны байгууллагаас гаргасан шийдвэрт нийцээгүй бол түүнийг тухайн Хурал өөрчлөх буюу хүчингүй болгоно” гэж заасан. Харин иргэний гомдлыг хүлээн авч Захиргааны Ерөнхий хуульд заасан журмаар иргэний гомдлыг хүлээн авч шийдвэрлээд гаргасан шийдвэрээ хүчингүй болгосон талаар нэгдсэн мэдээлэл байхгүй байна.

2.3.1. Захиргааны шийдвэр гаргах ажиллагаа

ИТХ- нь зөвхөн нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний акт гаргадаг бус нэг удаагийн тодорхой тохиолдыг зохицуулсан шийдвэр гаргадаг. Жишээлбэл: Засаг даргыг огцруулах гэх мэт. ЗЕХ-ийн 3-р бүлэгт захиргааны акт гаргах хууль зүйн техникийг “Захиргааны шийдвэр гаргах ажиллагаа” гэж томъёолж зохицуулсан. Захиргааны шийдвэр гаргах ажиллагаа гэдэг бол аливаа шийдвэр гаргахын өмнө урьдчилсан нөхцөл шаардлагыг шалгах, төсөл бэлтгэх, батлах үйл ажиллагаа гэж ойлгож болно. Тодруулбал, захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд оролцогч /13-р зүйл/-ийг тодорхойлох, захиргааны шийдвэр гаргах ажиллагааг эхлүүлэх, /22- р зүйл / нөхцөл байдлыг тогтоох /24- р зүйл/, ингэхийн тулд нотлох баримтыг цуглуулах /25 р зүйл/, ашиг сонирхол нь хөндөгдөх иргэдэд сонсох ажиллагаа /27-р зүйл/ явуулах зэрэг болно (Алтанзул. А, 2017).

Захиргааны байгууллага, албан тушаалтан шийдвэр гаргахаасаа өмнө оролцогч хэн байхыг тогтоож байх ёстой. Хуульд зааснаар тухайн захиргааны байгууллагад өргөдөл хүсэлт тавьсан этгээд, захиргааны акт, захиргааны гэрээний эрх зүйн үйлчлэл шууд болон шууд бусаар чиглэсэн этгээд болон захиргааны байгууллагаас шийдвэр гаргах ажиллагаанд татан оролцуулсан этгээдийг оролцогч байхаар зохицуулсан.

Өнөөдрийн практикт захиргааны байгууллагууд өргөдөл, хүсэлт гаргасан этгээдийн “асуудалд” хариу өгөх замаар захиргааны шийдвэр гаргах ажиллагааг эхлүүлэх нь түгээмэл байна (Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрт дүн шинжилгээ хийсэн судалгааны ажил, 2013).

Гэтэл захиргааны байгууллага хэдийгээр тухайн иргэний хүсэлтийг хүлээн авч шийдвэр гаргаж байгаа боловч уг шийдвэр нь захиргааны гэдгээрээ ямагт нийтийн шинжийг агуулж байдаг гэдгийг сайн ойлгодоггүй. Өөрөөр хэлбэл, гуравдагч этгээд, шууд бусаар эрх ашиг хөндөгдөж байгаа болон ирээдүйд хөндөгдөх этгээдэд захиргааны шийдвэрийн үйлчлэл хамаардаг гэсэн үг. Эдгээр оролцогчдыг захиргаа урьдчилж тогтоогоод шийдвэр гаргах ажиллагаанд оролцуулж, санал, тайлбарыг авах нь чухал юм. Захиргааны байгууллагууд энэ ажиллагааг хийхгүй байгаагаас шийдвэр гарсны дараа иргэд гомдол гаргаж, шүүхэд ханддаг явдал буурахгүй байна. Захиргааны байгууллага, албан тушаалтан ялангуяа эерэг нөлөөлөл бүхий акт гаргахдаа дээрх гурван оролцогчийг урьдчилан тогтоох шаардлагатай. Жишээлбэл: дэд бүтэцтэй холбоотой тусгай зөвшөөрөл олгох эерэг нөлөөлөл бүхий акт гаргахдаа гуравдагч этгээд хэн байхав, ирээдүйд уг тусгай зөвшөөрөл өгсний дараа ямар эерэг болон сөрөг үр дагавар гарах уу, хэний эрх ашиг хөндөгдөх боломжтой вэ гэдгийг тооцно гэсэн үг. Урьдчилан тогтоосны дараа оролцогчдод ЗЕХ-д зааснаар эрхийг хангах үүргийг захиргаа хүлээнэ. Захиргааны байгууллагын албан тушаалтан системтэй мэдлэгт тулгуурласан судалгааны баримт нотолгоонд гэхээсээ зөвхөн өөрийн ойлголтод тулгуурлан шийдвэр гаргаж байна. Захиргааны байгууллага бодит нөхцөл байдлыг тогтоох замаар хуульд нийцүүлж шийдвэр гаргахыг ЗЕХ хуулиар хуульчилсан. Иймд захиргааны байгууллага захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд хамаарах бодит нөхцөл байдлыг тогтооно. Тухайн захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд хамааралтай тохиолдол бүрийн үндэслэлийг захиргааны байгууллага нарийвчлан шинжлэн судлах үүрэгтэй бөгөөд оролцогчийн хувьд ач холбогдол бүхий нөхцөл байдлыг тогтооно. Ялангуяа нийтийн эрх ашгийг хөндсөн, эрхийг хязгаарласан, хориглосон шийдвэрүүдэд заавал бодит нөхцөл байдал тогтоогдсон байхыг шаардана. Шийдвэр гаргаж буй бодит нөхцөл байдалд, асуудлын агуулгыг хамаарсан шийдвэр гаргахдаа захиргаа зөвхөн өөрийн үзэмжээр, дур зоргоороо асуудлыг шийдэх бус, хуулийн эрх хэмжээний сонголтын хүрээнд зөв сонголт хийж шийдвэр гаргасан эсэх нь захиргааны шийдвэрийн үндэслэлээр тодорхой болох юм (Сүнжид. Д, 2016). Тиймээс бодит нөхцөл байдлыг тогтооход ач холбогдол бүхий шаардлагатай ажиллагаа хийх, нотлох баримтыг цуглуулах, үнэлэх үүргийг захиргааны байгууллага хүлээнэ. Нотлох баримтыг хуульд дараах байдлаар заасан. Үүнд:

1. ач холбогдол бүхий мэдээллийг цуглуулах;
2. оролцогчийг сонсох, тайлбар гаргуулах;
3. шинжээч оролцуулан дүгнэлт гаргуулах;
4. гэрч, гуравдагч этгээдээс тайлбар гаргуулах;
5. баримт бичиг болон хууль, бусад шийдвэртэй танилцах, хуулбарлах;
6. шаардлагатай бол туршилт хийх;
7. оролцогчийн хүсэлтээр зайлшгүй шаардлагатай нотлох баримтыг гаргуулан авах.

Захиргааны байгууллага холбогдох нотлох баримтуудыг цуглуулж, дүн шинжилгээ хийсний дараа тухайн шийдвэрт хамаатай иргэдээс сонсох ажиллагаа явуулна. Сонсох ажиллагааг Ерөнхий хуульд оролцогчийг сонсох /ЗЕХ.26/ гэж заасан. Сонсох ажиллагаа нь захиргааны байгууллагад үр нөлөөтэй, бодит нөхцөлд тохирсон,

үндэслэл бүхий шийдвэр гаргах боломжийг олгодог (Монгол Улсын захиргааны ерөнхий хуулийн тайлбар).

Захиргааны шийдвэрийн хууль зүйн техникт баримт бичгийн стандартыг баримтална. Энэ нь албан хэрэг хөтлөлтийн журмаар зохицуулагдана.

ДАСГАЛ 2. Тохиолдол шинжлэх

Үргэлжлэх хугацаа: 20 минут

Аргачлал: Оролцогчид 3 багт хуваан тодорхой нэг жишээн дээр ажиллуулна.

1. Нийт 3 багт хуваагдана. Нэг багт 5-6 хүн байна. А, В, С баг гэж дугаарлана.
2. Ширээний байрлал: П хэлбэртэй
3. Баруун- А баг
4. Зүүн - В баг
5. Дунд -В баг сууна.

Баг тус бүрт дасгал ажлын хуудас- 3, бичиг хэрэгсэл тараагдсан байна. А ба В баг жишээг бодож, хариултаа хэлнэ. С баг дүгнэнэ.

Тохиолдлын гол үр дүнг дэлгэц цаасан дээр бичиж, танилцуулах ба танилцуулгын явцад асуулт асуух, хариулт өгөх, тодруулга хийх зэргээр оролцоонд суурилсан үйл ажиллагааг хэрэгжүүлэх боломж бүрдүүлнэ.

Жишээ:

Нийслэлийн ИТХ-аас авто машин худалдаалдаг захуудыг нүүлгэн шилжүүлэхдээ холбоотойгоор шийдвэр гаргахаар болжээ. Ховд аймгаас машин худалдаж авахаар ирсэн малчин А дээрх шийдвэрийн оролцогч болох уу?

Асуулт: ИТХ хууль зүйн ямар техник ашиглаж шийдвэрээ гаргах вэ?

2.3.2.Захиргааны хэм хэмжээний акт гаргах

Захиргааны хэм хэмжээний актад “эрх олгогдсон байх, хуулиар хориглоогүй асуудлаар хориглосон зохицуулалт тогтоохгүй байх” шаардлага тавигдсанаас үзэхэд хуульд зааснаас өөрөөр шинээр эрх, үүрэг үүсгэсэн агуулгатай байх боломжгүй байна. Гэвч тухайн харилцаанд оролцогчдод чиглэсэн үйл ажиллагаа, цаг хугацааны тодорхой нөхцөл, шаардлага, хүрээ, хязгаар тогтоосон байх нь бий.

ИТХ-ын шийдвэрийн хувьд хууль зүйн техникийн ерөнхий дүрмийн дагуу бие даасан хэм хэмжээний акт гаргах гэж байгаа бол хууль бүтээх, харин хууль хэрэгжүүлэхийн тулд гаргасан хэм хэмжээний актын хувьд хэрэгжүүлэх хууль зүйн техникийг баримтална.

ИТХ-ын хууль хэрэгжүүлэхийн тулд гаргасан захиргааны хэм хэмжээний актын хууль зүйн техникийн агуулгыг ЗЕХ-д дараах байдлаар зохицуулжээ. Үүнд:

- Захиргааны хэм хэмжээний актын төслийг бэлтгэх
- Нөлөөллийн шинжилгээ хийх
- Захиргааны хэм хэмжээний актын төсөлд санал авах
- Захиргааны хэм хэмжээний актыг баталж, хүргүүлэх
- Захиргааны хэм хэмжээний актыг бүртгэх
- Захиргааны хэм хэмжээний акт хүчин төгөлдөр болох
- Хяналт-шинжилгээ, үнэлгээ

ИТХ захиргааны хэм хэмжээний акт гаргахдаа дараах хуульд заасан шаардлагыг хангах үүрэгтэй.

- Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон бусад хуульд нийцсэн байх;
- тусгайлан эрх олгосон тухайн хуулийн агуулга, зорилго, хүрээнд нийцсэн байх;
- тэмдэглэх хэсэгт үндэслэл болгож байгаа хуулийн заалтыг заасан байх;
- шийдвэрийн заалт хоорондоо болон эрх бүхий бусад этгээдийн гаргасан шийдвэрийн заалттай зөрчилдөхгүй байх;
- Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог үндсэн болон нийтээр хүлээн зөвшөөрсөн утгаар хэрэглэх;
- хуулиар хориглоогүй асуудлаар хориглосон зохицуулалт тогтоохгүй байх;
- тухайн шийдвэрээр урьд нь гарсан шийдвэрийг хүчингүй болсонд тооцож байгаа, эсхүл түүнд өөрчлөлт оруулж байгаа бол энэ тухай заалтыг тусгасан байх;
- бусад хуулийн заалтыг давхардуулан заалгүйгээр шаардлагатай тохиолдолд эшлэл хийгдсэн байх;
- баталсан байгууллага, албан тушаалтны болон захиргааны хэм хэмжээний актын нэр, он, сар, өдөр, дугаарыг тодорхой заасан байх;
- хуульд заасан бусад шаардлага

Мөн ИТХ хууль хэрэгжүүлэхтэй холбоотой гаргасан хэм хэмжээний актыг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад бүртгүүлэх ёстой.

ЗЕХ батлагдахаас өмнөх нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын гаргасан хэм хэмжээний актыг Хууль зүйн яам Засгийн газрын 2010 оны 119 дүгээр тогтоолоор батлагдсан журамд нийцсэн эсэхэд бүрэн хяналт тавих боломжгүй байсан. Жишээ нь нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын хэм хэмжээний шийдвэр гэдэг утгаар шүүхийн практикт агуулгын болон хэлбэрийн шаардлага хангаж байгаа эсэхийг Засгийн газрын байгууллагынхтай адилтган бүрэн шалган тогтоох боломжгүй байсаар ирсэн. Харин Захиргааны ерөнхий хууль батлагдсанаар бүх захиргааны байгууллага, тухайлбал, ИТХ захиргааны байгууллага мөн тул уг хуулиар тогтоосон журам, шаардлагын дагуу захиргааны хэм хэмжээний акт гаргах болсон. Хэрэв тухайн нутаг дэвсгэрт үйлчлэх хэм хэмжээний актыг бүртгүүлж, Захиргааны хэм хэмжээний нэгдсэн санд оруулаагүй бол уг журам хүчин төгөлдөр бус гэж үзнэ. Гэхдээ өмнө дурдсан Үндсэн хуулийн 62.2-ийг үндэслэж гаргасан бол бүртгүүлэх эсэх нь эргэлзээтэй байна.

ДАСГАЛ 3.

Үргэлжлэх хугацаа: 40 минут

Захиргааны хэм хэмжээний актын төсөл бичих даалгавар өгөх

Сэдэв: Иргэдийн оролцоог хангах тухай журмын төсөл боловсруулах 4 баг тус бүрд багш даалгавар өгнө.

- А баг актын төслийн зорилго, бүтцийг гаргах
 - Б баг нөлөөллийн шинжилгээ хийх /нөлөөллийн шинжилгээ хийх аргачлалыг багш өгнө./
 - С баг төсөлд санал авах ажлыг зохион байгуулах
 - Г баг төслийг батлах, бүртгүүлэх журмын талаар танилцуулга бэлдэх
-

Багшийн дүгнэлт

ИТХ-ын төлөөлөгч бол иргэдээс сонгогддог олон нийтийн эрх ашгийн төлөө шийдвэр гаргагч билээ. Нутгийн өөрөө удирдах ёсыг Үндсэн хуульд зааж өгснөөс хойш 25 жил өнгөрсөн боловч төлөөлөгч өөрийгөө, иргэн төлөөлөгчийг “дарга” гэж ойлгодог сэтгэлгээнээс салаагүй байна. ИТХ шийдвэр бол тухайн нутаг дэвсгэрийн ирээдүйн хөгжлийн бодлогыг тодорхойлох, бодит нөхцөл байдлыг зөв үнэлсэн, иргэдийн оролцоон дээр тулгуурласан байх зэрэг шаардлагыг хангасан байх ёстой. Эдгээр шаардлагыг хангах суурь нөхцөл нь төлөөлөгч хууль тогтоомжийн хэрэглээний тодорхой мэдлэг эзэмшсэн байх юм.

Нэмж судлах эх сурвалж

- Монгол улсын Үндсэн хууль. (1992)
- Захиргааны Ерөнхий хууль. (2016)
- Алтанзул.А., (2017), *Захиргааны шийдвэр гаргах ажиллагаа, нийтлэг гарч буй алдаа, анхаарах асуудал*, Шударга ёс сэтгүүл
- Захиргааны Ерөнхий хуулийн тайлбар. (2017), Ханс-зайделийн сан
- Кашанина. Т.В. (2016), *Хууль зүйн техник*
- Лүндээжанцан. Д. (2017). *Хууль бүтээх ажиллагаа ба хууль зүйн техник*. Улаанбаатар
- Лүндээжанцан. Д., (2017), *Хууль бүтээх ажиллагаа ба хууль зүйн техник*
- Одгэрэл П., Алтанзул. А., Мөнхзул. Б., Дэлгэрзаяа. Д., Мөнх-Эрдэнэ.Б., (2017), *Захиргааны эрх зүйн сургалтын гарын авлага*.
- Одгэрэл. П. (2016). *Захиргааны эрх зүйн ерөнхий анги*.
- Сүнжид. Д. (2016). *Захиргааны Ерөнхий хууль хэрэглээ: үзэл баримтлал, хэрэглээ*
- Удирдлагын Академи. (2013). *Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрт дүн шинжилгээ хийсэн судалгааны ажил*
- Чимид. Б., (2004), *Үндсэн хуулийн үзэл баримтлал: Нутгийн удирдлага*
- Энхбаатар. Ч., (2007), *Үндсэн хуулийн эрх зүй*

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙГ ТӨЛӨВЛӨХ, ХЯНАХАД ИТХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ

Зорилго: Сургалтад оролцогчид орон нутгийн төсвийн төлөвлөлт, хяналтын талаарх мэдлэгээ бататгаж, орон нутгийн хөгжлийн бодлогын баримт бичиг болон төсвийн уялдааг хангах, төсвийн төсөл, хөрөнгө оруулалтын төсөв боловсруулах үйл явцад оролцох, орон нутгийн төсвийн ил тод байдал, төсвийн зарцуулалтад хяналт тавих ур чадвар эзэмшихэд нь дэмжлэг үзүүлэх

Дэд сэдэв:

1. Орон нутгийн хөгжлийн төлөвлөгөө ба төсвийн уялдаа
2. Орон нутгийн хөрөнгө оруулалтын хэрэгцээг тодорхойлох, эрэмбэлэх, шийдвэр гаргах үйл явцад ИТХ-ын Төлөөлөгчийн гүйцэтгэх үүрэг
3. Орон нутгийн төсвийн зарцуулалт, түүний ил тод байдалд ИТХ-аас хэрэгжүүлэх хяналт

Хүрэх үр дүн

- Төсвийн тухай болон Шилэн дансны тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль тогтоомжид тулгуурлан орон нутгийн хөгжлийн бодлогын баримт бичгүүд, тэдгээрийн ангилал, хөрөнгийн болон урсгал төсвийн уялдаа, төсвийн ил тод байдлын талаарх мэдлэг, ойлголтоо бататгана.
- Тодорхой орон нутгийн хөгжлийн баримт бичгүүдтэй танилцах замаар орон нутгийн хөгжлийн дунд, богино хугацааны баримт бичгүүд болон төсвийн уялдааг хангаж чадаж буй эсэхэд шинжилгээ хийж, үнэлгээ өгөх чадварыг эзэмшинэ.
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгцээг тодорхойлох, эрэмбэлэх, шийдвэр гаргах үйл явцыг зураглан энэ үйл явцад ИТХ-ын Төлөөлөгчийн гүйцэтгэх үүргийг тодорхойлж, үүргээ хэрэгжүүлэхэд шаардагдах мэдлэг, чадвартай болно.
- Шилэн дансны тухай хуулийн дагуу орон нутгийн ТЕЗ болон байгууллагын төсвийн зарцуулалтын ил тод байдлыг хянаж, үнэлгээ өгөхөд суралцана.

Хүснэгт 4.3. Хичээлийг зохион байгуулах төлөвлөгөө

№	Агуулга	Сургалтын арга	Цагийн хуваарилалт	Сургалтын хэрэглэгдэхүүн
Нэг. Орон нутгийн хөгжлийн төлөвлөгөө ба төсвийн уялдаа				
1	“Орон нутгийн төсөв, санхүү”-гийн талаарх ИТХ-ын Төлөөлөгчийн мэдлэг, чадварын түвшинг тогтоох	Сорил авах	15 минут	Сорилын хуудас, зөв хариулт, нэгтгэх хуудас
2	Орон нутгийн хөгжлийн бодлогын баримт бичгүүд, тэдгээрийн ангилал	Багшийн мэдээлэл	20 минут	Лекцийн слайд, компьютер, проектор
3	Орон нутгийн хөгжлийн дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүд болон төсвийн уялдааг хангаж буй байдалд үнэлгээ өгөх	Кейс ажиллах, хэлэлцүүлэг	40 минут	Тодорхой орон нутгийн кейс, ажлын хуудас, хэлэлцүүлгийн удирдамж
Хоёр. Орон нутгийн хөрөнгө оруулалтын хэрэгцээг тодорхойлох, эрэмбэлэх, шийдвэр гаргах үйл явцад ИТХ-ын Төлөөлөгчийн гүйцэтгэх үүрэг				
1	Орон нутгийн төсвийн үйл явцын үндсэн үе шатууд ба ИТХ-ын үүрэг	Хэлэлцүүлэг	20 минут	Хэлэлцүүлгийн удирдамж, дэлгэц цаас, үзэг, скочь
2	Орон нутгийн хөрөнгө оруулалтын хэрэгцээг тодорхойлох, эрэмбэлэх, шийдвэр гаргах үйл явцыг зураглах	Дасгал ажил	25 минут	Дасгал ажлын удирдамж, дэлгэц цаас, үзэг, скочь

Завсарлага			15 минут	
3	Орон нутгийн хөрөнгө оруулалтыг төлөвлөх, шийдвэр гаргах үйл явцад ИТХ-ын Төлөөлөгчийн гүйцэтгэх үүргийг тодорхойлох	Кейс ажиллах, хэлэлцүүлэг	25 минут	Тодорхой орон нутгийн кейс, хэлэлцүүлгийн удирдамж, дэлгэц цаас, үзэг, скочь
4	Багшийн дүгнэлт		5 минут	
Гурав. Орон нутгийн төсвийн зарцуулалт, түүний ил тод байдалд ИТХ-аас хэрэгжүүлэх хяналт				
1	Орон нутгийн төсвийн зарцуулалт, ил тод байдалд ИТХ-аас хяналт тавих шаардлага	Багшийн мэдээлэл	20 минут	Лекцийн слайд, компьютер, проектор
2	Орон нутгийн төсвийн зарцуулалт, түүний ил тод байдлыг хянах чиглэлээр ИТХ-аас хэрэгжүүлж буй ажлын талаарх туршлагаа хуваалцах	Дасгал ажил, хэлэлцүүлэг	20 минут	Дасгал ажил, хэлэлцүүлгийн удирдамж
3	Орон нутгийн болон байгууллагын төсвийн ил тод байдлыг үнэлэх	Кейс ажиллах, хэлэлцүүлэг	30 минут	Тодорхой орон нутгийн кейс, хэлэлцүүлгийн удирдамж
4	Багшийн дүгнэлт		5 минут	
НИЙТ			225 минут	

3.1. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БА ТӨСВИЙН УЯЛДАА

Сорил: “Орон нутгийн төсөв, санхүү”-гийн талаарх ИТХ-ын Төлөөлөгчийн мэдлэг, чадварын түвшинг тогтоох

Үргэлжлэх хугацаа: 15 минут

“Орон нутгийн төсвийг төлөвлөх, хянахад ИТХ-ын гүйцэтгэх үүрэг” сэдэвт бататгах сургалтанд хамрагдахын өмнө сургалтанд хамрагдах ИТХ-ын Төлөөлөгчдийн орон нутгийн төсөв, санхүүгийн удирдлагын талаарх мэдлэг, чадварын түвшинг тогтоох 15 асуулт бүхий сорилыг авна.

Сургалтанд оролцогчдын бөглөсөн сорилыг зөв хариулттай тулган, дүнг дараах хүснэгтэд нэгтгэнэ. Оролцогчдын бөглөсөн сорилын дүнг харгалзан багш сургалтын хүрээнд тодруулж, бататгах шаардлагатай мэдлэг, чадварыг эзэмшүүлэхэд анхаарч ажиллана.

Орон нутгийн төсөв, санхүүгийн талаарх ИТХ-ын Төлөөлөгчдийн мэдлэг чадварын түвшинг тогтоох сорилын дүнг нэгтгэх хуудас

№	Овог, нэр	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	Зөв хариулт	Хувь
1																		
2																		
3																		
4																		
5																		
	НИЙТ																	

**ИТХ-ын Төлөөлөгчдийн орон нутгийн төсөв, санхүүгийн удирдлагын талаарх
мэдлэг, чадварын түвшинг тогтоох сорил**

Таньд энэ өдрийн мэндийг хүргэе!

Сургалтын үр дүнг дээшлүүлэх зорилгоор оролцогчдын мэдлэгийн түвшинг үнэлэхийн тулд энэхүү сорилыг авч байгаа болно.

Хугацаа: 15 минут

1. Монгол Улсын нэгдсэн төсөв нь:
 - 1) Улсын төвлөрсөн ба орон нутгийн төсвөөс бүрдэнэ.
 - 2) Засгийн газрын мэдэлд зарцуулах төсөв ба орон нутгийн төсөв юм.
 - 3) Төвлөрсөн төсөв болон Засаг даргын мэдэлд зарцуулах төсвийг хэлнэ.
 - 4) Улсын болон орон нутгийн төсөв, Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвөөс бүрдэнэ.
2. Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч нь:
 - 1) Ерөнхий сайд
 - 2) Тухайн шатны Засаг дарга
 - 3) Тухайн шатны ИТХ-ын нарийн бичгийн дарга
 - 4) Тухайн шатны ЗДТГ-ын дарга
3. Орон нутгийн төсөв нь дараах эх үүсвэрээс бүрддэг.
 - 1) Орон нутгийн төсвийн суурь орлого
 - 2) Дээд шатны төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлэг
 - 3) Тусгай зориулалтын шилжүүлэг
 - 4) Дээрх бүгд
4. Дараах албан тушаалтнуудын аль нь төсвийн ерөнхийлөн захирагч вэ?
 - 1) Салбарын яамны төрийн нарийн бичгийн дарга
 - 2) Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга
 - 3) Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга
 - 4) Үндэсний татварын ерөнхий газрын дарга
5. Төсвийн тухай Монгол Улсын хуулинд зааснаар орон нутгийн төсөв нь:
 - 1) ИТХ-аас баталсан, тухайн шатны төсөвт харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчийн бүрдүүлж, хуваарилан зарцуулах төсөв
 - 2) Орон нутгийн орлого, санхүүгийн дэмжлэг, улсын төсвийн байгууллагын санхүүжилтийн нийлбэр
 - 3) Сургууль, цэцэрлэг, эмнэлэг, соёлын төвийн санхүүжилт
 - 4) Дээрх бүгд
6. Төсвийн гадаад буюу хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх байгууллага нь:
 - 1) Төрийн өмчийн хороо
 - 2) Татварын хяналт шалгалтын газар
 - 3) Төрийн аудитын байгууллага
 - 4) Төсвийн хяналт, дотоод аудитын алба
7. Дараах албан тушаалтнуудын аль нь төсвийн шууд захирагч вэ?
 - 1) Сумын Засаг даргын Тамгын газрын дарга
 - 2) Сумын ИТХ-ын дарга
 - 3) Ерөнхий сайд
 - 4) Үндсэн хуулийн цэцийн дарга
8. Орон нутгийн суурь орлого гэдэг нь:
 - 1) Тухайн шатны төсөвт төвлөрөх бүх төрлийн татварын орлогыг хэлнэ.
 - 2) Тухайн шатны төсөвт орох татварын доод хувь хэмжээгээр тооцсон орлого болон татварын бус орлогын нийлбэрийг хэлнэ.
 - 3) Орон нутгийн төсвийн байгууллагуудын төвлөрүүлэх орлогыг хэлнэ.

- 4) Орон нутгийн хөгжлийн сангийн нийт орлогыг хэлнэ.
9. Аймаг, нийслэлийн Засаг дарга Засгийн газрын дараах чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлнэ.
 - 1) Нийтийн тээвэр
 - 2) Аймгийн эрүүл мэндийн газраас үзүүлэх үйлчилгээ
 - 3) Мэргэжлийн боловсрол
 - 4) Соёлын үйлчилгээ
10. Төсвийн захирагчдыг:
 - 1) Төсвийн ерөнхийлөн захирагч, төвлөрүүлэн захирагч, шууд захирагч гэж ангилдаг
 - 2) Төсвийн ерөнхийлөн захирагч, шууд захирагч, нэгтгэн захирагч гэж ангилдаг
 - 3) Төсвийн ерөнхийлөн захирагч, ерөнхий менежер гэж ангилдаг
 - 4) Төсвийн төвлөрүүлэн захирагч, шууд захирагч гэж ангилдаг
11. Орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор дээд шатны орон нутгийн хөгжлийн сангаас олгож буй шилжүүлгийг юу гэж нэрлэдэг вэ?
 - 1) Нөхцөлт мөнгөн тусламж
 - 2) Санхүүгийн дэмжлэг
 - 3) Орлогын шилжүүлэг
 - 4) Тусгай зориулалтын шилжүүлэг
12. Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн гүйцэтгэхэд олгох шилжүүлгийг:
 1. Тусгай зориулалтын шилжүүлэг
 2. Нөхцөлт мөнгөн тусламж
 3. Санхүүгийн дэмжлэг
 4. Орлогын шилжүүлэг
13. Хэн нь төсвийн төвлөрүүлэн захирагч вэ?
 - 1) Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
 - 2) Салбарын сайдтай төлөөлөн гүйцэтгэх гэрээ байгуулан ажиллаж буй Засаг дарга
 - 3) Аймгийн Засаг даргатай гэрээ байгуулан ажиллаж буй салбарын сайд
 - 4) Аймгийн татварын хэлтсийн дарга
14. Орон нутгийн төсвийн суурь зарлагад аль нь хамаарах вэ?
 - 1) Төсвийн тухай хуулийн дагуу аймаг, нийслэл, сум, дүүргийн удирдлагын чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдсон урсгал болон хөрөнгийн зарлага
 - 2) Тухайн орон нутгийн хэмжээнд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээ үзүүлэх чиг үүрэгтэй холбогдох урсгал зардал
 - 3) Дээрх бүгд
15. Доод шатны төсвийн алдагдлыг нөхөх зорилгоор дээд шатны төсвөөс шилжүүлэх хөрөнгийг дараах байдлаар нэрлэдэг.
 - 1) Санхүүгийн дэмжлэг
 - 2) Орлогын шилжүүлэг
 - 3) Тусгай зориулалтын шилжүүлэг
 - 4) Нөхцөлт мөнгөн тусламж

Амжилт хүсье.

3.1.1. Орон нутгийн хөгжлийн бодлогын баримт бичгүүд, тэдгээрийн ангилал*Үргэлжлэх хугацаа: 20 минут*

Орон нутгийн төсвийг боловсруулахдаа үндэсний болон орон нутгийн урт, дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөөтэй нягт уялдуулах шаардлагатай байдаг. Учир нь энэхүү урт, дунд хугацааны төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хангах санхүүгийн баталгаа нь орон нутгийн төсөв юм.

Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгийг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үе шат, баримтлах зарчим, оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох, хөгжлийн бодлого төлөвлөлтийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулах зорилгоор “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль”-ийг УИХ-аар 2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр батлан мөрдөж байна. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хууль батлагдсанаар Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтолцооны эрх зүйн үндэс бүрдэж, улс, бүс, орон нутаг, салбарын хөгжлийн бодлогыг төлөвлөх, боловсруулах ажлын уялдааг хангах боломжтой болсны зэрэгцээ орон нутгийн хөгжлийн урт, дунд, богино хугацааны төлөвлөгөөний нэгдсэн аргачлал, шаардлага тодорхой болсон билээ.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулинд орон нутгийн хөгжлийн бодлоготой холбогдох дараах баримт бичгүүдийн тодорхойлолтыг тусгаж өгсөн байдаг. Үүнд:

- *Аймаг, нийслэл, сум, дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл* - Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, дэд хөтөлбөрийн хүрээнд тухайн жилд дэвшүүлсэн зорилго, зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлсон баримт бичиг;
- *Аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт* - бүсчилсэн хөгжлийн бодлогод суурилсан, орон нутгийн онцлогийг харгалзан, байгаль орчны тогтвортой байдлыг хангасан эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх зорилго, зорилтыг тодорхойлсон баримт бичиг;
- *Бүсчилсэн хөгжлийн бодлого* - Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалд суурилсан, бүс нутаг, хот байгуулалтын уялдаа, байгаль орчны тогтвортой байдлыг хангах замаар орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийг дэмжих зорилго, зорилт, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлсон баримт бичиг;
- *Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр* - бүсчилсэн хөгжлийн бодлого болон аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтод суурилсан, орон нутгийн сонгуулиар олонх суудал авсан улс төрийн нам, улс төрийн намуудын эвслийн мөрийн хөтөлбөрийг тусгасан, орон нутгийн хөгжлийн дунд хугацааны зорилго, зорилт, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлсон баримт бичиг;
- *Дэд хөтөлбөр* - Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд дэвшүүлсэн зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг тодорхойлсон баримт бичиг хамаарна.

Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журмыг Засгийн газар 2016 оны 29-р тогтоолоор батласан бөгөөд дэвшүүлж байгаа зорилго, зорилтоосоо хамааран хөгжлийн бодлогын баримт бичиг нь урт, дунд, богино хугацааны гэсэн 3 төрөлтэй байна. Үүнд:

- *Урт хугацааны* буюу 15-20 жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын баримт бичиг нь Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал байна.
- *Дунд хугацааны* буюу 8-10 жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын баримт бичиг:

- төрөөс баримтлах бодлого;
- бүсчилсэн хөгжлийн бодлого;
- аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт.
- *Дунд хугацааны буюу 3-5 жилийн* хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын баримт бичиг:
 - Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр;
 - Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр;
 - үндэсний хөтөлбөр болон дэд хөтөлбөр;
 - улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр.
- *Богино хугацааны* буюу нэг жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын баримт бичиг:
 - улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл;
 - аймаг, нийслэл, сум, дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл;
 - улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд нийцүүлэн боловсруулсан улсын болон орон нутгийн төсөв.

Монгол улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, үндэсний хөтөлбөр болон улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн тухайн жилд хэрэгжүүлэх арга хэмжээнд үндэслэн боловсруулах бөгөөд энэхүү үндсэн чиглэлд дээр дурдсан урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн холбогдох заалт, зорилт, арга хэмжээ, хүрэх түвшин, шалгуур үзүүлэлт, хариуцах байгууллага, төсөв, санхүүгийн тооцоо, эх үүсвэрийг тусгасан байна.

Нутгийн захиргааны байгууллага буюу Засаг дарга, ЗДТГ нь:

- Үндэсний хэмжээний бодлогын чанартай арга хэмжээ болон улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хязгаарыг хангаж байгаа төсөл, арга хэмжээний саналыг улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгуулахаар жил бүрийн 2 дугаар сарын 15-ны дотор салбарын яам болон Сангийн яаманд хүргүүлнэ.
- Холбогдох яам, агентлаг улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг өөрийн эрхлэх асуудлын хүрээнд нутгийн захиргааны байгууллагаас ирүүлсэн саналыг тусган, нэгтгэн боловсруулж, жил бүрийн 3 дугаар сарын 1-ний дотор Сангийн яаманд хүргэдэг болсон.

Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагаас улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгах төсвийн хөрөнгө оруулалтын нийт дүн нь дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд заасан тухайн салбарын зарлагын дээд хязгаараас хэтрэхгүй байхаар зохицуулсан байна.

Орон нутгийн хөгжлийн дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд тулгуурлан аймаг, нийслэл, сум, дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг боловсруулна.

- Аймаг, нийслэл, сум, дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, дэд хөтөлбөрт үндэслэн тухайн жилд эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх чиглэлээр дэвшүүлсэн зорилт, арга хэмжээ, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт, хариуцах байгууллага, төсөв, санхүүгийн тооцоо, эх үүсвэрийг тодорхойлсон байх шаардлагатай.

- Засаг дарга эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг боловсруулж, 10 дугаар сарын 5-ны дотор иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдаа өргөн мэдүүлж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.
- Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг хэлэлцэн батлахдаа өмнөх жилийн биелэлт, тухайн жилийн хэрэгжилтийн явцыг хэлэлцэж дүгнэнэ.

Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд үндэслэн тухайн жилийн төсвийн төслийг боловсруулна.

“Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”-ыг УИХ 2016 оны 2-р сарын 5-ны өдрийн 19 тоот тогтоолоор батласан. Уг үзэл баримтлалд эдийн засаг, нийгэм, байгаль орчин, засаглалын харилцан хамаарлыг бүхэлд нь тусгаж, Монгол хүний хөгжлийг эрхэмлэсэн цогц бодлого байхаар боловсруулсан бөгөөд 2016-2020, 2021-2025, 2026-2030 он гэсэн 3 үндсэн үе шаттайгаар хэрэгжүүлнэ. Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал нь НҮБ-аас батлан гаргасан Тогтвортой хөгжлийн үзэл санаанд суурилсан төдийгүй Монгол Улсын өөрийн онцлог, тулгамдаж байгаа асуудлуудтай нягт уялдсан байна.

Тус үзэл баримтлал батлагдсанаар үндэсний болон орон нутгийн хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлого нь үр дүнд суурилсан удирдлагын хүрээнд хэрэгжих бөгөөд бодлого төлөвлөлт, төсөвлөлт, хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагаа нь харилцан уялдаатай, нэгдмэл зорилго, зорилтод чиглэсэн эрх зүй, эдийн засаг, нийгмийн шинэ орчин бүрдсэн юм. Монгол Улсын салбар, аймаг, орон нутгийн хөгжлийн хөтөлбөр, бүсчилсэн хөгжлийн бодлого зэрэг дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогуудыг урт хугацааны тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлснээр нэгдсэн бодлогоор улс орныг хөгжүүлэх боломжтой болж байна.

Иймээс аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтыг тодорхойлон хэрэгжүүлснээр орон нутгийнхаа хөгжлийн бодлогыг Монгол улсын хэмжээний болон салбарын хөгжлийн бодлоготой уялдуулах боломжтой болох төдийгүй Орон нутгийн хөгжлийн сангаа үр ашигтай зарцуулах бүрэн боломжтой болно. Тухайлбал, Төсвийн тухай хуулиар Орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлэх төслийг сонгохдоо Иргэдийн нийтийн хурлаараа иргэд эхлэн эрэмбэлэхээр заасан бол мөн хуулийн 63.3-д баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлаас ирүүлсэн саналыг тухайн орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан эрэмбэлж, төсвийн төсөлд тусгах боломжтойгоор хуульчилсан байна.

Орон нутгийн хөгжлийн хэрэгцээ, бүс нутгийн хөгжлийн бодлоготой нийцсэн дунд хугацаанд хэрэгжих, төсөвт өртөг өндөртэй томоохон төслүүдийг улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгуулан хэрэгжүүлэх боломжтой. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг 4 жилд нэг удаа баталж, жил бүр Засгийн газраар тодотгон авч явах ба тус хөтөлбөрт улсын төсөв, зээл, тусламж болон концессийн гэрээ, Хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжих төсөл арга хэмжээ бүгд хамаардаг.

3.1.2. Кейс, хэлэлцүүлэг: Орон нутгийн хөгжлийн дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүд болон төсвийн уялдааг хангаж буй байдалд үнэлгээ өгөх

Үргэлжлэх хугацаа: 40 минут

Аргачлал:

- Багш кейс ажиллах, хэлэлцүүлэг хийх удирдамжийг танилцуулна.

- Оролцогчдыг 5-6 хүнтэй 5 баг болгон ажиллуулна.
- Баг тус бүрт тодорхой аймгийн хөгжлийн зорилтыг тодорхойлсон баримт бичиг, тус аймгийн болон аль нэгэн сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн холбогдох зорилтууд, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, жилийн төсвийн талаарх мэдээллийг кейс болгон өгч, ажлын хуудсанд тусгасан асуултуудын дагуу үнэлгээ хийлгэнэ.
- Багийн нэг гишүүн багийн ажлыг удирдаж, өөр нэг гишүүн ажлын хуудсан дээр багийн гишүүдийн өгсөн үнэлгээг асуулт тус бүрээр тэмдэглэнэ.
- Оролцогчид аймаг, сумын түвшинд орон нутгийн хөгжлийн баримт бичгүүд ба төсвийн уялдааг хангаж чадаж буй эсэхэд үнэлгээ өгөхийн зэрэгцээ цаашид авах арга хэмжээний талаарх саналаа гаргана.

Ажлын хуудас 1

Даалгавар, хэлэлцүүлгийн удирдамж:

1. Х аймгийн хөгжлийн зорилтыг тодорхойлсон баримт бичиг, тус аймгийн болон А сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн холбогдох зорилтууд, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, жилийн төсвийн талаарх мэдээлэлтэй танилцаж, өгөгдсөн асуултуудын дагуу үнэлгээ хийнэ.
 2. Багийн нэг гишүүн багийн ажлыг удирдаж, өөр нэг гишүүн ажлын хуудсан дээр багийн гишүүдийн өгсөн үнэлгээг асуулт тус бүрээр тэмдэглэнэ.
 3. Аймаг, сумын түвшинд орон нутгийн хөгжлийн баримт бичгүүд ба төсвийн уялдааг хангаж чадаж буй эсэхэд өгсөн үнэлгээнд тулгуурлан цаашид авах арга хэмжээний талаарх саналаа гаргана.
 4. Багаар ажиллах хугацаа 20 минут
 5. Багийн ажлын үр дүнг танилцуулах – баг тус бүр 2 минут (нийт 10 минут)
 6. Нийтээр хэлэлцэх хугацаа 10 минут
-

Асуулт, хариулт

1. Аймгийн хөгжлийн зорилтыг тодорхойлсон баримт бичиг болон аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн холбогдох зорилт, заалтууд хоорондоо уялдаатай байна уу?
2. Аймаг, сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, дэд хөтөлбөрт тулгуурлан боловсруулсан байна уу?
3. Аймаг, сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон жилийн төсвийг харилцан уялдаатай боловсруулж баталсан эсэхэд үнэлгээ өгнө үү.
4. Аймаг, сумын түвшинд орон нутгийн хөгжлийн баримт бичгүүд ба төсвийг илүү сайн уялдуулахын тулд цаашид авах арга хэмжээг санал болгоно уу.

Кейс 1**Х аймгийн хөгжлийн бодлогын баримт бичгүүд болон батлагдсан төсөв**

Х аймгийн хөгжлийн бодлогын баримт бичгүүд өгөгдсөн байна. Үүнд:

- Аймгийг хөгжүүлэх хэтийн зорилт 2017-2024
- Аймгийн ЗД-ын үйл ажиллагааны хөтөлбөр 2016-2020
- Аймгийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл
- Аймгийн 2018 оны төсөв

Хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан байгаль орчны чиглэлийн зорилтууд:

“ХӨГЖЛИЙН ТҮҮЧЭЭ-XXX АЙМАГ-2024” АЙМГИЙН ХӨГЖЛИЙН ХЭТИЙН ЗОРИЛТ**3. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ****ЗОРИЛГО 1:**

- Ногоон хөгжлийн үзэл баримтлал, байгаль орчны даац чадамжид суурилж хүний үйл ажиллагаанаас хамааралтай байгалийн доройтлыг хязгаарлан баялгийг нь зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, хамгаалах үйл ажиллагааг, нутгийн иргэд, тэдний үүсгэл санаачилгын болон мэргэжлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж, нийт иргэдэд байгальд ээлтэй хандлага, зөв дадлыг төлөвшүүлж, экологийн тэнцвэрт байдлыг хадгалан, ирээдүй хойч үедээ өвлүүлж, үр өгөөжийг нь урт хугацаанд хүртэх боломжоор хангах нөхцлийг бүрдүүлэн ногоон хөгжлийг хангахад оршино.

Зорилт 1: Агаар хөрсний бохирдлыг бууруулах, хог хаягдлын зохистой менежментийг хэрэгжүүлж, хүн амыг эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлнэ.

- ***Нэгдүгээр үе шат (2017-2020 он):***
 - Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлж, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөгүй, үр ашигтай, дэвшилтэт технологи нэвтрүүлэн, агаарын болон хөрсний бохирдлыг бууруулах.
 - Орчны бохирдлыг бууруулах, хэмнэлттэй хэрэглээг бий болгох байгаль хамгаалах уламжлалт ёс заншлаа өвлүүлэх, орчин үеийн амьдралын хэмнэлд нийцсэн, үр ашигтай хэрэглээний соёлыг төлөвшүүлэх.
 - Ахуйн хог хаягдлыг ангилан ялгах боловсруулах үйлдвэр байгуулах.
 - Гэр хорооллын айл өрхийн бохирын цооног, задгай нойлын стандартыг хангуулах.
- ***Хоёрдугаар үе шат (2021-2024):***
 - Хог хаягдлыг цуглуулан тээвэрлэх, устгах үйл ажиллагааг олон улсын жишигт нийцүүлэн боловсонгүй болгон, хог хаягдлын дахин боловсруулах аж үйлдвэрийн парк байгуулах.
 - Иргэн бүр хог хаягдлыг ангилан ялгаж, дахин боловсруулах, эдийн засгийн эргэлтэнд оруулах сэтгэлгээ, хандлага төвшиж, эх үүсвэр дээрх хог хаягдлын үнэлэмжийг бий болгох.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧИН НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Тэргүүлэх зорилт: Байгаль орчны даац чадамжид суурилж хүний үйл ажиллагаанаас хамааралтай доройтлыг хязгаарлан зүй зохистой ашиглах нөхөн сэргээх, хамгаалах үйл ажиллагааг, нутгийн иргэд тэдний үүсгэл санаачилгыг байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж, байгальд ээлтэй хандлага, зөв дадлыг төлөвшүүлж, ногоон хөгжлийг хангана.

Зорилт: Байгальд ээлтэй хандлага, зөв дадлыг төлөвшүүлэх замаар агаар хөрсний бохирдлыг бууруулах, хог хаягдлын зохистой менежментийг хэрэгжүүлж, хүн амыг эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1. Албан байгууллага, айл өрхийн хог хаягдлыг төрөлжүүлэн ялгах, зайлуулах, булшлах ажлыг цогцоор нь шийдвэрлэж, агаарын болон хөрсний бохирдлыг бууруулж, хүн амыг эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ. БХС 100,0 сая,төг
2. Хог хаягдлыг ангилан боловсруулах үйлдвэр байгуулна. БХС 900,0 сая,төг
3. Гэр хорооллын айл өрхийн бохирын цооног, задгай 00-ыг стандарт хангуулах ажлыг ээлж дараатайгаар хэрэгжүүлнэ. ОНХО 1500,0 сая

АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2018 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

Чадамжид суурилж хүний үйл ажиллагаанаас хамааралтай доройтлыг хязгаарлан зүй зохистой ашиглах нөхөн сэргээх, хамгаалах үйл ажиллагааг, нутгийн иргэд тэдний үүсгэл санаачилгыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж, байгальд ээлтэй хандлага, зөв дадлыг төлөвшүүлж ногоон хөгжлийг хангана.

Зорилт:

- Усны нөөцийг хамгаалах, бохирдлоос сэргийлэх, ариун чанараа хадгалах, байгалийн аясаар сэргэх бүхий л боломжийг бүрдүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1. Гол мөрний урсац бүрэлдэх эхийн хилийн заагийг тогтоосон газарт шаардлагатай зарим хэсгийг орон нутгийн хамгаалалтад авна.
2. Усан сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалттай бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдүүлж тэмдэгжүүлнэ. **Орон нутгийн төсөв, БОХНСАХЗ 15.0 сая.төг**
3. Өмнөх онуудад тохижуулсан булаг шанданд үзлэг шалгалт хийж ашиглалт, хамгаалалтыг сайжруулах ажлыг зохион байгуулж, булаг шанд тохижуулах ажлыг үргэлжлүүлэн хийнэ. **БОХНСАХЗ 40.5 сая.төг**
4. Усны сав газрын захиргаатай хамтран гадаргын худаг, уст цэгийн тооллого хийж өөрчлөлтийг нарийвчлан бүртгэж мэдээллийн санг шинэчилж баяжуулна. **БОХНСАХЗ 10.0 сая.төг**
5. Уул уурхайн үйлдвэрлэлийн технологийн хэрэгцээнд ашиглаж буй ус хэрэглэгч, ашиглагчдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийнэ. **БОХНСАХЗ 0.5 сая.төг**
6. Цэвэрлэх байгууламжаас гарч буй хаягдал саарал усыг эргүүлэн ашиглах технологи, боломжийг судлан хэрэгжүүлэх талаар анхаарч ажиллана. **УТ, Сумын ОНТ**

АЙМГИЙН 2018 ОНЫ ТӨСӨВ

	5. Байгаль орчин аялал жуулчлалын газар Төсөвт байгууллагын өөрийн орлого	5000.0
--	--	--------

	3.2.3.	Засаг даргын шууд харьяаны байгууллага : Байгаль орчин аялал жуулчлалын газар	1037586,8
		Урсгал зардал, үүнээс:	
		арга хэмжээ : Үндсэн үйл ажиллагааны зардал	366685,4
		арга хэмжээ: Харуул хамгаалалтын зардал	4926,4
		арга хэмжээ: АО-с олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	13900,0

		арга хэмжээ: Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээ	652075,0
--	--	--	----------

	2.1.5	Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээ	Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтээр
--	-------	---	--

*Эрх зүйн лавлагаа 1***ХББББНЖ-ын дагуу тавигдах шаардлага**

9.4. "бодлогын зорилт" гэж асуудлыг хэсэгчлэн болон бүрэн шийдвэрлэхэд чиглэсэн Засгийн газраас аливаа бодлогын хүрээнд дэвшүүлсэн оновчтой, хэмжиж болохуйц, тодорхой хугацаанд хүрч болохуйц эерэг өөрчлөлтийг;

9.6. "бодлогын үр нөлөө" гэж бодлогыг хэрэгжүүлснээр эдийн засаг, нийгмийн хөгжил, байгаль орчны хүрээнд бий болох өөрчлөлтийг;

9.7. "бүтээгдэхүүн" гэж бодлогыг хэрэгжүүлэгч байгууллагаас авсан арга хэмжээний хүрээнд холбогдох талуудад нийлүүлж байгаа бараа, ажил, үйлчилгээг;

9.9. "шалгуур үзүүлэлт" гэж хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үе шат бүрт бий болох өөрчлөлтийг хэмжихээр төсөлд заасан чанарын болон тоон үзүүлэлтийг;

9.10. "суурь түвшин" гэж төслийг боловсруулах үеийн шалгуур үзүүлэлтийн чанарын болон тоон утгыг;

9.11. "зорилтот түвшин" гэж бодлогыг хэрэгжүүлэх явцад болон хэрэгжиж дуусахад хүрэхээр хүлээгдэж байгаа өөрчлөлтийг төсөлд тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн чанарын болон тоон утгыг;

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр

55.6. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилго нь аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтод үндэслэх;

55.7. Дэд хөтөлбөрийн зорилго нь Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтод үндэслэх.

61. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн төсөл дараах ерөнхий бүтэц, агуулгатай байж болно:

61.1. Нэгдүгээр бүлэг. Ерөнхий мэдээлэл;

61.2. Хоёрдугаар бүлэг. Эдийн засгийн хөгжлийн бодлогын зорилго, тэргүүлэх зорилтууд;

61.3. Гуравдугаар бүлэг. Нийгмийн хөгжлийн бодлогын зорилго, тэргүүлэх зорилтууд;

61.4. Дөрөвдүгээр бүлэг. Байгаль орчны бодлогын зорилго, тэргүүлэх зорилтууд;

61.5. Тавдугаар бүлэг. Засаглалын бодлогын зорилго, тэргүүлэх зорилтууд;

61.6. Зургаадугаар бүлэг. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ.

62. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг энэхүү журмын 8 дугаар хавсралтад заасан хүснэгтийн дагуу боловсруулна.

Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл

4.1.1. “аймаг, нийслэл, сум, дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл” гэж Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, дэд хөтөлбөрийн хүрээнд тухайн жилд дэвшүүлсэн зорилго, зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлсон баримт бичгийг;

16 дугаар зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл

16.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, дэд хөтөлбөрт үндэслэн тухайн жилд эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх чиглэлээр дэвшүүлсэн зорилт, арга хэмжээ, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт, хариуцах байгууллага, төсөв, санхүүгийн тооцоо, эх үүсвэрийг тодорхойлсон байна.

16.2. Нутгийн захиргааны байгууллага эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг боловсруулж, 10 дугаар сарын 05-ны дотор иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.

16.3. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг хэлэлцэн батлахдаа өмнөх жилийн биелэлт, тухайн жилийн хэрэгжилтийн явцыг хэлэлцэж дүгнэнэ.

16.4. Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд үндэслэн тухайн жилийн төсвийн төслийг боловсруулна.

16.5. Нутгийн захиргааны байгууллага эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж, 02 дугаар сарын 20-ны дотор Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.

54. “Бодлогын зорилго, зорилт”

54.1. бодлогын зорилго, зорилт нь тухайн бодлогыг хэрэгжүүлснээр урт, дунд хугацаанд нийгэм, эдийн засгийн хөгжилд бий болохоор хүлээгдэж байгаа өөрчлөлтийг илэрхийлсэн бодлогын үр нөлөөнд тулгуурласан тодорхой, хэмжиж болохуйц, хүрч болохуйц, хэрэгжихүйц бодитой байна;

54.2. бодлогын зорилго, зорилтыг хэрэгжүүлэх хугацааг тодорхойлсон байна;

57. “Бодлогын үр нөлөө, бүтээгдэхүүн, шалгуур үзүүлэлт” - бодлогыг хэрэгжүүлсний үр дүнд бий болох бүтээгдэхүүн, үр нөлөө, түүнийг хэмжих шалгуур үзүүлэлт

58. Бодлогын үр нөлөө, бүтээгдэхүүн, шалгуур үзүүлэлтийг бусад бодлогын баримт бичиг, статистикийн мэдээ, салбарын мэдээлэлд үндэслэн

58.1. бодлогын зорилго, зорилт бүрийг хэрэгжүүлсний үр дүнд бий болох эдийн засаг, нийгмийн хөгжил, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

58.2. зорилт тус бүрийн хүрээнд 2-5 хүртэлх тооны эдийн засаг, нийгмийн хөгжил, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг тодорхойлж, тухайн үр нөлөө бүрт 2-оос доошгүй шалгуур үзүүлэлт

58.3. бодлогыг хэрэгжүүлэгч байгууллагаас бусад этгээдэд хүргэх эцсийн бүтээгдэхүүнийг завсрын бараа, ажил, үйлчилгээ буюу эцсийн бүтээгдэхүүнийг бий болгоход ашиглагдах бүтээгдэхүүнээс ялгаж тодорхойлох;

58.4. бодлогын бүтээгдэхүүн бүрт 1-ээс доошгүй шалгуур үзүүлэлт

58.5. төсөлд шалгуур үзүүлэлтийн суурь түвшин, суурь он, зорилтот түвшин болон он, мэдээллийн эх сурвалж:

58.5.1. бодлогыг хэрэгжүүлсний үр дүнд гарах өөрчлөлт нь Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалын зорилт, шалгуур үзүүлэлттэй уялдсан байдал;

ББББ-д тавигдах шаардлага

Зорилго

- Дээд эрэмбийн бодлогын зорилтод үндэслэсэн байна

Зорилт

- Тухайн бодлогын зорилгод чиглэсэн байна


Хэрэгжүүлэх арга зам

- Тухайн бодлогын зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн байна

Шалгуур үзүүлэлт

Үр дүн тус бүрээр тодорхойлогдоно

- Суурь он
- Суурь үзүүлэлт
- Зорилтод он
- Зорилтод түвшин



3.2. ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭРЭГЦЭЭГ ТОДОРХОЙЛОХ, ЭРЭМБЭЛЭХ, ШИЙДВЭР ГАРГАХ ҮЙЛ ЯВЦАД ИТХ-ЫН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ

3.2.1. Хэлэлцүүлэг: Орон нутгийн төсвийн үйл явцын үндсэн үе шатууд ба ИТХ-ын үүрэг

Үргэлжлэх хугацаа: 20 минут

Хэлэлцүүлгийн удирдамж:

1. Оролцогчид орон нутгийн төсвийн үйл явцын үе шатуудыг дэс дараалан дурдаж, тухайн үе шатанд ИТХ-ын хэрэгжүүлдэг үүргийг тодруулж ярилцана. Үүнд:
 - а. Орон нутгийн төсвийг боловсруулж, бэлтгэх үе шат;
 - б. ИТХ-аар төсвийг хэлэлцэн батлах үе шат;
 - в. Төсвийн гүйцэтгэл, хэрэгжилтийг зохион байгуулах үе шат;
 - г. Төсвийг хянаж, үнэлэх үе шат
2. Оролцогчид орон нутгийн төсвийн үйл явцын үе шат бүрт ИТХ-ын зүгээс хэрэгжүүлдэг үүргийг тодруулж тайлбарлахад багш дэлгэц цаасан дээр тэмдэглэж, нийтээр хэлэлцэж, нэгдсэн дүгнэлтэд хүрэхийг зорино.
3. Оролцогч 1 минутад багтаан саналаа хэлэх бөгөөд хэлэлцүүлэг нийтдээ 20 минут үргэлжилнэ.

3.2.2. Дасгал ажил: Орон нутгийн хөрөнгө оруулалтын хэрэгцээг тодорхойлох, эрэмбэлэх, шийдвэр гаргах үйл явцыг зураглах

Үргэлжлэх хугацаа: 25 минут

Дасгал ажлын удирдамж:

- 1) Оролцогчид 5 багт хуваагдан ажиллаж орон нутгийн хөрөнгө оруулалтын хэрэгцээг тодорхойлох, эрэмбэлэх, шийдвэр гаргах үйл явцыг зураглана. Хугацаа: 10 минут
- 2) Багийн ажлын үр дүнг танилцуулна. Баг бүр 1-2 минут
- 3) Нийтээр хэлэлцэж, нэгтгэн дүгнэнэ. Хугацаа 5 минут

3.2.3. Кейс, хэлэлцүүлэг: Орон нутгийн хөрөнгө оруулалтыг төлөвлөх, шийдвэр гаргах үйл явцад ИТХ-ын Төлөөлөгчийн гүйцэтгэх үүргийг тодорхойлох

Үргэлжлэх хугацаа: 25 минут

Кейс, хэлэлцүүлгийн удирдамж:

- 1) Оролцогчид өөрсдийн зурагласан орон нутгийн хөрөнгө оруулалтын хэрэгцээг тодорхойлох, эрэмбэлэх, шийдвэр гаргах үйл явцад тухайн шатны ИТХ-ын Төлөөлөгч ямар үүрэг гүйцэтгэх боломжтойг төлөөлж буй орон нутгийнхаа жишээнд тулгуурлан хэлэлцэнэ. Багаар ажиллах хугацаа: 10 минут
- 2) Багийн ажлын үр дүнг баг тус бүр 1-2 минутад багтаан танилцуулна.
- 3) Нийтээр хэлэлцэж, нэгдсэн дүгнэлтэд хүрнэ. Хугацаа 5 минут
- 4) Орон нутгийн жишээнд тулгуурлан орон нутгийн хөрөнгө оруулалтын хэрэгцээг тодорхойлох, эрэмбэлэх, шийдвэр гаргах үйл явцад ИТХ-ын Төлөөлөгчийн гүйцэтгэх үүргийг тодорхойлсноор төсвийн төлөвлөлтийн үе шатанд Төлөөлөгч оролцох, мөн Засаг дарга болон ЗДТГ, төсвийн байгууллагууд, иргэд, иргэний нийгмийн байгууллагатай Төлөөлөгч хамтран ажиллах чиглэлээ олж харах боломжтой болно.

Арга зүйн лавлагаа 1

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙГ БОЛОВСРУУЛАХ, ХЭЛЭЛЦЭН БАТЛАХ ҮЙЛ ЯВЦ

Орон нутгийн төсвийг боловсруулж, бэлтгэх

Орон нутгийн төсвийн төслийг боловсруулж, өргөн барих асуудлыг Монгол Улсын Сангийн сайдын 2012 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр 244 тоот тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-аар (журмыг хавсралтаас үзэж болно) зохицуулж байна. Уг журамд орон нутгийн төсвийн төсөл боловсруулахад баримтлах зарчим, төсвийн удирдамж, орон нутгийн суурь төсвийн санал боловсруулах, тусгай сангуудыг төлөвлөх, төсвийн тодотголын төсөл боловсруулах, төсвийн төслийг боловсруулахад иргэдийн оролцоог хангах зэрэг асуудлыг тусгажээ.

ИТХ-ын бүрэн эрх

64.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал орон нутгийн төсвийн удирдлага, санхүүжилтийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

64.1.1.Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэлэлцэн батлах, хэрэгжилтэд хяналт тавих

64.1.2.тухайн жилийн төсөв, түүний тодотголын төслийг хэлэлцэн батлах, хэрэгжилтэд хяналт тавих, нийтэд мэдээлэх;

64.1.3.төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэн батлах;

64.1.4.төсвийн гүйцэтгэлийн болон санхүүгийн тайлангийн талаарх Засаг даргын мэдээллийг сонсох.

Төсвийн тухай Монгол улсын хуулийн 64 дүгээр зүйл

Төсвийн тухай хуулийн “төсвийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх, батлах” гэсэн 5-р бүлгийн 27-р зүйлд төсвийн төсөлд тавигдах шаардлага, 28-р зүйлд орон нутгийн төсвийн төслийг боловсруулж, ИТХ-д өргөн барих цаглабарыг тогтоосон.

Хүснэгт 3.1. Орон нутгийн төсвийн саналыг боловсруулж, хүргүүлэх цаглабар

Төсвийн захирагчийн түвшин	Төсвийн саналын төрөл	Төсвийн саналыг хүргүүлэх хугацаа	Хүргүүлэх төсвийн захирагч, байгууллага
Орон нутгийн төсөвт байгууллагын төсвийн шууд захирагч	Орон нутгийн төсвийн байгууллагын суурь төсвийн санал	Жил бүрийн 7 дугаар сарын 15-ны дотор	Сум, дүүргийн Засаг даргад

Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа улсын төсөвт байгууллагын төсвийн шууд захирагч	Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа тусгай зориулалтын шилжүүлгийн гэрээний үндсэн дээр санхүүжих улсын төсөвт байгууллагын суурь төсвийн санал		
Сум, дүүргийн Засаг дарга	Орон нутгийн төсөвт байгууллага болон тусгай зориулалтын гэрээний үндсэн дээр санхүүжих улсын төсвийн байгууллагын суурь төсвийн саналыг нэгтгэн	Жил бүрийн 7 дугаар сарын 25-ны дотор	Аймаг, нийслэлийн Засаг даргад
Аймаг, нийслэлийн Засаг дарга	Төлөөлөн гүйцэтгэх гэрээний үндсэн дээр санхүүжих улсын төсвийн байгууллагын суурь төсвийн саналыг	Жил бүрийн 8 дугаар сарын 1-ний дотор	Холбогдох төсвийн ерөнхийлөн захирагчид
	Орон нутгийн төсөвт байгууллагын суурь төсвийн саналыг ■ Үүнээс удирдлагын чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой хөрөнгийн суурь зардлын санал	Жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор	Сангийн яаманд
	Орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор дотоод, гадаадын хандив, тусламж авахаар бол холбогдох гэрээ, хэрэгжүүлэх хөтөлбөрийг төсвийн захирагч бүрээр боловсруулж, төсвийн төслийн хамт		
Сангийн яам	Орон нутгийн суурь төсвийн дэлгэрэнгүй мэдээллийг	Жил бүрийн 10 дугаар сарын 5-ны дотор	Аймаг, нийслэлийн Засаг даргад
Аймаг, нийслэлийн Засаг дарга	Жилийн төсвийн төслийг Сангийн яамнаас ирүүлсэн мэдээлэлд үндэслэн боловсруулж, танилцуулгын хамт	Жил бүрийн 11 дүгээр сарын 25-ны дотор	Тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд
Аймаг, нийслэлийн Засаг дарга	Тухайн шатны төсвийн төслийг	Жил бүрийн 11 дүгээр сарын 10-ны дотор	Аймаг, нийслэлийн аудиторт
Аймаг, нийслэлийн аудитор	Жилийн төсвийн төслийн талаарх дүгнэлтийг	Жил бүрийн 11 дүгээр сарын 25-ны дотор	Иргэдийн төлөөлөгчдийн хуралд

Эх сурвалж: Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журмын 4.3 дахь заалт

Засгийн газраас Улсын Их Хуралд улсын төсвийн төслийг жил бүрийн 10 дугаар сарын 1 гэхэд өргөн мэдүүлдэг бөгөөд 10 дугаар сарын 5 гэхэд сангийн яамнаас аймаг, нийслэлд орон нутгийн суурь орлого, зарлага, санхүүгийн дэмжлэг, орон нутгийн хөгжлийн сангийн тоог дэлгэрэнгүй эдийн засгийн ангиллаар мэдээлэл байдлаар суурь төсөв тооцоход хүргүүлнэ.

Мөн Улсын Их Хурлаар 11 дүгээр сарын 15-нд улсын төсөв батлагдахад төсөв хоорондын шилжүүлгийн батлагдсан тооцоог дэлгэрэнгүйгээр өгнө. Аймаг, нийслэл нь сум, дүүрэгтээ суурь төсвийн задаргааг нь хүргүүлнэ. Төсвийн байгууллага энэхүү хүргэгдсэн суурь төсвийн задаргааг үндэслэн 11-12 саруудад дараа жилийн төсвийг тооцон, түүнд шаардлагатай сарын санхүүжилтийн хуваарийг бэлтгэнэ. Ийнхүү төсвийн төслийг бэлтгэхдээ дээд шатнаас ирүүлсэн суурь зардлыг эдийн засгийн

ангилал хооронд зөвшөөрөгдсөн хүрээнд, өр үүсгэхгүйгээр хөдөлгөөнд оруулах эрхтэй ба төсвийн ерөнхийлөн захирагчаараа дамжуулан иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн батлуулж хэрэгжүүлнэ.

Улсын төсвийн тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын хувьд цалин хөлстэй холбоотой зардал болон нэг удаагийн тэтгэмж урамшуулал, бусад Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээнд тусгагдсан зардлыг хөдөлгөөнд оруулах боломжгүй ба гэрээнд тусгагдсан чиглэл зарчмыг удирдлага болгоно. Мөн төсвийн хуулиар олгогдсон төсвийн ерөнхийлөн захирагч, төвлөрүүлэн захирагч, шууд захирагчийн эрхээ хэрэгжүүлэх боломжтой.

ИТХ-аар төсвийг хэлэлцэн батлах

Төсвийн хуулиар төсөв батлах эрх бүхий байгууллага төсвийг батлахдаа шатлал бүрээр, түүнд харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч, тэдгээрийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүн, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ, тусгай сан, орлого, санхүүжүүлэх эх үүсвэр бүрээр нь батлана.

Төсөв батлагдахад Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих хөрөнгө оруулалт ба орон нутгийн хөрөнгийн эх үүсвэрээр санхүүжих хөрөнгө оруулалтын жагсаалтыг тусад нь хавсралтаар батладаг. Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр журмын хавсралт маягтыг ашиглана.

Төсвийн төслийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцэх явцад нэмж тусгах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг тухайн шатны төсвийг өргөн мэдүүлсэн этгээдээс төсвийн тухай хуулийн 29-р зүйлд заасан шаардлагыг хангаж байгаа эсэх талаар санал, дүгнэлтийг авсны үндсэн дээр тусгана гэж хуульчлагдсан байна. Өөрөөр хэлбэл, иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар төсвийг хэлэлцэж байхад хөрөнгө оруулалтын төсөл шинээр нэмэгдэхэд тухайн төслийн зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэл нь хийгдсэн, зохих зөвшөөрлүүд нь олгогдсон эсэхийг нягтална. Мөн тухайн хөрөнгө оруулалт нь ашиглалтад орсноор урсгал зардал, орон тоог нэмэгдүүлэхээр байна уу? гэдэг дүгнэлт хийгдсэн байх шаардлагатай бөгөөд хэрэв нэмэгдүүлэхээр бол тэрхүү зардлыг цаашид ямар эх үүсвэрээс шийдвэрлэх талаар тооцоо, тайлбарыг авч үзэх шаардлагатай. Түүнчлэн хөрөнгө оруулалтын төслийн эхний жилд тавигдах санхүүжилт нь төсөвт өртгийг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан дүнгээс багагүй байхаар тусгах шаардлагыг хуульчилсан тул хөрөнгө санхүүгийн боломжоо тооцох учиртай юм. Жишээлбэл, Ахуйн үйлчилгээний төвийг 200 сая төгрөгөөр 2 жилд хэрэгжүүлэх төсөл хэрэгжүүлнэ гэхэд эхний жилдээ 100 сая төгрөг нь тусгагдсан байхыг шаардана.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын хувьд иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцэх явцад иргэдийн саналыг аваагүй төслийг шинээр нэмж тусгах боломжгүй.

Аймаг, нийслэлийн Засаг дарга нь улсын төсөв УИХ-аар батлагдсанаас хойш 10 хоногт багтаан аймаг, нийслэлийнхээ дараа жилийн төсвийн төслийг, харин сум, дүүргийн Засаг дарга аймаг, нийслэлийн төсөв ИТХ-аар батлагдсанаас хойш 5 хоногийн дотор сум, дүүргийн төсвийн төслөө эцэслэн боловсруулж, тухайн шатны ИТХ-даа өргөн мэдүүлдэг болсон юм. Энэ нь тухайн шатны ИТХ орон нутгийн төсвийн төслөө хүлээн аваад 10 хоногийн хугацаанд танилцан хэлэлцэж, батлах боломжийг олгож байгаа болно.

Хүснэгт 3.2. Орон нутгийн төсвийн төслийг өргөн мэдүүлэх, хэлэлцэн батлах цаглабар

Орон нутгийн төсвийн төсөл	Засаг дарга ИТХ-д өргөн мэдүүлэх хугацаа	ИТХ тухайн шатны төсвийн хэлэлцэн батлах хугацаа
Аймаг, нийслэлийн дараа жилийн төсвийн төсөл	Жил бүрийн 11 дүгээр сарын 25-ны дотор	Жил бүрийн 12 дугаар сарын 05-ны дотор
Сум, дүүргийн дараа жилийн төсвийн төсөл	Жил бүрийн 12 дугаар сарын 10-ны дотор	Жил бүрийн 12 дугаар сарын 20-ны дотор

Төсвийн тухай хуулийн 8.5.5-д аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн шатны жилийн батлагдсан төсвийг 12-р сарын 31-ний дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (Сангийн яам)-д хүргүүлэхээр заажээ.

Орон нутгийн төсөв батлах талаар ИТХ-ын бүрэн эрх

68.1. Орон нутгийн төсөвт энэ хуулийн 33.2.1-33.2.7-д заасныг тусгаж, батална.
 68.2. Төсвийн төслийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцэх явцад нэмж тусгах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг тухайн шатны төсвийг өргөн мэдүүлсэн этгээдээс энэ хуулийн 29-р зүйлд заасан шаардлагыг хангаж байгаа эсэх талаар санал, дүгнэлтийг авсны үндсэн дээр тусгана.
 68.3. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан тухайн жилийн төсвийг ил тод, олон нийтэд хүртээмжтэй байдлаар мэдээнэ.

Төсвийн тухай Монгол улсын хуулийн 68-р зүйл

Аймаг, нийслэлийн ИТХ нь Засаг даргын өргөн мэдүүлсэн дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 11 дүгээр сарын 25-наас 12 дугаар сарын 5-ны дотор, харин сум, дүүргийн ИТХ нь жил бүрийн 12 дугаар сарын 10-20-ны өдрүүдэд хэлэлцэн баталж, тогтоол гаргана. Тухайлбал, сумын ИТХ нь орон нутгийн төсвийг баталсан тогтоолдоо дараах зүйлсийг заавал тусган гаргадаг. Үүнд:

- 1) Сумын тухайн оны төсвийн орлогын нийт дүн, орлогын нэр төрлийн хэмжээ
- 2) Сумын тухайн оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа байгууллага, бусад байгууллагын төвлөрүүлэх орлогын хэмжээ
- 3) Сумын тухайн оны орон нутгийн төсвийн зарлагын нийт дүн, төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн жилд зарцуулах зарлагын дээд хэмжээ
- 4) Тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжих төсөвт байгууллагын зардлын хэмжээ
- 5) Сумаас аймгийн төсөвт төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ
- 6) Урьд оны үлдэгдлээс санхүүжих урсгал зардлын дүн, хөрөнгийн зардлын дүн
- 7) Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүн
- 8) Сумын хөрөнгө оруулалт, их засварын нэр төрөл, төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт
- 9) Төсөвтэй холбоотой бусад заалт.

Төсвийн тухай хуулиар сум, дүүргийн Засаг дарга иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлагдсан орон нутгийн төсвийг түүнийг баталснаас хойш ажлын 7 өдрийн дотор аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлэхээр заажээ.

ИТХ-аар орон нутгийн төсвийг хэлэлцэн батлахад анхаарвал зохих зүйлс:

- Орон нутгийн төсвийн орлогыг үндэслэлтэйгээр тооцож батлах, хийсвэрээр өсгөхгүй байх;
- Хууль тогтоомжоор тухайн шатны хуралд олгогдсон эрх хэмжээний хүрээнд төлбөр, хураамж ногдуулах, цуглуулах асуудлыг шийдвэрлэх;
- Орон нутгийн төсвийн байгууллагын болон тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжих улсын төсөвт

байгууллагын зардлыг үндэслэл, тооцоогүйгээр өсгөж батлахгүй байх;

- Эх үүсвэргүй урсгал болон хөрөнгийн зардал батлахгүй байх;
- Төсвийн шийдвэрийг гаргахдаа орон нутгийн хөгжлийн урт болон дунд хугацааны бодлого, төлөвлөгөө, иргэдээс гарсан саналд тулгуурлан нийтийн эрх ашигт нийцсэн төсөл, арга хэмжээ, үйл ажиллагааг санхүүжүүлэхэд анхаарах нь чухал.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ төсвийн төсөл хэлэлцэж батлах үйл ажиллагааг хурлын дотоод дэгээр зохицуулах бөгөөд тухайн хурлын онцлог байдалд тохируулан төсөв хэлэлцэж батлах тусгай журам гарган мөрдөж болно.

3.3. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТ, ТҮҮНИЙ ИЛ ТОД БАЙДАЛД ИТХ-ААС ХЭРЭГЖҮҮЛЭХ ХЯНАЛТ

3.3.1. Орон нутгийн төсвийн зарцуулалт, ил тод байдалд ИТХ-аас хяналт тавих шаардлага

Үргэлжлэх хугацаа: 20 минут

ИТХ-аас төсөвт хяналт тавих арга, хэлбэр

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас хэрэгжүүлдэг үндсэн чиг үүргүүдийн нэг нь хяналтын чиг үүрэг юм. Хяналтын чиг үүргийн хүрээнд ИТХ нь батласан шийдвэрийнхээ хэрэгжилтийг хянах, батлан гаргасан журам, төсөв, төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байгаа эсэхийг ажлын хороод, тэргүүлэгчид, Төлөөлөгчдөөрөө дамжуулан, эсвэл мэргэжлийн байгууллага, иргэд, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран хянаж шалгах үйл ажиллагаа явуулдаг.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ бүрэн эрхийнхээ дагуу төсвийн хяналтыг дараах чиглэлээр хэрэгжүүлж болно. Үүнд:

- Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг батлах, тайланг хэлэлцэж үнэлэлт дүгнэлт өгөхдөө түүнд шаардлагатай төсвийг хянах
- Орон нутгийн төсвийн орлого, зарлагын төсөл, жилийн төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг хэлэлцэн батлах
- Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт, зарлага санхүүжилтийн байдлыг хянах
- Орон нутгийн төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны хэрэгжилтийг хянах
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэлэлцэх, төлөвлөх үйл явц, хөрөнгийн зарцуулалт, төслийн хэрэгжилтийн явц, үр дүнг хянан шинжилж, үнэлэх
- Орон нутгийн байгууллагуудын Шилэн дансны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих гэх мэт.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлынхны хувьд орон нутгийн төсөв, санхүүгийн байдал, Засаг даргын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэхэд дараах мэдээллүүдтэй ажиллах боломжтой байна. Үүнд:

1. Төсвийн байгууллагын зорилго, зорилт хангагдсан эсэх
2. Холбогдох хууль, тогтоомж, тогтоол шийдвэр, дүрэм журмуудыг үйл ажиллагаандаа мөрдөж байгаа байдал;
3. Жилийн төсвийн гүйцэтгэл болон төсвийн төлөвлөгөөнд аудитын байгууллагын гаргасан зөвлөмж, тайлан, түүний мөрөөр хэрэгжүүлэх ажлыг хэрэгжүүлсэн эсэх;
4. Байгууллагын хувьд жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, түүний тайлан;

5. Байгууллагын шилэн дансны үйл ажиллагаа, шилэн дансны цахим хуудсанд тавигдсан мэдээлэл;
6. Орон нутгийн төсвийн сар, улирал, хагас жил болон жилийн тайлан гүйцэтгэлийн мэдээ, үүнд төсвийн орлого, зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэл орно.
7. Засаг даргын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан, Засаг даргын улсын төсвийн ерөнхийлөн захирагчтай хийсэн гэрээний хэрэгжилтийн тайлан;
8. Орон нутгийн төсвийн худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан;
9. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэл тайланг үнэлэх;
10. ИТХ-ын тогтоолын хавсралтаар батлагдсан тухайн байгууллагын хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнгийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлантай ажиллах бүрэн боломжтой байна.
11. Мөн бусад нэмэлт мэдээллүүд орно.

Эдгээр мэдээллийг ашиглан ИТХ-ын Төлөөлөгчид болон Иргэний зөвлөл, иргэд, Иргэний нийгмийн төлөөллийг оролцуулан төсвийн орлого бүрдүүлэлт, зарлага санхүүжилтийн байдалд төлөвлөгөөт болон урьдчилсан хяналтыг ИТХ-аас хэрэгжүүлэх бүрэн боломжтой.

Орон нутгийн төсөвт ИТХ-аас тавих хяналтыг хэрэгжүүлж буй зарим сайн туршлагыг дурдаж болно. Тухайлбал,

- ♦ Өвөрхангай аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид 2014 оны 38-р тогтоолоор “Нутгийн удирдлагын байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх журам”-ыг батлан мөрдүүлж байна¹. Үүний зэрэгцээ тус аймгийн ИТХ “Иргэдийг чадавхижуулах замаар хяналтыг нэмэгдүүлэх нь” тэтгэлгийн хүрээнд ОНХС-гийн хөрөнгө оруулалтын ажлын төлөвлөлтөд иргэдийн саналыг авах, эрэмбэлэх ажлыг сүүлийн 2 жил орон нутагтаа үйл ажиллагаа явуулж байгаа иргэний нийгмийн байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлэх замаар иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж² байна. Мөн аймгийн 19 сумаас орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн ИТХ-аас үнэлгээний хороонд иргэний төлөөллөө оролцуулж буй байдалд мониторинг хийдгээс гадна “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр хийгдэж байгаа бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлд хяналт тавих “Иргэний хяналт” багийн ажиллах журам”-ыг гарган эдгээр багууд ИТХ-ын хуулиар олгогдсон эрх хэмжээний дагуу хуралтайгаа хамтран ажиллаж чадавхижин туршлагажиж байна.
- ♦ Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын ИТХ, багийн ИНХ-ын дэргэд Хяналтын хороог 7 төлөөлөгчийн бүрэлдэхүүнтэй ажиллуулж³, сум хөгжүүлэх сангийн хөрөнгө, ОНХС-гийн хөрөнгө, төсвийн зарцуулалт, суманд хэрэгжиж байгаа тендер шалгаруулалтад оролцон шалгарсан компани, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны явц, үр дүн, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьдаг болсон.
- ♦ Сүхбаатар аймгийн ИТХ нь “ОНХС-гийн үйл ажиллагааны хэрэгжилтэнд аймгийн ИТХ-аас хяналт тавих, санал зөвлөмжөөр хангах нь” гэсэн чиглэлээр

¹ Орон нутгийн хөгжлийн хүрээлэн (2016). Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлуудын сайн туршлагын эмхэтгэл. Улаанбаатар, 8-9 дэх тал

² УИХТГ, ШХА, НҮБХХ (2016). Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг бэхжүүлэх нь” төсөл. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг дэмжих тэтгэлэг: Сайн туршлагын эмхэтгэл. Улаанбаатар, 105-112 дахь тал.

³ Орон нутгийн хөгжлийн хүрээлэн (2016). Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлуудын сайн туршлагын эмхэтгэл. Улаанбаатар, 9-11 дэх тал

тэтгэлэг авч ОНХС-гийн хөрөнгийг төлөвлөх, зарцуулах, тайлагнах, хэрэгжилтэнд тавих хяналтад иргэд хэрхэн оролцох боломжтой талаар сургалт явуулж, Халзан, Асгат, Баруун-Урт, Уулбаян, Түмэнцогт сумд иргэдийн оролцоотой хяналтын зөвлөл байгуулан ажиллаж байна⁴. Мөн Уулбаян суманд Засаг даргын захирамжаар ОНХС-гаар хийгдсэн бүтээн байгуулалтын ажлаа сумын албан тушаалтнууд, ТАХ-дад хариуцуулан өгч эзэнжүүлжээ.

- ♦ Баян-Өлгий аймгийн ИТХ хяналтын чиг үүргээ иргэдтэйгээ хамтран⁵ хэрэгжүүлэхээр аймгийн хэмжээнд болон сумдад ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэж байгаа болон хийгдсэн бүтээн байгуулалтын ажлын явц, үр дүнд хяналт шалгалт хийх ажлын хэсгийг аймгийн ИТХ-ын төлөөлөгчдөөр ахлуулж, сум бүрийг хуваарилан ажиллажээ.
- ♦ Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын ИТХ ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэж байгаа ажилд иргэдийн хяналтыг бий болгох зорилгоор “ОНХС-гийн хэрэгжилтэд хяналт тавих зөвлөл”-ийг иргэдийн болон төрийн бус байгууллагын төлөөллөөс оролцуулан 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан⁶ ажиллуулдаг болжээ.
- ♦ Дундговь аймгийн Дэрэн сумын ИТХ бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажилд иргэдийнхээ хяналт, оролцоог нэмэгдүүлэх⁷ чиглэлээр сумын ИТХ-ын дэргэд бодлогын 4 хороо байгуулан ажиллаж байна.

Төсвийг ил тод болгох шаардлага

Сүүлийн жилүүдэд Монгол улсын төрөөс төсвийн төвлөрлийг сааруулах, орон нутгийн эрх мэдлийг нэмэгдүүлэх чиглэлээр дэс дараалсан арга хэмжээ авч хэрэгжүүлж байна. Тухайлбал, орон нутгийн төсвөөс хөгжлийн сангийн хөрөнгийг тусгайлан баталж, зарцуулалтыг нь иргэдийн саналаар шийдвэрлэдэг болж орон нутагт иргэдийн дунд нээлттэй хэлэлцүүлгүүд өрнүүлдэг боллоо. Мөн төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах үүднээс олон нийтийн оролцоог бага багаар нэмэгдүүлж байна.

Төсвийн харилцааны шинэ нөхцөлд түүний ил тод, нээлттэй байдлыг хангах зорилт чухлаар тавигдаж, орон нутгийн төсвийг иргэд, олон нийтийн идэвхтэй оролцоогүйгээр бодитой төлөвлөх, хянах боломжгүй болж байна. Иргэд, татвар төлөгчдийн оршин суугаа газар нутаг, өдөр тутмын ажил, амьдралтай шууд холбоотой төсвийн үнэн зөв мэдээллийг ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар өгч байх нь тэдний зүгээс төсвийн үйл явцад анхаарлаа хандуулж бүтээлчээр оролцох үндсэн нөхцөл болдог.

Төсвийн талаар төрөөс, ялангуяа нутгийн удирдлагын зүгээс хүлээх хариуцлагыг тодорхой болгож, төсвийн талаарх мэдээллээр олон нийтийг хангаж, төсвийг

⁴ УИХТГ, ШХА, НҮБХХ (2016). Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг бэхжүүлэх нь” төсөл. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг дэмжих тэтгэлэг: Сайн туршлагын эмхэтгэл. Улаанбаатар, 113-116 дахь тал.

⁵ Орон нутгийн хөгжлийн хүрээлэн (2016). Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлуудын сайн туршлагын эмхэтгэл. Улаанбаатар, 34-36 дахь тал

⁶ УИХТГ, ШХА, НҮБХХ (2016). Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг бэхжүүлэх нь” төсөл. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг дэмжих тэтгэлэг: Сайн туршлагын эмхэтгэл. Улаанбаатар, 192-193 дахь тал.

⁷ Орон нутгийн хөгжлийн хүрээлэн (2016). Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлуудын сайн туршлагын эмхэтгэл. Улаанбаатар, 92-94 дэх тал

боловсруулах, хэрэгжүүлэх үйл явц дахь иргэдийн оролцоог нэмэгдүүлэх нь сайн засаглалыг төлөвшүүлэхэд чухал ач холбогдолтой.

Төсвийн ил тод байдал хангагдаагүй тохиолдолд олон нийтийн оролцоо бий болохгүй бөгөөд энэ нь мөн төсвийн бодлогыг боловсруулах үйл явц дахь олон нийтийн хэлэлцүүлгийн хамрах хүрээ, агуулгыг хязгаарлах болно. Нөгөө талаас, төсвийн үйл явц ил тод байх нь бодлого боловсруулагчдад хариуцлагын мэдрэмжийг бий болгох; төрөөс хариуцлагатай, шударга шийдвэр гаргадаг болгох; ирээдүйн хөгжлийн талаар илүү сайн төсөөлөл, стратегийг тодорхойлох; төсвийн төслийг цаг хугацаанд нь, үр дүнтэй боловсруулж хэрэгжүүлэхийг дэмжих; төсвийн үйл явцад хуулийн дагуу илүү сайн хяналт тавих; олон нийтийн хүсэл эрмэлзэл, итгэлийг бий болгох, түүнчлэн Засгийн газар, нутгийн удирдлага хүнийхээ төлөө ажиллах чадварыг бий болгоход хувь нэмрээ оруулдаг.

Төсвийн ил тод байдлын ойлголт нь ихэвчлэн төсвийн үйл явцын нээлттэй байдал, энэ үйл явцад олон нийтийг оролцуулах боломжтой холбоотой. Ил тод төсвийн үйл явц нь иргэд төр, орон нутгийн бодлого, тэргүүлэх чиглэлийг тодорхойлоход оролцох боломжит орон зайг бий болгодог хэдий ч оролцоонд тулгуурлан хариуцлагатайгаар шийдвэр гаргахыг баталгаажуулна гэсэн үг биш юм. Олон нийтийн оролцоог хангахуйц байхын тулд төсвийн үйл явц нь улсын болон орон нутгийн түвшинд аль алинд нь ил тод байх хэрэгтэй.

Төсвийн тухай хуульд төсвийн ил тод байдлыг хангасан байх, хариуцлагатай байх үндсэн зарчмуудыг тодорхойлж, эдгээр зарчмыг хэрэгжүүлэхдээ төсөв хэлэлцэх, батлах үйл ажиллагааг нээлттэй байлгаж, төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл, тайлангийн талаар тогтоосон хугацаанд нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар мэдээлэх, төсвийн асуудлаар иргэд, төрийн бус байгууллагаас гаргасан санал, дүгнэлтийг эрх бүхий этгээд нь шийдвэртээ хэрхэн тусгасан тухай, төсвийн үйл ажиллагаан дахь олон нийтийн оролцоог хангаж ажилласан дүнг тэдэнд тухай бүр танилцуулж байхыг үүрэг болгосон билээ. Түүнчлэн УИХ-аас Шилэн дансны тухай хуулийг батлан гаргаж, энэхүү хуулийг хэрэгжүүлэх зорилгоор “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ыг Засгийн газрын 2016 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн 29 дүгээр тогтоолоор баталжээ.

Энэ журам нь шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоож, уг цахим хуудсанд мэдээлэл тавихтай холбогдсон харилцааг зохицуулах зорилготойгоос гадна төрийн байгууллага, албан газар, төрийн өмчит хуулийн этгээд, үйлдвэрийн газар, хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани, улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч нь шилэн дансны цахим хуудсанд хууль, журамд заасны дагуу холбогдох мэдээллийг тавих үүрэгтэй гэдгийг тогтоож өгсөн.

Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангах зорилгоор бүх шатны төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь батлагдсан жилийн төсөв, түүний гүйцэтгэл, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт, тэдгээртэй холбоотой гаргасан шийдвэр, томоохон хэмжээний мөнгөн гүйлгээний талаарх мэдээллийг олон нийтэд нээлттэй болгох шаардлагатай юм. Энэхүү зохицуулалтад хууль тогтоомжийн дагуу төрийн нууцад

хамаарах төсөв, үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон гүйцэтгэх ажил эрхлэх эрх бүхий байгууллагын гүйцэтгэх ажилтай холбоотой төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагнал хамаарахгүй байна.

Төсвийн байгууллага мэдээллийг олон нийтэд хүргэхдээ мэдээллийн самбар, цахим болон хэвлэмэл хуудас, мэдээллийн бусад хэрэгсэл ашиглах боломжтой бөгөөд цахим болон мэдээллийн бусад хэлбэр ашиглаж байгаагаас үл хамааран мэдээллийн самбарыг заавал ажиллуулсан байхыг хууль, журамд заажээ.

Хэрэв төсвийн байгууллага цахим хуудастай бол тус цахим хуудсанд “байгууллагын төсөв” гэсэн цэс үүсгэн тэрхүү цэсэнд төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл болон дунд хугацааны зорилго, зорилт, үйл ажиллагааны стратегийн мэдээллүүдээ оруулах, шинэчлэн байршуулах үйл ажиллагааг тухай бүр хэрэгжүүлнэ. Мөн аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн төлөвлөлтийн хариуцсан нэгж тухайн шатны төсвийн сар, улирлын хуваарь, түүнд хийсэн зохицуулалтын тухай цахим хэлбэрээр болон бусад мэдээллийн хэрэгслээр олон нийтэд тухай бүр мэдээлэхээр зохицуулагджээ.

Орон нутгийн төсвийн үйл явцын мэдээлэл ба баримт бичгийг ил болгох цаглабар, хэлбэр

Аймаг, нийслэл, сум, дүүргийн түвшинд орон нутгийн төсвийн үйл явцын мэдээлэл болон төсвийн баримт бичгийг олон ниуйтэд ил тод болгох цаглабар, төсвийн мэдээллийг ил тод болгох маягт, хэлбэрийг дараах хүснэгтэд нэгтгэн харууллаа.

Хүснэгт 3.3. Орон нутгийн төсвийн үйл явцын мэдээлэл ба баримт бичгийг ил болгох цаглабар

Ил тод болгох хугацаа	Төсвийн баримт бичиг ба үйл явц	Төсвийн мэдээллийг ил тод болгох маягт, хэлбэр
Сар бүрийн 8-ны дотор (жилд 12 удаа)	Төсвийн гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн сар (улирал, хагас, бүтэн жил)*-ын мэдээ	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.1.2, 2, 20-р хавсралт (цахим)
	Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, концессийн зүйлийн сар (улирал, хагас, бүтэн жил)-ын мэдээ	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.1.4, 3-р хавсралт (цахим)
	Улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын гүйцэтгэлийн сар (улирал, хагас, бүтэн жил)-ын мэдээ	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.1.5, 4-р хавсралт (цахим)
	Засгийн газрын болон орон нутгийн тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн сар (улирал, хагас, бүтэн жил)-ын мэдээ	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.1.8, 2-р хавсралт (цахим)
	Орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэлийн сар (улирал, хагас, бүтэн жил)-ын мэдээ	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.1.15 11-р хавсралт (цахим)
Жил бүрийн 1-р сарын 10-ны дотор	ТЕЗ-ийн тухайн жилийн төсвийн хөтөлбөр, батлагдсан төсөв	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.1.2, 2, 20-р хавсралт (цахим)
	ТЕЗ-ийн тухайн жилийн төсвийн хөтөлбөр, хөтөлбөрийн үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлтийн төлөвлөгөө	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.1.1, 1-р хавсралт (цахим)
	Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жилийн төлөвлөгөө, концессийн зүйлийн жагсаалт	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.1.4, 3-р хавсралт (цахим)
	Засгийн газрын болон орон нутгийн тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.1.8, 2-р хавсралт (цахим)
	Тухайн оны худалдан авах ажиллагааны жилийн төлөвлөгөө	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.1.14 21-р хавсралт (цахим)

Жил бүрийн 1-р сарын 15-ны дотор	Өмнөх оны худалдан авах ажиллагааны жилийн тайлан	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.1.14 22-р хавсралт (цахим)
Жил бүрийн 1-р сарын 10-ны дотор	Тухайн оны Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.1.15 11-р хавсралт (цахим)
Жил бүрийн 4-р сарын 25-ны дотор	ТЕЗ-ийн өмнөх оны төсвийн хөтөлбөр, хөтөлбөрийн үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлтийн жилийн эцсийн тайлан	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.1.1, 1-р хавсралт (цахим)
	Өмнөх оны жилийн эцсийн санхүүгийн тайлан (төсвийн гүйцэтгэлийн тайлан)	Төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн маягтуудаар. МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.1.9 (цахим, PDF форматаар)
	Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан жилийн тайлан	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.2.6, 5-р хавсралт (цахим)
	Өмнөх оны хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын жилийн тайлан	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.2.7, 6-р хавсралт (цахим)
	Өмнөх оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын дүгнэлт	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.1.10 (цахим, PDF форматаар)
Жил бүрийн 7-р сарын 1-ний дотор	Өмнөх оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.1.11 (цахим, PDF форматаар)
Жил бүрийн 7-р сарын 15-ны дотор	Сум, дүүргийн төсвийн байгууллага (ТШЗ)-ын дараа жилийн төсвийн санал	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.2.3 (цахим, PDF форматаар)
Жил бүрийн 7-р сарын 25-ны дотор	Аймаг, нийслэлийн төсвийн байгууллага (ТШЗ)-ын дараа жилийн төсвийн санал	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.2.3 (цахим, PDF форматаар)
	Сум, дүүргийн төсвийн зрөнхийлөн болон төвлөрүүлэн захирагч (ТЕЗ, ТТЗ)-ын дараа жилийн төсвийн төсөл	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.1.16 (цахим, PDF форматаар)
Жил бүрийн 8-р сарын 1-ний дотор	Аймаг, нийслэлийн төсвийн төвлөрүүлэн захирагч (ТТЗ)-ын дараа жилийн төсвийн төсөл	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.1.16 (цахим, PDF форматаар)
Жил бүрийн 8-р сарын 15-ны дотор	Аймаг, нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагч (ТЕЗ)-ийн дараа жилийн төсвийн төсөл	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.1.16 (цахим, PDF форматаар)
	Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан хагас жилийн тайлан	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.2.6, 5-р хавсралт (цахим)
	2015 оны хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын хагас жилийн тайлан	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.2.7, 6-р хавсралт (цахим)
	2015 оны хагас жилийн санхүүгийн тайлан (төсвийн гүйцэтгэлийн тайлан)	Төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн маягтуудаар. МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.1.9 (цахим, PDF форматаар)
Жил бүрийн 9-р сарын 15-ны дотор	2016 оны төсвийн төсөл	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.1.16 (цахим, PDF форматаар)
Жил бүрийн 9-11-р сард	Аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр дараа жилд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний талаар санал асуулга явуулж, иргэд, олон нийтийн санал авах явц, урьдчилсан жагсаалт боловсруулж хэлэлцүүлэх, өргөн барих үйл явц, үр дүнгийн мэдээлэл	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.1.15 11-р хавсралт (цахим)
Жил бүрийн 11-р сарын 10-ны дотор	Аймаг, нийслэлийн Засаг даргаас Аймаг, нийслэлийн ерөнхий аудиторт хүргүүлсэн	ТЕЗ-ын төсвийн төсөл, төсвийн төсөөлөл боловсруулах удирдамжийн

	дараа жилийн төсвийн төсөл	хавсралт
Жил бүрийн 11-р сарын 25-ны дотор	Дараа жилийн төсвийн төсөлд аймаг, нийслэлийн ерөнхий аудиторовн өгсөн дүгнэлт	Аймаг, нийслэлийн ерөнхий аудиторовн өгсөн дүгнэлтийг бүрэн эхээр нь цахимаар
	Аймаг, нийслэлийн Засаг даргаас аймаг, нийслэлийн ИТХ-д өргөн мэдүүлсэн дараа жилийн төсвийн төсөл	Сангийн сайдын 2012 оны 244-р тушаал, Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журмын 2-р хавсралт
Жил бүрийн 12-р сарын 5-ны дотор	Аймаг, нийслэлийн дараа жилийн төсвийн төслийг хэлэлцэж батлах ИТХ-ын хуралдааны ил тод байдал	Жил бүрийн 12-р сарын 5-наас өмнө хуралдсан байдлаар
Жил бүрийн 12-р сарын 10-ны дотор	Сум, лүүргийн Засаг даргаас сум, дүүргийн ИТХ-д өргөн мэдүүлсэн дараа жилийн төсвийн төсөл	Сангийн сайдын 2012 оны 244-р тушаал, Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журмын 2-р хавсралт
Жил бүрийн 12-р сарын 20-ны дотор	Сум, дүүргийн дараа жилийн төсвийн төслийг хэлэлцэж батлах ИТХ-ын хуралдааны ил тод байдал	Жил бүрийн 12-р сарын 20-ноос өмнө хуралдсан байдлаар
Жил бүрийн 12-р сарын 31-ний дотор	Дараа оны батлагдсан төсвийн сар, улирлын хуваарь	Аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн сар, улирлын хуваарийн маягтаар
1, 4, 7, 10-р сарын 20-ны дотор (Жилд 4 удаа)	Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын улирал бүрийн нөөц хөрөнгийн ил тод байдал	Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн маягтаар
Жилийн турш (батлагдсанаас хойш 7 хоногийн дотор)	Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.1.3, 1, 2, 20-р хавсралт (цахим)
Жилийн турш (үнэлгээний хорооны дүгнэлт гарснаас хойш 7 хоногийн дотор)	Хөрөнгийн болон урсгал зардалд тусгасан арга хэмжээний тендер шалгаруулалтын ерөнхий мэдээлэл	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.1.6, 7-р хавсралт (цахим)
Жилийн турш (шийдвэр гарснаас хойш 7 хоногийн дотор)	Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээ (гэрээ, хэлцэл хийсэн, санхүүжилт өгснөөс хойш)	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.2.9, 8-р хавсралт (цахим)
Жилийн турш (гүйлгээ хийснээс хойш 7 хоногийн дотор)	Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ бүрийг холбогдох шийдвэрийн хамт	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.2.10 9-р хавсралт (цахим)
Жилийн турш (шийдвэр гарснаас хойш 7 хоногийн дотор)	Зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулсан гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулсан, өр авлага үүсгэсэн тухай шийдвэр	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.1.7, 10-р хавсралт (цахим, PDF форматаар)
Жилийн турш (дүн гарснаас хойш 7 хоногийн дотор)	Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.1.13 (цахим, PDF форматаар)
Тодотгол хийсэн тухай бүр	Аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн тодотгол (хэрвээ тодотгол хийгдсэн бол)	Тодотгол хийсэн бол тухай бүр

* Сар (улирал, хагас, бүтэн жил)-ын мэдээ-сар бүрийн мэдээг дараа сарын 8-ны дотор гаргана, улирал бүрийн сүүлийн сарын мэдээ нь улирлын, 6-р сарын мэдээ хагас жилийн, 12-р сарын мэдээ бүтэн жилийн мэдээ байдлаар гарна гэсэн үг.

Аймаг, нийслэл, дүүргийн төсвийн ил тод байдлын хэрэгжилт

Орон нутгийн төсвийн ил тод байдлыг аймаг, нийслэлийн түвшинд үнэлэх анхны судалгааг 2010-2011 онд Олон улсын төсвийн түншлэл байгууллагын Нээлттэй төсвийн санаачилгын санхүүжилт, арга зүйн дэмжлэгтэйгээр Нээлттэй Нийгэм Форум (ННФ), “Иргэд төсвөө хянана” иргэний нийгмийн сүлжээ хамтран⁸ гүйцэтгэсэн байдаг. Орон

⁸ ННФ (2011). Орон нутгийн төсвийн ил тод байдал - 2011, Улаанбаатар

нутгийн төсвийн ил тод байдалд гарч буй өөрчлөлтийг тодорхойлох үүднээс энэхүү судалгааг хоёр жил тутамд хийдэг болсон бөгөөд “Орон нутгийн төсвийн ил тод байдал - 2013” судалгааг 2013-2014 онд ННФ-ын санхүүжилтээр иргэний нийгмийн байгууллагууд хамтран хийсэн⁹ байна.

Аймаг, нийслэлийн төсвийн ил тод байдлыг 2013 онд үнэлсний дараа Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар УИХ-д өргөн барьсан Шилэн дансны тухай хууль (ШДТХ) 2014 оны 7 дугаар сарын 15-ны өдөр батлагдаж, 2015 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдсөн. Уг хуулийг батлан хэрэгжүүлж эхэлсэнтэй холбогдуулан Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн төсөв, худалдан авах ажиллагааны ил тод байдалтай холбоотой заалтуудыг хүчингүй болгож, Шилэн дансны хуулиар зохицуулах болсон юм. Үүнээс гадна Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ыг батлан гаргаж, улсын болон орон нутгийн төсвийн байгууллагууд, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд дагаж мөрдөн ажиллаж байна. Ийнхүү төсвийн ил тод байдлын хууль, эрх зүйн зохицуулалт сайжирч, хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд буюу 2015 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс 2016 оны 6 дугаар сарын 1-нийг хүртэлх хугацаанд аймаг, нийслэл, дүүргийн түвшинд ил тод болговол зохих төсвийн үйл явцын мэдээлэл ба баримт бичгийг хамруулан “Орон нутгийн төсвийн ил тод байдал – 2016” судалгааг Нээлттэй Нийгэм Форум, “Иргэд төсвөө хянана” иргэний нийгмийн сүлжээ хамтран гүйцэтгэжээ.

Орон нутгийн төсвийн буюу аймаг, нийслэл, дүүргийн төсвийн ил тод байдлын үнэлгээ нь “Төсвийн ил тод байдлыг нутгийн удирдлагаас гаргасан эрх зүйн баримт бичигт тусгасан байдал”, “Төсвийн үйл явц, баримт бичгийн ил тод байдал” гэсэн 2 үндсэн хэсгээс бүрдэнэ. Нэгдсэн үнэлгээг гаргахдаа төсвийн ил тод байдлыг эрх зүйн баримт бичигт тусгасан байдал болон төсвийн үйл явц, баримт бичгүүдийн ил тод байдлыг харуулах нийт 12 үзүүлэлт тус бүрийн дундаж оноогоор тооцож, үнэлгээг нэгтгэхдээ 21 аймаг, нийслэлийг хооронд нь, нийслэлийн 9 дүүргийг хооронд нь харьцуулсан байна.

⁹ ННФ (2014). Орон нутгийн төсвийн ил тод байдал - 2013, Улаанбаатар

Хүснэгт 3.4. Аймаг, нийслэлийн төсвийн ил тод байдлын индекс тооцсон байдал (Нийт авбал зохих оноо: 100), хувиар

№	Аймаг, нийслэл	Эрх зүйн баримт бичиг	Төсвийн төсөл	ИТХ-ын хуралдаан	Баглагдсан төсөв	Иргэний төсөв	Төсвийн тодотгол	Хөрөнгө оруулалт, ХАА	Төсвийн гүйцэтгэл	Орон нутгийн хөгжлийн сан	Засаг даргын ноёд хөрөнгө	Орон нутгийн тусгай сангууд	Хандив, тусламжийн хөрөнгийн зарцуулалт	Нэгдсэн үнэлгээ	Рейтинг
1	Хөвсгөл	58	45	91	82	0	50	65	82	17	50	75	88	58.5	Дунджаас дээш
2	Сэлэнгэ	63	29	59	77	0	50	63	76	47	100	58	25	53.9	
3	Говьсүмбэр	50	31	38	68	0	31	73	68	38	75	75	63	50.8	
4	Увс	44	31	60	71	0	63	59	61	17	0	75	75	46.3	
5	Сүхбаатар	50	15	53	32	0	31	54	82	22	50	75	87	45.9	
6	Говь-Алтай	28	31	46	77	0	63	50	71	36	42	75	13	44.3	
7	Завхан	41	34	47	39	0	38	36	39	42	50	75	88	44.1	
8	Өмнөговь	65	28	45	77	0	56	67	75	31	25	25	0	41.2	Дундаж
9	Улаанбаатар	40	19	62	54	0	62	39	57	19	0	50	88	40.8	
10	Баянхонгор	25	5	50	71	0	63	50	80	13	25	50	38	39.2	
11	Өвөрхангай	51	4	50	69	0	44	58	52	4	0	50	75	38.1	
12	Төв	49	10	59	65	0	44	51	69	21	0	42	46	38.0	
13	Орхон	34	16	30	43	0	19	48	71	25	25	75	62	37.3	
14	Дархан-Уул	44	21	47	55	0	6	35	62	29	25	25	88	36.4	
15	Хэнтий	38	10	47	57	0	37	62	68	38	0	75	0	36.0	Дунджаас доош
16	Ховд	13	22	55	61	0	31	45	61	8	0	75	50	35.1	
17	Булган	19	22	37	71	0	31	68	75	17	0	75	0	34.6	
18	Архангай	31	16	62	44	0	19	36	64	17	25	75	25	34.5	
19	Дорноговь	14	10	27	64	0	19	43	75	8	0	75	38	31.1	
20	Дорнод	25	12	42	43	0	25	57	54	0	0	25	37	26.7	
21	Дундговь	25	3	28	64	0	6	58	68	21	0	0	13	23.7	
22	Баян-Өлгий	25	15	5	43	0	13	33	33	8	0	67	8	20.8	
Дундаж оноо		37.8	19.5	47.3	60.3	0.0	36.5	52.3	65.6	21.7	22.4	58.7	45.9	39.0	

Орон нутгийн төсвийн ил тод байдлын үнэлгээг аймаг, нийслэлийн дунджаар тооцвол нийт авбал зохих 100 онооны 39.0 хувийг авсан нь орон нутгийн төсвийн ил тод байдал хангалттай түвшинд хүрч чадаагүй байгааг харуулна. Хөвсгөл аймаг хамгийн өндөр буюу 58.5 хувьтай үнэлэгдсэн бол Баян-Өлгий аймгийн үнэлгээ 20.8 хувьтай гарсан байна.

Аймаг, нийслэлийн төсвийн ил тод байдлын үнэлгээний дээд оноо нь 58.5 байгаа учир аймаг, нийслэлийн үнэлэгдсэн дундаж үзүүлэлтэд үндэслэн орон нутгийн төсвийн ил тод байдлын өнөөгийн түвшинг үнэлэхэд “дунджаас дээш (44-өөс дээш оноотой)” гэсэн үнэлгээг Хөвсгөл, Сэлэнгэ, Говьсүмбэр, Увс, Сүхбаатар, Говь-Алтай, Завхан аймгууд авсан бол “дундаж (36-41 оноотой)” гэсэн үнэлгээтэй Улаанбаатар хот, Өмнөговь, Баянхонгор, Өвөрхангай, Төв, Орхон, Дархан-Уул, Хэнтий аймгууд байна. Харин бусад аймгууд буюу Ховд, Булган, Архангай, Дорноговь, Дорнод, Дундговь, Баян-Өлгий “дунджаас доош (20-35 оноотой)” түвшинд хамаарагдаж байна.

Энэ нь аймаг, нийслэлийн түвшинд төсвийн ил тод, нээлттэй байдал “нэн хангалтгүй, хангалтгүй байна” гэсэн өмнөх судалгаануудын үр дүнтэй адил байгааг харуулна. Өөрөөр хэлбэл, Шилэн дансны тухай хууль батлагдаж хэрэгжин төсвийн ил тод байдлыг хангах хууль эрхзүйн зохицуулалт хангалттай түвшинд шинэчлэгдсэн боловч хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх чиглэлээр дорвитой ахиц гарсангүй гэсэн дүгнэлтэд хүргэж байна. Гэвч зарим аймгууд, тухайлбал, Баянхонгор, Говь-Алтай, Завхан, Өвөрхангай, Сүхбаатар, Сэлэнгэ, Увс аймгуудын төсвийн ил тод байдлын

үнэлгээ сайжирсан бол Архангай, Баян-Өлгий, Булган, Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Дундговь, Төв, Ховд, Хэнтий зэрэг аймгийн үнэлгээ буурсан үзүүлэлттэй байгаа юм.

Хүснэгт 3.5. Аймаг, нийслэлийн төсвийн ил тод байдлын 2011, 2013, 2016 оны үнэлгээний харьцуулалт (Нийт авбал зохих оноо: 100)

№	Аймаг, нийслэл	Орон нутгийн төсвийн ил тод байдал - 2011		Орон нутгийн төсвийн ил тод байдал - 2013		Орон нутгийн төсвийн ил тод байдал - 2016	
		Нийт оноо	Рейтинг	Нийт оноо	Рейтинг	Нийт оноо	Рейтинг
1	Архангай	44.5	5	36.8	10	34.6	18
2	Баян-Өлгий	32.3	15	26.0	20	20.8	22
3	Баянхонгор	32.4	14	15.0	22	39.1	10
4	Булган	44.6	4	36.5	11	34.6	17
5	Говь-Алтай	29.4	17	26.7	19	44.3	6
6	Говьсүмбэр	38.3	8	51.5	3	50.7	3
7	Дархан-Уул	25.5	19	35.2	12	36.4	14
8	Дорноговь	28.2	18	48.9	4	31.1	19
9	Дорнод	36.5	11	29.3	16	26.7	20
10	Дундговь	18.0	21	34.5	13	23.7	21
11	Завхан	37.4	9	27.1	17	44.1	7
12	Орхон	16.6	22	32.1	14	37.3	17
13	Өвөрхангай	37.0	10	27.0	18	38.1	11
14	Өмнөговь	29.7	16	44.5	7	41.2	8
15	Сүхбаатар	34.6	12	31.4	15	45.9	5
16	Сэлэнгэ	47.6	3	18.3	21	53.9	2
17	Төв	40.2	6	51.9	2	38.0	12
18	Увс	38.4	7	46.4	6	46.3	4
19	Ховд	48.0	2	47.1	5	35.1	16
20	Хөвсгөл	33.8	13	55.3	1	58.5	1
21	Хэнтий	19.9	20	37.1	9	36.0	15
22	Улаанбаатар	55.5	1	38.7	8	40.8	9
Дундаж оноо		34.9		36.2		39.0	

Орон нутгийн төсвийн ил тод байдлын үнэлгээний дундаж оноо 2011 онд 34.9, 2013 онд 36.2 байсан бол төсвийн ил тод байдлын эрх зүйн зохицуулалт хангалттай хэмжээнд бүрдэн хэрэгжиж байгаа 2016 оны байдлаар 3 жилийн өмнөхөөс 3 оноогоор нэмэгдсэн нь аймаг, нийслэлийн төсвийн ил тод байдалд бага зэрэг ахиц гарч нутгийн удирдлагын зүгээс төсвийн үйл явц болон төсвийн баримт бичгийг ил тод, нээлттэй болгох алхмууд хийгдэж эхэлж буйг илтгэнэ.

Хүснэгт 3.6. Аймаг, нийслэлийн төсвийн баримт бичгийн ил тод байдлын үнэлгээний харьцуулалт (Нийт авбал зохих оноо: 100), 2013 он ба 2016 он

№	Төсвийн баримт бичгийн нэр	2013 он	2016 он	Зөрүү
1	Эрх зүйн баримт бичиг	39.0	37.7	-1.3
2	Төсвийн төсөл	15.3	19.6	4.3
3	ИТХ-ын хуралдаан	46.0	47.1	1.1
4	Батлагдсан төсөв	48.8	60.4	11.6
5	Иргэний төсөв	1.1	0.0	-1.1
6	Төсвийн тодотгол	41.5	36.4	-5.1
7	Хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагаа	50.9	52.3	1.4
8	Төсвийн гүйцэтгэл	55.6	65.6	10.0
9	Орон нутгийн хөгжлийн сан	38.5	21.7	-16.8
10	Засаг даргын нөөц хөрөнгө	30.2	22.3	-7.9
11	Орон нутгийн тусгай сангууд	43.4	58.7	15.3
12	Хандив, тусламжийн хөрөнгийн зарцуулалт	16.8	45.6	28.8

Аймаг, нийслэлийн төсвийн баримт бичгийн ил тод байдлын 2016 оны үнэлгээг 2013 оны дүнтэй харьцуулан дээрх хүснэгтэд харуулбал төсвийн төслийн ил тод байдал

4.3, ИТХ-ын хуралдааны ил тод байдал 1.1, батлагдсан төсвийн ил тод байдал 11.6, Хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны ил тод байдал 1.4, Төсвийн гүйцэтгэлийн ил тод байдал 10.0, Орон нутгийн тусгай сангуудын ил тод байдал 15.3, Хандив, тусламжийн хөрөнгийн зарцуулалтын ил тод байдал 28.8 хувиар нэмэгдсэн байна. Гэтэл Иргэний төсөв 1.1, Төсвийн тодотголын ил тод байдал 5.1, ОНХС-гийн ил тод байдал 16.8, Засаг даргын нөөц хөрөнгийн ил тод байдал 7.9 хувиар буурсан үзүүлэлттэй гарчээ. Энэ нь Шилэн дансны тухай хуульд ил тод байдлын шаардлага нь тодорхой тусгагдаагүй төсвийн үйл явц, баримт бичгүүд байгааг анхаарах шаардлагатайг харуулж байна.

Иргэний төсөв: Аймаг, нийслэл, дүүргийн ИТХ, Засаг даргын зүгээс орон нутгийн төсвийн талаар иргэдэд зориулан хялбаршуулан бэлтгэдэг “иргэний төсөв”-ийг огт гаргадаггүй хэвээр байна. Шилэн дансны тухай хууль Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн ил тод байдлыг хангах, төсвийн үйл явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлэхийн тулд орон нутгийн удирдлага болон төсвийн байгууллагуудын зүгээс иргэний төсвийг бэлтгэх шаардлага, хэлбэрийг нарийвчлан тодорхойлж, “иргэний төсөв” бэлтгэх аргачлал, заавар, програм хангамжийг боловсруулж, хэрэглэх шаардлагатай нь судалгааны явцад харагджээ.

Хүснэгт 3.7. Төсвийн ил тод байдлыг нутгийн удирдлагын байгууллагаас гаргасан эрх зүйн баримт бичигт тусгасан байдлын үнэлгээ

№	Эрх зүйн баримт бичгийн нэр	Аймаг, нийслэлийн		Дүүргүүдийн	
		Дундаж хувь	Авсан оноо	Дундаж хувь	Авсан оноо
1	Орон нутгийн бодлогын баримт бичигт төсвийн ил тод байдлыг тусгасан эсэх (Тухайлбал, аймаг, нийслэл, дүүргийн нийгэм, эдийн засгийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, зорилт)	62	2.5	74	2.9
2	Аймаг, нийслэл, дүүргийн ИТХ ба Тэргүүлэгчдийн хурлаас төсвийн ил тод байдлыг хангахтай холбоотой гаргасан тогтоол, шийдвэр	7	0.3	6	0.2
3	Аймаг, нийслэлийн Засаг даргын 2016 онд салбарын ТЭЗ нартай, Нийслэлийн Засаг даргаас дүүргийн Засаг дарга нартай байгуулсан төлөөлөн гүйцэтгэх болон хамтран ажиллах гэрээ	42	1.7	47	1.9
4	Аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан төсвийн ил тод байдалтай холбоотой заалт	64	2.5	64	2.6
5	Аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга төсвийн ил тод байдлыг хангахтай холбоотой гаргасан захирамж, албан даалгавар	49	2.0	29	1.2
6	Аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ-ын дарга болон байгууллагын төсвийн шууд захирагч нар Засаг даргатай байгуулсан ҮДГ-нд тусгагдсан төсвийн ил тод байдалтай холбоотой заалт	56	2.2	49	1.9
7	Аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ-ын даргын СТСХ-ийн даргатай байгуулсан ҮДГ-нд тусгагдсан төсвийн ил тод байдалтай холбоотой заалт	48	1.9	26	1.1
8	ЗДТГ-ын дарга болон СТСХ-ийн даргын гаргасан төсвийн ил тод байдалтай холбогдох албан бичиг, үүрэг даалгавар	22	0.9	8	0.3
9	Аймаг, нийслэл, дүүргийн ИТХ болон иргэдээс төсвийн ил тод байдалд тавих хөндлөнгийн хяналтын журам, түүний хэрэгжилт	9	0.4	0	0.0
10	Аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын дэргэдэх Дотоод аудитын албанаас төсвийн ил тод байдалд тавих дотоод хяналтын журам, түүний хэрэгжилт	20	0.8	10	0.4
Нэгдсэн үнэлгээ		38	1.5	31	1.3

Орон нутгийн төсвийн ил тод байдлыг сайжруулах арга зам:

- Орон нутгийн төсвийн ил тод байдлыг зохицуулсан хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах, хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах
- Орон нутгийн түвшний эрх зүйн баримт бичигт төсвийн ил тод байдлыг тодорхой тусган зохицуулахын зэрэгцээ ИТХ болон иргэдээс тавих хяналтын журмыг батлан мөрдөх
- Орон нутгийн төсвийн ил тод байдлыг хангах чиг үүргийг аймаг, нийслэл болон сум, дүүрэг, байгууллагын удирдлагын түвшин бүрээр зааглан тодорхой болгох
- Шилэн дансны цахим хуудсанд нийтлэх мэдээлэл болон орон нутаг, байгууллагын төсөв захирагчдын гаргадаг мэдээллийн уялдаа, нийцлийг хангах (төсвийн баримт бичиг боловсруулж, тайлан мэдээ гаргаж буй ажилтанд төвөггүй, мэдээллийг ашиглах иргэд хэрэглэгчдэд энгийн хялбар байх зарчмыг баримтлах)
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн ажлыг хянан шинжилж, үнэлэх шалгуур үзүүлэлтэд төсвийн ерөнхийлөн захирагч орон нутгийн төсвийн ил тод байдлыг ханган ажиллаж буй эсэх талаар үзүүлэлт оруулах
- Орон нутгийн төсвийн мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэх замаар иргэд төсвийн үйл явцад бүтээлчээр оролцох нөхцлийг бүрдүүлэх
- Орон нутгийн төсвийн үйл явцын болон ил тод байдлын цаглабар, түүнийг хэрхэн үр дүнтэй мөрдөж ажиллах талаар төсвийн захирагч нарт зориулсан ханын хуанли, гарын авлагыг ойлгомжтой, энгийн хэлбэрээр бэлтгэж, хэвлүүлэх
- Орон нутгийн төсвийн ил тод байдалд цахим хэлбэрээр хяналт тавих Дотоод аудит, хяналт шинжилгээ, үнэлгээний албаны ажилтнуудад ашиглахад хялбар програм хангамжийг бий болгох нь зүйтэй.

3.3.2. Дасгал ажил, хэлэлцүүлэг: Орон нутгийн төсвийн зарцуулалт, түүний ил тод байдлыг хянах чиглэлээр ИТХ-аас хэрэгжүүлж буй ажлын талаарх туршлагаа хуваалцах

Үргэлжлэх хугацаа: 20 минут

Дасгал ажил, хэлэлцүүлгийн удирдамж:

- 1) Хамтрагчтайгаа ярилцаж, орон нутгийн төсвийн зарцуулалт, ил тод байдлыг хянах чиглэлээр сумын ИТХ-аас хэрэгжүүлж байгаа ажлын талаарх туршлагаа хуваалцана. Ярилцах хугацаа 5 минут
- 2) Илтгэгч бүр 1 минутад багтаан хамтрагчтайгаа хуваалцсан туршлагаа танилцуулна. Нийт 5 минут
- 3) Багш хэлэлцүүлгийг удирдаж, нийтээр хэлэлцэнэ. Хэлэлцүүлгийн хугацаа 10 минут

3.3.3. Кейс, хэлэлцүүлэг: Орон нутгийн болон байгууллагын төсвийн ил тод байдлыг үнэлэх

Үргэлжлэх хугацаа: 30 минут

Кейс, хэлэлцүүлгийн удирдамж:

- 1) Сонгосон орон нутгийн 2018 оны төсвийн мэдээлэл Шилэн дансны цахим хуудсанд ил тод болсон эсэхтэй танилцана. Хугацаа 10 минут
- 2) Холбогдох мэдээллийг дараах хүснэгтэд тусгасан үзүүлэлтүүдээр үнэлнэ.

Төсвийн ил тод байдлыг үнэлэх үзүүлэлт

Үзүүлэлт	Харгалзах оноо
Хугацаандаа, иж бүрэн ил тод болсон	4
Хугацаа хоцорсон ч бүрэн ил тод болсон	3
Хугацаандаа ч, бүрэн бус мэдээлсэн	2
Бүрэн бус ч ямар нэгэн байдлаар мэдээлэл олж үзэх боломжтой	1
Огт ил тод болоогүй	0

3) Шилэн дансны дараах мэдээлэлд үнэлгээ өгнө. Хугацаа 10 минут

Жишээ 1: Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч буюу Засаг даргын төсвийн ил тод байдлын үнэлгээ

№	Мэдээллийн нэр	Ил тод болгох хугацаа	Ил тод байдалд өгсөн үнэлгээ	Үнэлгээний үндэслэл
1	5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ (ШДЦХТМАСТЖ 3.2.9, Хавсралт 8)	Долоо хоногийн дотор		
2.1.	Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр (ШДТХ 6.4.8, ШДЦХТМАСТЖ 3.1.7, Хавсралт 10)	(Тухай бүр) Долоо хоногийн дотор		
2.2.	Холбогдох шийдвэрийн эх хуулбар (PDF хэлбэрээр)			
3	Тухайн жилийн батлагдсан төсөв (ШДТХ 6.2.1, ШДЦХТМАСТЖ 3.1.2, Хавсралт 20)	Жил бүрийн 1-р сарын 10-ны дотор		
4	Тухайн жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө (ШДТХ 6.1.1, ШДЦХТМАСТЖ 3.1.14, Хавсралт 21)	Жил бүрийн 1-р сарын 10-ны дотор		
5	Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ (ШДТХ 6.1.2, ШДЦХТМАСТЖ 3.1.2, Хавсралт 20)	Сард 1 удаа (дараа сарын 8-ны дотор)		
6	Худалдан авах ажиллагааны тайлан (ШДТХ 6.1.1, ШДЦХТМАСТЖ 3.1.14, Хавсралт 22)	Дараа жилийн 1-р сарын 15-ны дотор		

Жишээ 2: Төсвийн шууд захирагчийн буюу байгууллагын төсвийн ил тод байдлын үнэлгээ

№	Мэдээллийн нэр	Ил тод болгох хугацаа	Ил тод байдалд өгсөн үнэлгээ	Үнэлгээний үндэслэл
1	5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ (ШДТХ 6.4.4, ШДЦХТМАСТЖ 3.2.9, Хавсралт 8)	Долоо хоногийн дотор		
2.1.	Цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээ тус бүрийн гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр (ШДТХ 6.4.5, ШДЦХТМАСТЖ 3.2.10, Хавсралт 9)	Долоо хоногийн дотор		
2.2.	Холбогдох шийдвэрийн эх хуулбар (PDF хэлбэрээр)			
3	Тухайн жилийн батлагдсан төсөв (ШДТХ 6.1.1, ШДЦХТМАСТЖ 3.2.2, Хавсралт 2)	Жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны өдрийн дотор		
4	Тухайн жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө (ШДТХ 6.1.1, ШДЦХТМАСТЖ 3.2.1, Хавсралт 21)	Жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны өдрийн дотор		
5	Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ (ШДТХ 6.1.2, ШДЦХТМАСТЖ 3.2.2, Хавсралт 2)	Сард 1 удаа (дараа сарын 8-ны дотор)		

4) Нийтээр хэлэлцэн орон нутгийн төсвийн зарцуулалт, ил тод байдалд ИТХ-аас хяналт тавихад анхаарах асуудал, шийдлийн талаар ярилцана. Хугацаа 10 минут

Багшийн дүгнэлт

Багш “Орон нутгийн төсвийг төлөвлөх, хянахад ИТХ-ын гүйцэтгэх үүрэг” сэдвийн хүрээнд авч үзсэн онол, арга зүйн мэдлэг, кейс, дасгал, хэлэлцүүлгийн явцад багуудын хүрсэн үр дүн, олж авсан чадвар, оролцогчдын гаргасан саналуудыг нэгтгэн дүгнэнэ.

Нэмж судлах эх сурвалж

- Монгол Улсын Үндсэн хууль, 1992.
<http://www.legalinfo.mn/law/details/367?lawid=367>
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль (Шинэчилсэн найруулга) <http://www.legalinfo.mn/law/details/343?lawid=343>
- Монгол улсын хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай, 2011.06.16 <http://legalinfo.mn/law/details/374?lawid=374>
- Төсвийн тухай Монгол Улсын хууль (Шинэчилсэн найруулга), 2011.11.23 <http://www.legalinfo.mn/law/details/504?lawid=504>
- Төрийн аудитын тухай хууль. 2003.
<http://www.legalinfo.mn/law/details/491?lawid=491>
- Төрийн болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль. УБ., 2005. <http://www.legalinfo.mn/law/details/493?lawid=493>
- Монгол улсын хууль, Шилэн дансны тухай, 2014.07.01
<http://legalinfo.mn/law/details/10497?lawid=10497>
- Монгол Улсын Засгийн газрын тогтоол, Орон нутгийн төсвийн аргачлал батлах тухай, 2012 оны 9 дүгээр сарын 15, #30. 2 дугаар хавсралт
- *Монгол Улсын Засгийн газрын тогтоол, “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”, 2016 оны 1-р сарын 11, #29*
- Монгол Улсын Сангийн сайдын тушаал, Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам батлах тухай, 2012 оны 11 дүгээр сарын 19, #244
- УИХТГ, УА, ШХА, НҮБХХ (2016). ИТХ-ын Төлөөлөгчдийн сургалтын гарын авлага. 2 дахь хэвлэл. Улаанбаатар. Хоёрдугаар бүлэг. Орон нутгийн хөгжлийн төлөвлөгөө, төсөв: эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт. 59-122 дахь тал.
- ННФ (2011). Орон нутгийн төсвийн ил тод байдал - 2011, Улаанбаатар
- ННФ (2014). Орон нутгийн төсвийн ил тод байдал - 2013, Улаанбаатар
- ННФ (2017). Орон нутгийн төсвийн ил тод байдал - 2016, Улаанбаатар
- Орон нутгийн хөгжлийн хүрээлэн (2016). Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлуудын сайн туршлагын эмхэтгэл. Улаанбаатар
- УИХТГ, ШХА, НҮБХХ (2016). Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг бэхжүүлэх нь” төсөл. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг дэмжих тэтгэлэг: Сайн туршлагын эмхэтгэл. Улаанбаатар
- УАГ (2016). Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтад хийсэн нийцлийн аудитын тайлан: ОНХС-гийн хөрөнгө хууль, журмын дагуу зарцуулагдахгүй байна. Улаанбаатар. <http://www.audit.mn/wp-content/uploads/2016/06/oron-nutag-hogjlin-san-2015.pdf>
- Энхбаяр Г., Отгонтуяа Л. Төрийн санхүүгийн удирдлага. Нэмж засварласан 2 дахь хэвлэл. УБ., 2003, 2009

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. БАЙГАЛЬ ХАМГААЛАЛ, ГАЗРЫН ХАРИЛЦАА – ИТХ БОЛОН ИРГЭДИЙН ОРОЛЦОО

Сургалтын зориулалт

Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ, баг, хорооны ИНХ-аас орон нутгийн байгаль хамгаалах, газрын харилцааны тухай шийдвэр гаргахад иргэдийн саналыг авах, хэрэгжилтэд оролцуулах арга барил эзэмшүүлж, дадлагажуулахад чиглэнэ.

Оролцогчид:

Монгол Улсын аймаг, сум, нийслэл, дүүргийн ИТХ-ын төлөөлөгчид

Хамрах хүрээ

Монгол Улсын аймаг, сум, баг, нийслэл, дүүрэг, хороонд тулгарч буй хүрээлэн буй байгаль орчин, газар ашиглалттай холбоотой асуудлыг тодорхойлж, хамтын шийдвэр гаргах

Агуулга буюу дэд сэдэв

1. Тогтвортой хөгжил, ногоон хөгжилд улс, орон нутгийн үүрэг, оролцоо
 - 1) Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, хэрэгжилт
 - 2) Нөхөн сэргэх боломжтой болон боломжгүй нөөц
 - 3) Байгалийн нөхөн сэргээгдэх нөөцийг ашиглах, хамгаалах
2. Байгаль орчин болон Газрын тухай хууль тогтоомж
 - 1) Байгаль орчны хууль эрх зүйн зохицуулалт
 - 2) Байгал орчин, Газартай холбогдон үүссэн зөрчлийг шийдвэрлэх
 - 3) Байгал орчин, Газрын асуудлыг нутгийн төвшинд шийдэх арга зам, боломж
3. Байгаль орчны элэгдэл, эвдрэл, бохирдолд хүний оролцоо, нөлөө
 - 1) Байгалийн зүй тогтлын дагуух өөрчлөлт, урьдчилан сэргийлэх, даван туулах арга
 - 2) Хүний үйл ажиллагаанаас үүссэн эвдрэл, бохирдол ба шийдэл Нутгийн хэмжээнд асуудлыг шийдвэрлэх
 - 3) Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ
 - 4) Уул уурхайн дараах нөхөн сэргээх ажил
 - 5) Нөхөрлөлийн үйл ажиллагаа
4. Тусгай хамгаалалттай газар нутаг: төр, иргэдийн оролцоо
 - 1) Газар нутгийг тусгай хамгаалалтад авах нийгэм-эдийн засгийн үндэслэл
 - 2) Тусгай хамгаалалттай газар нутгийн эрх зүйн зохицуулалт
 - 3) Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн хэрэгжилт
 - 4) Тусгай хамгаалалттай газар нутгийн эрх зүйн зохицуулалт дахь тулгамдсан асуудал
5. Орон нутгийн газрын ашиглалт хэрэглээнд үүсэж буй асуудал, шийдэл, туршлага, сургамж, дасгал
 - 1) Мал аж ахуй – бэлчээр, усалгаа, өвөлжөө, хаваржаа, намаржаа, зуслангийн хуваарийг хийж буй арга ажиллагаа, туршлага
 - 2) Газар тариалан – хөрсний элэгдэл, хамгаалал, сэлгэлт, химийн бордооны хэрэглээ, эерэг болон сөрөг нөлөөлөл, туршлага
 - 3) Хот байгуулалт – зам, хот суурингийн төлөвлөлт, хог хаягдлын асуудлыг шийдэж буй туршлага, арга ажиллагаа, үр дүн
 - 4) Тусгай хамгаалалт – ойжуулалт, түймэр, нөхөн сэргээлтийн ажлын зохион байгуулалтын туршлага
 - 5) Уул уурхай – хайгуул, олборлолт, нөхөн сэргээлтийн ажил, үр дүн

- б) Салбар хооронд (а, в, с, d, e) үүсэх маргаан, зөрчил, түүнийг шийдсэн байдал, орон нутгийн төвшинд шийдэх арга зам, боломжийг эрэлхийлнэ.

Байгаль орчин, газрын харилцааг орон нутгийн төвшинд ИТХ болон мэргэжлийн байгууллага, иргэд хамтран шийдвэрлэх арга замыг эрэлхийлнэ. Байгаль орчин, газрын харилцаатай холбогдон үүсэх зөрчил, маргаан нь 21 аймаг, 330 сум, Нийслэл, 9 дүүрэг, нарийвчилбал хөдөө, суурингийн сум, багт өөр өөр байгааг анхаарна.

Сургалтын арга, технологи

- 1) Гарын авлагыг шинжлэх ухааны мэдлэгийг хялбаршуулсан, системтэй, дүрслэл, кейстэй боловсруулна.
- 2) Сургалтын явцад Кейсийг хамтран хэлэлцэх, оролцооны аргаар шийдэх, дүрд орох аргуудыг хослуулан хэрэглэнэ.
- 3) ^{a)}мал аж ахуй, ^{b)}газар тариалан, ^{c)}хот байгуулалт, ^{d)}тусгай хамгаалалт, ^{e)}уул уурхай, ^{f)}салбар хоорондын зохицуулалт гэсэн 6 дэд бүлэг асуудал тус бүрээр кейс бэлтгэж, сургалтад оролцогчдын аймаг, сумын онцлогтой холбогдуулан кейс сонгож, дасгал хийнэ.

Сургалт болон гарын авлагын үр дүн

- 1) Сургагч багшид болон Оролцогчдод зориулсан аргачлал, заавар
- 2) Сургагч багшид зориулсан чиглэл олгох, дадлагажуулах 6 цагийн хичээл
- 3) Оролцогчдод зориулсан 4 цагийн хичээл

Сургалт болон гарын авлагын үр дагавар

- 1) Оролцогчид Байгаль орчин, газрын харилцааны суурь мэдлэг, хууль эрх зүйн системтэй мэдлэг эзэмшинэ
- 2) Орон нутагтаа үүсэж буй Байгаль орчин, газрын харилцааны асуудлыг таньж, ямар төвшинд хэнтэй хамтарч шийдвэрлэх арга замыг сонгоно
- 3) Байгаль орчин, газрын харилцааны асуудлыг иргэдийн оролцоотой шийдвэрлэнэ.
- 4) Байгаль орчин, газрын харилцаанд үгүйлэгдэж буй эрх зүйн зохицуулалтын санал дэвшүүлнэ.

Хүснэгт 4.4. Хичээлийг зохион байгуулах төлөвлөгөө

Хичээлийн дэд сэдэв	Цаг	Дасгалжуулах (Coach)	Дасгал
1.Тогтвортой хөгжил, ногоон хөгжилд улс, орон нутгийн үүрэг, оролцоо 1) Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, хэрэгжилт <i>1.1 Х.а.а-н салбар</i> <i>3. Байгаль орчин тогтвортой хөгжил</i> <i>3.1 Усны нөөцийн нэгдсэн менежмент</i> <i>3.2 Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох</i> <i>3.3 Экосистемийн тэнцвэрт байдал</i>	Н 50' 10'	Танилцуулга 3' Номын 123-130-р тал. Үзүүлэн харуулна, Оролцоог өрнүүлж 5' ярилцана /бие халаалт/	Орон нутагт хэрэгжилт ямар байгааг асууж ярилцана.
2) Нөхөн сэргэх боломжтой болон боломжгүй нөөц <i>a. Байгалийн нөхөн сэргэх нөөц, эрчим хүч</i> <i>b. М.а.а ба Загасны а.а-н зохицуулалтын нийтлэг шаардлага</i> <i>c. Ойн нөөцийн зохицуулалт</i>	20'	Багуудад 5 дэд хэсэг, өгүүлэмжийг (праграф) хуваарилна. Зөвлөнө, нэмэлт тайлбар.	Багууд а b c d e-ийг 3' хэлэлцээд, бусдад 3' танилцуулна. Орон нутагт хэрэгжилт ямар

d. Бэлчээрийн нөөцийн зохицуулалт e. Байгалийн нөхөн сэргэхгүй нөөц			байгааг нэмж ярина. $3+5 \times 3' = 18'$
3) Байгалийн нөхөн сэргээгдэх нөөцийг ашиглах, хамгаалах Энэ тухай ИТХ-аас хийсэн бодит ажил, үр дүн, туршлага, сургамжийг хэлэлцэх	20'	Багууд хэлэлцээд дэлгэц цаасанд бичиж, танилцуулна. Багш дүгнэнэ	Багууд тус бүрдээ асуудал, ажил, үр дүн, сургамжийг хэлэлцээд, бусдад 3' танилцуулна. $3+5 \times 3' = 15'$
2. Байгаль орчин болон Газрын тухай хууль тогтоомж 1) Байгаль орчны хууль эрх зүйн зохицуулалт	H 80' 5'	Танилцуулга 3-5' Номын 135-131-р тал.	
2) Байгаль орчин, Газартай холбогдон үүссэн зөрчлийг шийдвэрлэх	55'	Танилцуулга 2' Номын 137-138-р тал. Багууд дүрд орж дасгал хийнэ. Аймаг, суманд Жишээ 1, Ний, дүүрэгт Жишээ 2-ийг ажиллана. Дүгнэлт, сургамжийг багш нэгтгэнэ 10'	Багууд ¹⁾ Иргэн Д; ²⁾ Компани; ³⁾ Багийн ИНХ; ⁴⁾ Сумын ИТХ, ЗД; ⁵⁾ Аймгийн ЗД болно. Багууд асуултын дагуу 20' хэлэлцэж, хариултыг Дэлгэц цаасанд бичиж, 4' танилцуулна. $20'+5 \times 4' = 40'$
3) Байгаль орчин, Газрын асуудлыг нутгийн төвшинд шийдэх арга зам, боломж Орон нутагт байгаль орчин, газрын харилцаанд үүсдэг асуудлыг хэлэлцэх	20'	Танилцуулга 2' Номын 146-147-р тал. 7 багц асуудлыг багууд тус бүрийг хэлэлцэнэ.	Багууд тухайн асуудлыг 3' хэлэлцээд, бусдад 3' танилцуулна. Аймаг, сумын (Ний, дүүрэг) хэмжээнд шийдсэн туршлага, боломжийг ярина. $3+5 \times 3' = 18'$
3. Байгаль орчны элэгдэл, эвдрэл, бохирдолд хүний оролцоо, нөлөө 1) Байгалийн зүй тогтлын дагуух өөрчлөлт, урьдчилан сэргийлэх, даван туулах арга /3.3.1/ 2) Хүний үйл ажиллагаанаас үүссэн эвдрэл, бохирдол ба шийдэл /3.3.2/ 3) Нутгийн хэмжээнд асуудлыг шийдвэрлэх /3.3.3/ 4) Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ 5) Уул уурхайн дараах нөхөн сэргээх ажил 6) Нөхөрлөлийн үйл ажиллагаа	H 50' 40'	Багш 2 минут танилцуулна. Дүгнэлт, сургамжийг багш нэгтгэнэ 8'	Баг тус бүр 10' хэлэлцээд, дэлгэц цаасанд бичиж, зурж, бусдад 4' танилцуулна.. Аймаг, сумын (Ний, дүүрэг) хэмжээнд гарсан зөрчил, шийдсэн туршлага, боломжийг ярина. $10'+5 \times 4' = 30'$
4. Тусгай хамгаалалттай газар нутаг: төр, иргэдийн оролцоо 1) Газар нутгийг тусгай хамгаалалтад авах нийгэм-эдийн засгийн үндэслэл 2) Тусгай хамгаалалттай газар нутгийн эрх зүйн зохицуулалт	H 90' 5'	Багш 5 минут танилцуулна.	
3) Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн хэрэгжилт a. Дархан цаазат газар b. Байгалийн цогцолбор газар c. Байгалийн нөөц газар d. Дурсгалт газар e. Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр	20'		Багууд a b c d e-ийг 3' уншиж, 3' танилцуулахдаа орон нутагт хэрэгжилт ямар байгааг ярина. $3+5 \times 3' = 20'$

4) Тусгай хамгаалалттай газар нутгийн эрх зүйн зохицуулалт дахь тулгамдсан асуудал	45'	Багууд дүрд орж дасгал хийнэ. Аймаг, суманд Жишээ 6, Ний, дүүрэгт Жишээ 5-ийг ажиллана. Дүгнэлт, сургамжийг багш нэгтгэнэ 5'	Багууд асуултын дагуу 15' хэлэлцээд хариултыг Дэлгэц цаасанд бичиж, 5' танилцуулна. $15' + 5 \times 5' = 40'$
5) Нутгийн удирдлагын эрх хэмжээ, хэрэгжилт	20'	Дүгнэлтийг хамтарч хийнэ.	Баг тус бүр 3' хэлэлцээд, Дэлгэц цаасанд бичиж, бусдад 3' танилцуулна. Бодит байдалд үүсдэг асуудал, шийдсэн туршлага, боломжийг ярина. $3' + 3 \times 5' = 20'$
Бүгд цаг	270'		

Тайлбар: Оролцогчдыг 5 баг болгохоор төлөвлөсөн. Оролцогчид цөөн бол 4 баг болгож болох бөгөөд багуудад ажил хуваарилахдаа жигд байхыг анхаарна

Асуудал шийдэх оролцоот сургалтын дараалал /жишиг/

А. Сургалтын бэлтгэл ажил

1) Танилцах

а. Багш өөрийгөө танилцуулах: Нэр, мэргэжил, туршлага

б. Оролцогчид хоорондоо танилцах:

i. Өмнөх хичээлд танилцсан бол хийх шаардлагагүй

ii. Нэг аймаг, нэг сумын ИТХ-ын төлөөлөгчид бол бие биеэ сайн таньдаг

iii. Өөр өөр аймаг, сумаас ирсэн бол ширээ ширээндээ танилцах

2) Сургагч багш тухайн дэд сэдвийг 2-3 минут тайлбарлаж (лекц хийж), оролцогчдыг багт хуваарилж, багуудыг хамтарч дасгал хийхэд чиглүүлж дадлагажуулна. Оролцоог дэмжиж, дүгнэж, зөвлөмж өгнө.

3) Сургалтыг оролцоог жигд өрнүүлэхийн тулд Дасгалын аргаар зохион байгуулна.

4) Багт дугаар нэр өгөх (нэг ширээнд 4-6 оролцогчид, тойрч суусан хэлбэртэй, ярилцах, бичих боломжтой байх)

Сургалтын үед баримтлах дүрэм

а. Өөрийгөө болон бусдыг хүндэтгэх

б. Утасны дууг хаах, нэн шаардлагатай ярих үед л гарч ярих

с. Бусдыг сонсох, ээлжилж ярих

д. Тодорхой асуулт, санал, эерэг бүтээлч хандлага

е. Маргахгүй, хэрэв шүүмжлэх бол шийдлийг санал болгох

Багшийн туршлага болон Оролцогчдын идэвх оролцоо, мэдлэг боловсрол, манлайллаас хамаарах тул уян хатан зохицуулалт хийж, хичээлийн агуулгыг цагтаа багтаах, мөн төгсгөлд дүгнэлт, зөвлөмж өгөх цагийг анхаарч ажиллана.

Б. Сургалтын үйл явц**1. Асуудал**

- ✓ Байгаль орчин, Газрын харилцаанд үүсдэг тухайн хүрээний Асуудлыг багаар хэлэлцээд дэс дараагаар тайлбарлана, зургаар дүрслэн үзүүлж болно.
- ✓ Баг тус бүрийн танилцуулсан “Асуудал”-аас асуулт асуух, санал хэлэх

2. Туршлага, сургамж

- a. Байгаль орчин, газрын харилцаанд хэрэгжүүлсэн ололт, амжилт, туршлага, сургамжийг багаар хэлэлцээд үзүүлэн бэлтгэж, бусдад танилцуулах
- b. Баг тус бүрийн танилцуулсан “Туршлага”-аас асуулт асуух, тодруулах

3. Шийдэл

- a. Байгаль орчин, газрын харилцаанд үүссэн “Асуудал”-аас сонгож, багийн шийдэл гаргах
- b. “Бор” номын Жишээ (1-6)-г сургалтад хэрэглэж болно. Хуулийн дагуух эцсийн шийдвэрийг жишээнд бичсэн байгаа тул та бүхэн шийдвэр гаргах гэхээсээ илүү Яагаад ийм байдал үүсэв? Үүнээс урьдчилан сэргийлэх арга байсан уу? ИТХ-ынхан юун дээр алдсан байна вэ? Төлөөлөгч-Бид ямар ямар хуулийг тодорхой мэдэх хэрэгтэй вэ? гэдэгт анхаарлаа хандуулаарай.

Таны хэрэгжүүлэх сургалтад оролцогчдын орон нутагт үүссэн асуудалтай холбож жишээ боловсруулж хэрэглэхийг зөвлөж байна.

Сургагч багшид зориулсан зөвлөмж

“Байгаль хамгаалал, газрын харилцаа – ИТХ болон Иргэдийн оролцоо” сэдэвт хичээл нь орон нутгийн байгаль хамгаалах, газрын харилцаанд тулгамдаж буй асуудлыг иргэдийн оролцоо, саналд тулгуурлаж ИНХ, ИТХ-аас оролцогч талуудын эрх ашиг, сонирхлыг харгалзан, байгаль-нийгэм-эдийн засгийн тогтвортой хөгжлийн нийтлэг зарчимд нийцүүлсэн хамтын шийдвэр гаргахад чиглэгдсэн болно.

Сургалтад баримтлах зарчим

- 1) *Орчноо өөрсдөө бүрдүүлэх хандлага төлөвшүүлнэ.* Орон нутгийнхаа асуудлыг иргэд болон оролцогч талуудын хамтын оролцоотойгоор байгаль орчинд ээлтэй, эдийн засагт үр ашигтай, хүний аюулгүй амьдрах орчноо өөрсдөө бүрдүүлэх хандлагыг төлөвшүүлэхэд чиглэнэ.
- 2) *Салбар хоорондын зохицуулалтыг ИТХ шийднэ.* Манай улсын ^{a)}мал аж ахуй, ^{b)}газар тариалан, ^{c)}хот байгуулалт, ^{d)}тусгай хамгаалалт, ^{e)}уул уурхай салбар тус бүрдээ өөрийн хэв болон бичмэл хуулиар зохицуулагдаж ирсэн билээ. Эдгээр салбар хоорондын зохицуулалт эдүгээ цагт нэн чухлаар үгүйлэгдэж, үүнээс үүдсэн зөрчил, маргаан мөн байгальд сөрөг нөлөөтэй эвдрэл, хохирол үүсэж байгаа тул ИТХ-ын гол анхаарал үүнд төвлөрөх шаардлагатай байна.
- 3) *Оролцогчдын мэргэжил, туршлагын онцлогийг анхаарна.* Нийслэл, дүүрэг, аймаг, сумын ИТХ-ын төлөөлөгчдийн мэргэжил, төлөөлөгчөөр ажилласан жил, туршлага харилцан адилгүй байдаг. Иймд практикт үүссэн асуудлыг шийдэхдээ шинжлэх ухааны мэдлэг, мэдээлэлтэй хандахыг чухалчлах бөгөөд ингэхдээ хэт онолдохоос болгоомжилж, агуулгыг орхигдуулахгүй байхыг анхаарна.
- 4) *Мэдээллийг түгээх, заах бус мэдлэг дамжуулах, хамтарч ажиллах арга барил эзэмшүүлнэ.* Сургалт, түүний гарын авлагыг мэдлэг, мэдээллийг системчилж, мэдлэгээ практикт оролцооны аргаар хэрэгжүүлэх дадал эзэмшүүлэхэд анхаарна.

- 5) *Хувилбартай кейсийг боловсруулж хэрэглэнэ.* Говь, хангай, тал хээрийн бүс, хотжилт, төв суурингаас алслагдсан байдал, уламжлалт мал аж ахуйтай, эрчимжсэн газар тариалан, мал аж ахуй хосолсон, уул уурхай үйлдвэрлэлтэй гээд 330 сум, 9 дүүрэг тус бүрдээ ялгаатай тул сургалтын кейсийг хувилбартай боловсруулна.

Тус хичээл нь Мал аж ахуйн бэлчээр, Газар тариалангийн газар ашиглалт, Хот суурины төлөвлөлт, Тусгай хамгаалалттай газар нутаг, Уул уурхайн үйл ажиллагаа болон салбар хоорондын Байгаль хамгаалал, Газрын харилцааны асуудлыг хамарсан өргөн хүрээтэй болно.

Дэд сэдэв тус бүрийн хувьд “Юу” гэдэг танин мэдэхүйн тайлбарыг өгөхөөс илүүтэй “Энэ асуудал яагаад үүсэв?”, түүний “Шалтгаан юу байв, хэрхэн шийдэв” гэдгийг чухалчлав. Өөрөөр хэлбэл, “Хэрхэн, яаж?” буюу “Иргэдийн оролцоотой ИНХ, ИТХ-аас хуулийн дагуу хамтарч шийдэх” гэдэгт анхаарав. Тухайлбал, дээрх салбар тус бүрд үүсэж буй газар ашиглалт, байгаль хамгааллын асуудал, зөрчлийг хүчин төгөлдөр үйлчилж буй хууль, дүрэм болон эрх зүйн хүрээнд орон нутгийн хэмжээнд шийдвэрлэх боломжийг эрэлхийлэх хандлагыг төлөвшүүлэхэд анхаарав.


Орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг иргэдийн санаа, санаачилгад тулгуурлаж, төсөл, төлөвлөгөө хийж, ИТХ-аас тогтоол, журам зэргээр албан ёсоор хэрэгжүүлэх боломж нь эдүгээ нээгдсэн бөгөөд “дээрээс шийдвэр харах”, “төрөөс зохицуулна” гэх сэтгэлгээг өөрчилж, **“нутгийн асуудлыг хуулийн дагуу өөрсдөө шийдвэрлэх”** сэтгэлгээ, арга барил, үйл ажил төлөвшүүлэх нь хичээлийн гол зорилго юм.

Тухайлбал, Өвөлжөө, хаваржаа, бэлчээр, хадлангийн газрын хуваарь, эзэнжүүлэх асуудлыг багийн ИНХ-аар шийдэх, энэ төвшинд хараахан шийдэж чадахгүй бол сумын ИТХ-аар шийдэх эрх зүйн зохицуулалтыг хэрэглэхийн оронд “Төрөөс шийднэ”, “Сонгуулиар нам солигдохыг хүлээнэ” гэх “хуучинсаг-хараат” сэтгэлгээ байсаар байна. Үүнийг халж, өөрчлөхөд “оч” төдий боловч сэдэл, тэмүүлэл, аргачлал өгөхөд тус хичээлийн ач холбогдол чиглэнэ.

Нутгийн асуудлыг хуулийн хүрээнд иргэдийн оролцоотой хамтран шийдэх сэтгэлгээ, арга барилыг төлөвшүүлэхэд энэ хичээл чиглэж байна.

Зураг 4.5. Байгаль хамгаалал, газрын харилцааны асуудлыг иргэдийн оролцоотой шийдэх арга





Иргэдийн оролцоог дэмжих, шийдвэр гаргахад татан оролцуулах анхдагч шат нь “мэдээлэл өгөх” тул (Батсүх.Ш, Долгоржав.Я, Ганцож.Б 2014) ИТХ-ын төлөөлөгчид сурснаа хэрэгжүүлэхдээ үнэн зөв, тэгш¹⁰ мэдээллийг жигд түгээхэд анхаарах хэрэгтэй юм.

Иймд сургагч багш мэдээллийг түгээх, зөвлөлдөх¹¹ арга эзэмшүүлэхэд анхаарлаа хандуулахыг зөвлөж байна. Энэхүү эхний 2 шатыг сургагч багш, сургалтад оролцогч Төлөөлөгчид эзэмшиж чадваас ИНХ, ИТХ-аар хэлэлцэн шийдэх нь дадлагажиж, суралцаж буй ажлууд юм. Хамгийн гол нь тухайн асуудалтай холбогдох үнэн зөв мэдээлэл, мөн шаардлагатай хууль, эрх зүйн баримт бичгийг жигд түгээх нь чухал юм.

Байгаль хамгаалал, газрын харилцааны асуудал нь тухайн орон нутгийн иргэдийн өнөө болон ирээдүйн хөгжлийн нийтлэг эрх ашгийг хөндөж байдаг тул малчид, тариаланчид, иргэд санал өгөх, санаачилга гаргах, хэрэгжилтэд оролцох сонирхол, эрмэлзэлтэй байдаг. Ялангуяа, газрыг зүй бусаар сорчилж ашиглах, байгалийг сүйтгэх үйл ажиллагааг үзэл бодол, хандлагаараа эсэргүүцэж байдаг. Гэсэн хэдий боловч тэдний дуу хоолойг сонсохгүй, эсвэл “дээрээс шийдсэн юм”, “яам, агентлагаас зөвшөөрөлтэй юм”, “дарга нар мэднэ” гэх үг яриа нь битүү болгоомжлол, заримдаа хүнийсэх буюу “бидэнд хамаагүй” гэх гутранги сэтгэлгээг үүсгэдэг.

Сургалтын үндсэн кейс буюу дасгалын жишээ

Жишээ 1. 2005 оны үед А аймгийн Х суманд гадаадын хөрөнгө оруулалттай тоосгоны үйлдвэр сумын төвд (1.5 км-ийн зайтай) үйл ажиллагаа явуулж, эмэгтэйчүүд хүүхдийг ажлын бээлий, өдрийн цайгүй ажиллуулж, багахан хэмжээний хөлс өгч, сумын төвд улаан шороо манаргаж байгаатай нутгийн удирдлагууд эвлэрч “зөвшөөрлийг дээрээс өгсөн юм” хэмээж, ямар ч арга хэмжээ авахгүй байв.

Жишээ 2. 2015 оны байдлаар З аймгийн Д суманд ажиллаж буй алтны уурхай тус багийн иргэдэд улирал бүр тэтгэмж өгч, байгаль орчны бохирдуулж байгааг “хамтран” нууж байна.

Эдгээр жишээнээс үзвэл, байгалийг зүй бусаар ашиглах, газрын харилцааны анхаарал татсан асуудлыг ИНХ, ИТХ-аар хэлэлцэхгүй, иргэдийн санаа бодлыг үл ойшоох нь иргэдийн сэтгэлгээг мохоох, худалдахад хүргэж байна.

Жишээ 3. Д аймгийн Х сумын хүүхдийн цэцэрлэгийн хажууд гадаадын хөрөнгө оруулалттай даавууны үйлдвэр олон жил ажиллаж, химийн урвалж бодисоор орчны агаарыг бохирдуулж байсныг иргэд эсэргүүцэж, тус үйлдвэрийг 2006 онд хаалгасан билээ.

¹⁰ Үнэн зөв, тэгш мэдээлэл – асуудалд оролцогч талуудын юу хийсэн, хийгээгүй, ямар байдалтай зэргийг иргэдэд мэдээлэх юм. Аль нэг талыг дөвийлгөж, нөгөө талыг хэт буруутгасан мэдээлэл нь асуудлыг бүрхэгдүүлдэг. Г.Ж

¹¹ Иргэдийн оролцооны шатлал: Мэдээлэл өгөх, Зөвлөлдөх, Санал авах болон Оролцуулах, Хамтын шийдвэр, төлөөллийг Хэрэгжилтэд оролцуулах зэрэг болно.

Жишээ 4. Өмнөговь аймгийн Гурвантэс сумын иргэд болон ТББ-аас орон нутгийн тусгай хамгаалалтад авах санал гаргаж, 2012 онд сумын ИТХ, аймгийн ИТХ-аар “Орон нутгийн хамгаалалтад авах” шийдвэрээр гаргасныг компаниуд эсэргүүцэж, улмаар анхан, давж заалдах, дээд Шүүхийн 3 шатанд хүчингүй болгожээ (Яагаад хүчингүй болгосон ИТХ-ын алдаа, сургамжийг Кейс болгов). Иргэд болон ТББ үүний төлөө олон жил тасралтгүй ажиллаж, аймаг ИТХ, УИХ-д өргөн мэдүүлж, улсын хэмжээнд төдийгүй олон хэмжээнд олон нийтийн анхаарлыг хандуулж, амь нас эрсдэж, зарим нутгийг л Байгалийн нөөц газрын ангиллаар улсын тусгай хамгаалалтад авах шийдвэрийг 2016.04.14-нд Засгийн газраар гаргуулсан билээ.

Эдгээр жишээнээс үзвэл, Байгаль хамгаалах, газрын харилцааны асуудал нь олон жил дамжих хугацаа, уйгагүй идэвх зүтгэл, маргаан мэтгэлцээн, хөрөнгө зарцуулдаг ажил болох нь харагдаж байна. Үүнд л иргэдийн санаа бодол, хамтын зүтгэл, ИТХ-ын хуулийн дагуух шийдвэрийн үүрэг, оролцоо чухал байдаг.

Хүснэгт 4.2. Орон нутгийн байгаль хамгаалал, газрын харилцаанд үүсдэг асуудлын онцлог, ялгаатай талууд

Асуудлын сэдэв	Аймаг, сум, баг	Нийслэл, дүүрэг, хороо
Байгаль орчин-Ногоон хөгжил	Ой мод огтлох, самар, жимсийг хяналтгүй түүх, ой модонд орогнох,	Нийслэлийн ногоон бүсэд иргэн, аж ахуйн нэгжүүд зуслан, амралтын газрыг олноор байгуулж, ой бүс, гол усны эх ундарга, эрэгт тулгаж хашаа, барилга барьсан
Ан ангуур	Хуулийн хугацаанаас өмнө ан агнах, тарваган тахал	Эрх мэдэлтнүүд хуулиас илүү тогтоол гаргуулж, төлбөрийг завших
Тусгай хамгаалалттай газар нутаг	Тусгай хамгаалалтад газар нутгийг авах хэрэгцээ, шаардлага их боловч түүнийг авахдаа хуулийг хэрэглэхдээ алддаг	Тусгай хамгаалалттай газарт хотхон байгуулсан
Газар	Бэлчээр, тариалангийн газрын маргаан, Бэлчээрийг уул уурхайн хайгуул, олборлолтоор эзэмдэх	Нийтийн эзэмшил газар, орон сууцны барилгыг хааж барилга барих
		Гэр хорооллын иргэд газар эзэмших, өмчлөхөд хүндрэл, чирэгдэл, хүнд суртал их
Албан тушаал, эрх мэдэл		Дүүргийн ӨГХ-ны дарга нар авилгын хэрэгт холбогдох

Сургалт зохион байгуулах болон Гарын авлагыг хэрэглэх заавар

Сургалтыг **А. Уламжлалт** буюу Танин мэдэхүйн лекцийн арга, **В. Оролцоот** буюу Асуудал шийдэх гэсэн 2 аргаар зохион байгуулахыг санал болгож байна.

Хүснэгт 4.3. Сургалтын аргын харьцуулалт


Үзүүлэлт	Уламжлалт буюу Лекцийн арга	Оролцоот буюу Асуудал шийдэх арга
Хичээлийн онцлог	Шинжлэх ухааны болон хууль, эрх зүйн тухай танин мэдэхүйн өргөн хүрээтэй лекц	Асуудал, Хамтын шийдэл, Мэдлэгээ бататгах дасгал
Хичээлийн дараалал	Лекц 80%, Дасгал, даалгавар 20%	Дасгал-кейс 80%, Лекц, зөвлөгөө 20%
Оролцогчдын тоо	Ихэвчлэн 25-аас их үед	Дунджаар 20-25
Сургагчийн үйлдэл	Багш лекцийг уншина, тайлбарлана. Багш заана, үүрэгдэнэ. “Их мэдлэгтэй багш”	Багш чиглүүлнэ, зохион байгуулна. Багш асуудлыг дэвшүүлнэ. “Туршлагатай багш”

Суралцагчийн үйлдэл	Оролцогчид бичих, эсвэл бэлдсэн материалыг гүйлгэх, слайдын зураг авах, “Томоотой сурагчид”	Оролцогчид дангаар болон багаар ажиллаж, шийдэл гаргана, асууна, маргана. “Хэрсүү сурагчид”
Үр дүн	Тогтсон цагт хөтөлбөрийн дагуух мэдээллийг оролцогчдод өгнө. Цагтаа багтана “Алга ташна”	Тодорхой бодит кейсд тулгуурлаж, хэлэлцэж, хамтын шийдэл гаргана. “Гүн сэтгэгдэл төрнө”
Давуу тал	Богино хугацаанд өргөн мэдлэгийг тоймлож, танилцуулах	Тодорхой асуудал, дасгал дээр хамтарч ажилладаг. Багаар ажиллах чадвар эзэмшдэг. Төсөл, журмын санаа төрдөг.
Сул тал	Насанд хүрэгчдийн боловсролын төвшин, мэргэжил харилцан адилгүй өөр өөр тул сонирхох, эс сонирхох хэсгээр ялгардаг. “Хэрэгтэй, ёстой”, “ийм тийм байдаг” гэх мэтээр тайлбарлахад хүмүүс төдий л дуртай хүлээж авдаггүй. Үүнийг Сайн илтгэгч хөтөлж, оролцогчдыг өдөөдөг.	Зохион байгуулалтын дүрэмгүй байх, эсвэл хэт ялгарсан “их мэдэгч” давамгайлах, албан тушаалын зэрэг дэвийн ялгаа их үед оролцоо багасдаг. Үүнийг Сургагч багш засаж болно.
Үр дагавар	Дасгал, даалгаврыг хийх, хийхгүй нь тодорхой бус. Мэдсэнээ хэрэгжүүлж болно, хэрэгжүүлэхгүй ч байж болно.	Амьдралд үүсдэг асуудлыг хамтарч шийдсэн тул арга барил сурна. Мэдлэг, эрх зүйн боловсролоо нэмэгдүүлэх сэдэл тэмүүлэл төрж, гарын авлагыг уншина.

Боловсруулсан: доктор Г.Жаргал (Жаргал.Г, Манлайлалд алхам алхмаар суралцах нь 2016)

А. Уламжлалт буюу Танин мэдэхүйн лекцийн аргаар хичээл зохион байгуулахдаа

- 1) Гарын авлагын 1-4-р бүлэг тус бүрийг хичээлийн 1 цагт багтааж тайлбарлана
- 2) 5, 6-р багийн дасгал, кейсээс танхимд ажиллуулах, дасгал даалгавраар гүйцэтгүүлнэ



В. Оролцоот буюу Асуудал шийдэх аргаар хичээл зохион байгуулахдаа

- 1) Орон нутгийн байгаль хамгаалах, газрын харилцаанд үүсдэг асуудлыг бүлэг тус бүрээр хэлэлцүүлж, эрэмбэ дараагаар сонсоно.
- 2) Тухайн аймаг, сумын хувьд бусдад сургамжтай туршлага, ололт, түгээх аргыг хэлэлцэнэ.
- 3) Тухайн аймаг, сумын хувьд хамгийн ихээр тулгамдсан боловч шийдэж чадаагүй асуудлыг сонгож, шийдлийг олохоор ажиллана

Тус гарын авлагын 1-4 бүлэг нь сэдвийн хүрээнд хамаарах ойлголт ухагдахууныг тайлбарласан бичвэр зураг, бүдүүвч байгаа бөгөөд мөн эргэцүүлэн бодох асуулт, хийх ажлын даалгаврыг оруулав.


Эргэцүүлэн бодох асуулт нь сонсогчид багаар болон ганцаараа ажиллах боломжийн олгож онол арга зүйн ойлголтоо бататгах, багшаас тодруулах асуултаа хэлэлцэн нягтлах боломжийг олгоно. Хийх ажлын даалгавар нь сонсогчоос илүү бүтээлч ажиллагааг шаардах бөгөөд онол арга зүйн мэдлэгээ ашиглах өөрийн хүрээлэн байгаа орчны бодлогын асуудал, түүний учир шалтгааныг арга зүйн үндэслэлтэйгээр боловсруулах ур чадвар эзэмших боломжийг багшийн удирдлага, заавар дор гүйцэтгэх боломжийг олгоно. Энд асуултын зөв хариулт гэсэн зүйлийг оруулаагүй бөгөөд энэ нь тухайн сонсогч бүрийн мэдлэг, ойлголтын төвшингээс хамааран зөв хандлагатай хариултыг хэлэлцэн тодорхойлох шаардлагатай болно. Иймд багш хичээл эхлэхээс өмнө сонсогчдын хэрэгцээ шаардлагыг нарийвчлан тодруулж хичээлдээ бэлтгэх хэрэгтэй юм.

Багшийн туршлага болон оролцогчдын идэвх оролцоо, мэдлэг боловсрол, манлайллаас хамаарах тул уян хатан зохицуулалт хийж, хичээлийг цагтаа багтаах, мөн төгсөлд дүгнэлт, зөвлөмж өгөх цагийг анхаарч ажиллана.

Уламжлалт сургалтын болон техникийн “Гарын авлага” нь мэдээлэл, зааврыг уншаад дагаж хийхэд тохиромжтой байдлаар бичигддэг. Иймд тухайн зүйлийн тогтсон ойлголтыг тайлбарлах, танин мэдэхүйн тал илүү, шинжлэх ухааны онол, аргачлал их байдаг.

Оролцоот буюу Асуудал-шийдэл сургалтын “гарын авлага”-ыг асуудалд бүтээлчээр хандах (нийтийн эрх ашигт нийцсэн хожих-хожих зарчим), асуудлын шалтгааныг тогтоож (буруутныг шийтгэхэд бус) засах аргыг хамтарч олоход чиглүүлэх зорилго, агуулгаар бичив. Иймд шинжлэх ухааны ойлголт, хууль эрх зүйн зохицуулалтыг үндэс суурь байдлаар оруулж, харин ойлголт, асуудлыг эргэцүүлж, тунгаах, харьцуулан уншихад илүү анхаарч бичив.

Зураг 4.6. Сургалтын 2 хандлага, 2 аргын харьцуулалт



Уламжлалт лекц: Аз жаргалын түлхүүрийг олох заавар

Асуудал-шийдэл: Сумын байгаль, нийгэм, эдийн засгийг цогцоор авч үзэх (Уул, ус, ургамал, хүн, мал, суурьшилтай нь харах)

Дасгал, кейс, хэлэлцүүлэг хийх аргачлал

- ~ 4-5 хүнтэй багаар ажиллана
- ~ Гишүүд хамтран ярилцаж дээрх асуултад хариулт бэлтгэнэ
- ~ Давуу тал, Сул талыг тодорхойлж, Санал бичихэд загвар хүснэгтийг ашиглана
- ~ Саналаа нэгтгэн дэлгэц цаасан дээр бичиж танилцуулна
- ~ Багууд ярилцаж саналаа нэгтгэнэ (Кейс, дасгалын онцлогоос шалтгаалж 10-15 минут)
- ~ Баг тус бүр 3 минутад багтааж танилцуулна.

Дэлгэц цаасанд бичих

Давуу тал

Сул тал

.....

.....

.....

Хэрэв (Таны хувилбар, санал)

.....

.....

.....

“Байгаль хамгаалал, Газрын харилцаа” хичээлийн кейс, дасгал**Кейсийн хураангуй**

Аймаг, Нийслэл, сум, дүүргийн Газрын харилцаа, Байгаль орчин, Тусгай хамгаалалтай холбоотойгоор бодит амьдралд үүдсэн асуудлыг 3 шатны шүүхээр хэлэлцсэн Шүүхийн эх сурвалжаас авч боловсруулав. Кейс тус бүрийн Хамрах хүрээ, Хэрэглэх арга, Сургагч багшийн бэлтгэх хуулийг дурдав. Сургагч багш илүү их мэдээлэл хэрэгтэй бол кейс тус бүрд эх сурвалжийг бичсэн болно.

Кейсийн нэр, агуулга	Хамрах хүрээ	Хэрэглэх арга	Бэлтгэх зүйл
1. Тариалангийн зориулалтаар газар эзэмшүүлэхэд багийн иргэдийн санал хүчинтэй	Аймаг, сум, баг	Дүрд оролцож, хэлэлцэнэ. Дүрүүд: Иргэн, Компани, Багийн ИНХ, Сумын ЗД, Сумын ИТХ, Аймгийн ЗД, Шүүх	ЗЗНДНгУТХ, Газрын тухай хууль, бусад
2. Багийн ИНХ-ын нэхэмжлэл хүчингүй болсон нь	Аймаг, сум, баг	Дүрд оролцож, хэлэлцэнэ. Дүрүүд: Багийн ИНХ, Шүүх	ЗЗНДНгУТХ, Газрын тухай хууль, бусад
3. Дүүргийн ИТХ-ын тогтоол, Засаг даргын захирамж юуны учир буруудав?	Нийслэл, дүүрэг	Дүрд оролцож, хэлэлцэнэ. Дүрүүд: Дүүргийн ИТХ, ЗД, Шүүх	ЗЗНДНгУТХ, Газрын тухай хууль, бусад
4. Малчид, тариаланчдын үйл ажиллагааны зохицуулалт	Аймаг, сум, баг	Баримт бичиг боловсруулна.	Үлгэрчилсэн дүрэм
5. Дархан цаазат Богдхан уулын тусгай хамгаалалттай газрын хил заагийн тухай	Нийслэл, дүүрэг	Дүрд оролцож, хэлэлцэнэ. Дүрүүд: Тусгай хамгаалалтын газар, Газрын харилцааны байгууллага, УИХ-ын гишүүн	ТХГНТХ, Газрын тухай хууль
6. Орон нутгийн тусгай хамгаалалтад авахад гарсан алдаа, сургамж	Аймаг, сум, баг	Дүрд оролцож, хэлэлцэнэ.	ТХГНТХ, Газрын тухай хууль

Дасгалын хураангуй

Сум, дүүрэг, баг, хороонд Газрын харилцаа, Байгаль орчин, Тусгай хамгаалалтай холбоотойгоор бодит амьдралд үүдсэн асуудлыг шийдсэн арга ажиллагаа, туршлагаас суралцахад зориулж дасгалын үлгэрчилсэн сэдвийг боловсруулав. Сургагч багш энд бичигдсэн дасгалыг оролцогчдоор хийлгэхийн зэрэгцээ эдгээр дасгалаас санаа авч баяжуулж, хөгжүүлж болно.

I. Мал аж ахуй: бэлчээр, усалгаа, өвөлжөө, хаваржаа, намаржаа, зуслангийн хуваарийг хийж буй арга ажиллагаа, туршлага, дасгал		
1. Бэлчээрийн менежмент - иргэдийн оролцоо	Багаар ажиллана	Бэлчээрийн тухай дүрэм, журам /хуулийн төсөл/
2. Нөөц бэлчээр ашиглалт	Багаар ажиллана	
3. Өвөлжөө, хаваржааны нутаг хуваарилсан	Багаар ажиллана	
II. Газар тариалан: хөрсний элэгдэл, хамгаалал, сэлгэлт, химийн бордооны хэрэглээ, эерэг болон сөрөг нөлөөлөл, туршлага, дасгал		
4. Нишингэ, рапс тариалахыг дэмжсэн шийдвэр /ИТХ-ын тогтоол, Засаг даргын захирамж, тариалсан талбай, ургац, хөрс газарт үүссэн өөрчлөлт/	Багаар ажиллана	Ургамал, газар тариалангийн тухай багц хуулиуд
5. Нишингэ, рапс тариалахыг хориглосон шийдвэр /ИТХ-ын тогтоол, Засаг даргын захирамж, тариалсан талбай, ургац, хөрс газарт үүссэн өөрчлөлт/	Багаар ажиллана	
6. Химийн бордооны хилээр орох хяналт, хэрэглээ, бордоог хэрэглэх стандарт, бороо хэрэглэсэн үеийн ургац, бордоог хэтрүүлэн хэрэглэсэн үеийн ургац зэргийг баримтжуулж, хэлэлцэх	Багаар ажиллана	
III. Хот байгуулалт: хот суурингийн төлөвлөлт, хог хаягдлын асуудлыг шийдэж буй туршлага, арга ажиллагаа, үр дүн		
7. Малтай өрхийн талаар баримтлах бодлого	Багаар ажиллана	Хот, тосгоны тухай хууль Хот байгуулалтын тухай хууль
8. Ногоон байгууламжийн ашиглалт, хамгаалалт	Багаар ажиллана	
9. Хог тээвэрлэлт, ангилах, устгах үйл ажиллагаа	Багаар ажиллана	
10. Хог хаягдлын цэгийн менежмент - иргэдийн оролцоо	Багаар ажиллана	
IV. Тусгай хамгаалалт, ойжуулалт, түймэр, нөхөн сэргээлтийн ажил, туршлага		
11. Ойн сан бүхий газраас цэвэрлэгээний журмаар мод ашиглуулах	Багаар ажиллана	Байгаль орчин, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай багц хуулиуд
12. Ойн сан бүхий газраас цэвэрлэгээний журмаар мод ашиглуулах	Багаар ажиллана	
13. Тусгай хамгаалалтад авах	Багаар ажиллана	
14. Орон нутгийн тусгай хамгаалалтад авах	Багаар ажиллана	
15. Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул, ашиглалт	Багаар ажиллана	
16. Уул уурхай ашиглалт, нөхөн сэргээлт	Багаар ажиллана	
17. Уул уурхайн нөхөн сэргээлт хийх	Багаар ажиллана	
18. Түгээмэл тархацтай ашигт малтмал	Багаар ажиллана	

Кейс 1. Тариалангийн зориулалтаар газар эзэмшүүлэхэд багийн иргэдийн санал хүчинтэй

Иргэн Д нэхэмжилдээ: “Сумын удирдлагууд багийн иргэдийн саналыг авалгүй дур мэдэн шийдвэр гаргаж хууль зөрчсөн. Багийн ИНХ-ын шийдвэргүйгээр сумын ИТХ-ын дарга, засаг дарга нар 969 га газрыг хууль бусаар олгосон” гэж 2013.09.27-ны өдөр шүүхэд ханджээ.



А аймгийн засаг дарга, Х сумын засаг дарга нар А багийн ИНХ-ын шийдвэр, (өмнө ажиллаж байсан) сумын засаг даргын шийдвэрийг буруутгаж, захирамжуудыг удаа дараа хүчингүй болгосныг Захиргааны анхан, давж заалдах, дээд шүүхийн хянах шалгах гэсэн 3 шатанд нэхэмжилж, шалгуулж, 9 удаагийн хурал хийлгэж 2 жил үргэлжилжээ.

Үйл явдлын хураангуй¹²

- 1) А аймгийн Б сумын ИТХ-ын 2010.06.21-ний өдрийн тогтоол, Засаг даргын 2010.06.21-ний “Газар эзэмшүүлэх тухай” А/47 дугаар захирамжаар дуудлага худалдаагаар К компанид газар эзэмшүүлэх шийдвэр гаргасан:
 - ~ *Аймаг, сумын Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 969 га газрыг дуудлага худалдаагаар К компани эзэмших болов. Эзэмшил газарт тариа тариалах бэлтгэл ажил, хөрөнгө оруулалт бэлтгэсэн боловч үйл ажиллагаа эрхлээгүй.*
 - ~ *969 га газрыг газар тариалангийн зориулалтаар эзэмшүүлсэн бөгөөд үүний 500 га нь атарисан (1960-70 оны үед газар тариалан явуулж байсан) газар, 469 га нь бэлчээр байна. Атарисан 500 газрыг бэлчээрт шилжүүлэх тухай, мөн бэлчээрийн 469 га газрыг тариаланд шилжүүлэх тухай Засгийн газрын тогтоол байхгүй болно.*
- 2) Сумын ИТХ-ын 2012.08.10-ны өдрийн хурлын тэмдэглэлд “Тухайн газрыг сүүлийн 30 гаруй жилд бэлчээрийн зориулалтаар ашиглаж байсан” гэдгийг онцолсон байна.
- 3) Сумын Засаг даргын 2012.11.16-ны өдрийн “Захирамж хүчингүй болгох тухай” А/89 дүгээр захирамжаар “Багийн иргэдийн бэлчээрийг тариалан болгож өөрчлөхийг эсэргүүцсэн санал болон 2 жил ашиглаагүй¹³” гэдгийг үндэслэж “К компанийн газар тариалангийн зориулалтаар эзэмших эрхийг хүчингүй болгов”
 - ~ *К компанийн газар эзэмших эрх дуусгавар болов.*

¹² Эх сурвалж: (www.shuukh.mn сайт 2016)

¹³ Монгол Улсын дээд шүүхийн зөвлөмж “Газрын тухай хуулийг шүүхийн практикт нэг мөр ойлгож, зөв хэрэглэх тухай”, 2008.03.31, №15 “газраа зориулалтын дагуу 2 жил дараалан ашиглаагүй” гэдгийг гэрээ хийгдсэнээс хойш хуанлийн бүтэн 2 жилийн дотор газар эзэмшигч нь тухайн газар дээрээ гэрээнд заасан нөхцөл, болзол, зориулалтын дагуу тодорхой үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлээгүй (барилга, байгууламж, зам талбай, тариалан эрхлээгүй г.м) байхыг ойлгоно.

- 4) Сумын Засаг даргын 2013.09.23-ны тогтоолд “Тухайн газрыг бэлчээрийн зориулалтаар ашиглаж ирсэн” А/118 дугаар захирамжаар 2012.11.16-ны өдрийн А/89 дүгээр захирамжийг хүчингүй болгосон
 ~ *К компанийн газар эзэмших эрх сэргэв.*
- 5) Сумын I багийн ИНХ-ын 2013.11.20-ны тогтоолд “Тухайн газрыг бэлчээрийн зориулалтаар ашиглаж ирсэн” гэдгийг санал нэгтэй тусгасан
- 6) Захиргааны хэргийн анхан шатны 2014.02.10-ны өдрийн .. дугаар шийдвэр “Газрын тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4-д заасны дагуу эхлээд багийн ИНХ-ын саналыг авах байсан” гэдэгт үндэслэж, “Б сумын Засаг даргын А/89 дүгээр захирамж хүчинтэй” гэж иргэн Д-ийн нэхэмжлэлийг шийдсэн
 ~ *К компанийн газар эзэмших эрх хууль бус байсныг тогтоож, эрхийг дуусгавар болгосон*
- 7) Аймгийн Засаг дарга 2014.03.20-ны өдрийн А/156 дугаар захирамжаар “Газар тариалангийн зориулалтаар дуудлага худалдаагаар хуулийн дагуу К компанид газар эзэмшүүлсэн байхад Б сумын Засаг дарга үндэслэлгүйгээр газар эзэмших эрхийг хүчингүй болгосон” гэж үзээд Б сумын Засаг даргын А/89 дугаар захирамжийг хүчингүй болгов.
 ~ *Шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон байхад А аймгийн Засаг дарга А/156 захирамж гаргасан*
 ~ *К компанийн газар эзэмших эрх дахин сэргэв*
- 8) Захиргааны хэргийн анхан шатны шүүх хуралдааны 2015.01.27-ны өдрийн 5 дугаар шийдвэр: Газрын тухай хуулийн 4 дүгээр¹⁴ зүйлийн 4.1.3, 4.1.4, 61 дүгээр зүйлийн 61.1, ЗЗНДНТУ-ын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ийн ж-д¹⁵ заасныг баримтлан нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд хангаж, А аймгийн Засаг дарга 2014.03.20-ны өдрийн “Захирамж хүчингүй болгох тухай” А/156 дугаар захирамжийг хүчингүй гэж шийдвэрлэжээ.
 ~ *Аймгийн Засаг даргын захирамж хүчингүй болов.*
 ~ *Тус газрыг Засаг дарга “тариалангийн газар” гэж үзсэн бол “Багийн ИНХ-ын санал авах журмыг зөрчиж”, мөн газар тариалангийн газар гэдгийг баттай нотолсон баримтгүйгээр газар эзэмших эрхийг сэргээсэн байна.*
 ~ *Тус газар нь бэлчээрийн зориулалттай ашиглаж ирсэн тул сумын Засаг даргын А/89 дүгээр захирамж Газрын тухай хуулийн 6 дугаар¹⁶ зүйлийн 6.2, 52 дугаар зүйлийн 52.1, 52.2 дахь заалттай нийцэж байна.*
- 9) Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх хуралдааны 2015.03.25-ны өдрийн 145 дугаар шийдвэр “Захиргааны хэргийн анхан шатны 2015.01.27-ны өдрийн 5 дугаар шийдвэрийг хэвээр үлдээж”
 ~ *Үүний дараа К компанийн гурав дахь шатны шүүхэд хандав.*

¹⁴ Газрын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3. Газар өмчлөх, эзэмших, ашиглахад шударга ёс, тэгш байдлыг хангах, 4.1.4. Газрыг хуульд заасан нөхцөл, журмын дагуу үндсэн зориулалтаар нь үр ашигтай, зохистой эзэмших, ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх;

¹⁵ Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ийн ж.

¹⁶ Газрын тухай хуулийн 6 дугаар зүйл. Хуульд өөрөөр заагаагүй бол дараах газрыг төрийн зохих шатны байгууллагын хяналт, зохицуулалттайгаар нийтээр ашиглана: 6.2.1. бэлчээр, бэлчээр дэх уст цэг, хужир мараа бүхий газар;

- 10) Дээд шүүхийн хяналтын шатны Захиргааны хэргийн шүүх хуралдааны 2015.05.25-ны өдрийн 129 дугаар шийдвэр “Захиргааны хэргийн анхан шатны 2015.01.27-ны өдрийн 5 дугаар шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх хуралдааны 2015.03.25-ны өдрийн 145 дугаар магадлалыг тус тус хэвээр үлдээж” тогтоол гаргажээ.

Хэлэлцүүлэг:

- 1) Энэ хэрэг яагаад 2 жил, 3 шатны шүүхээр дамжих болов?
- 2) Багийн иргэд, ИНХ-ийн алдаа, амжилт юу вэ?
- 3) Сумын ИТХ, Засаг даргын алдаа, амжилт юу вэ?
- 4) Аймгийн Засаг даргын алдаа, амжилт юу вэ?
- 5) К компанид ямар буруу байсан бэ? К компани хохирсон уу?
- 6) Атар газар, бэлчээр, тариалангийн газрын зориулалтын өөрчлөлтийг ямар төвшинд хэзээ шийддэг вэ? Хаана шийдэх хэрэгтэй вэ?
- 7) Танай суманд ийм үйл явдал тохиолдсон уу? Тухайлбал, Газар эзэмшүүлэхдээ Багийн ИНХ-ын санал авдаг уу?
- 8) Сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан боловч яагаад хүчингүй болов?
- 9) Дуудлага худалдаагаар 969 га газрыг эзэмшихэд ямар хэмжээний төлбөр, хураамжийг ямар хугацаанд, хаана төлөх вэ? Түүнийг ямар зориулалтаар хэн ашиглах вэ?
- 10) Дуудлага худалдаагаар газар эзэмших эрх цуцлагдсан үед төлсөн төлбөр, хураамжийн ямар төрлийг буцаан олгох, ямар төрлийг буцааж олгохгүй вэ?
- 11) Оролцогч талуудын хариуцлага хаана суларсан байна вэ?

Кейс 2. Багийн ИНХ-ын нэхэмжлэл хүчингүй болсон нь

А аймгийн Б сумын Засаг даргын шийдвэрээр Т байгууллагад эзэмшүүлсэн 1 га газрыг I багийн ИНХ-аар хэлэлцээгүй, иргэдийн саналыг аваагүй гэж үзэж Захиргааны хэргийн шүүхэд ханджээ. Энэ асуудал 2 шатны шүүхээр 2 жил дамжин хэлэлцээд, Багийн ИНХ-ын нэхэмжлэл хэрэгсэхгүй болсон байна.



Үйл явдлын хураангуй

- 1) Т байгууллага нь Б сумын Засаг даргад 2013.01.10-ны өдөр Газрын тухай хуулийн 32 дугаар зүйлд дагуу хүсэлтээ албан бичгээр өгсөн
- 2) А аймгийн Б сумын Засаг даргын 2013.01.28-ны өдрийн А/07 дугаар захирамжаар 1 га газрыг Т байгууллагад 15 жилийн хугацаатай эзэмшүүлэх шийдвэр гаргасан

- ~ *Захирамжийн дагуу Газрын даамал газар дээр солбицлыг 2013.03.01-нд хэмжиж, 2013.11.14-ны өдөр “Газар эзэмших гэрээ, гэрчилгээ” олгосон*
 - ~ *Тус газар нь сумын төвийн суурьшилийн бүсэд хамаарах бөгөөд Т байгууллага хашаа барьсан*
- 3) Б сумын А багийн ИНХ 2013.10.05-ны өдөр хуралдаж, Т байгууллагын хашааны газар нь
- a. Сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй,
 - b. ИТХ-ын шийдвэр байхгүй
 - c. Улсын баяр наадмын хурдан морины уралдаан олон жил уламжлал болдог, мөн машин зам, онгоц бууж байсан зэрэг зарим хэсгийг хаасан,
 - d. Сумын төвийн өнгө үзэмж, эмх цэгцэд сөргөөр нөлөөлөх, нийтийн эрх ашгийг ноцтойгоор зөрчсөн шийдвэр
 - e. Энэ хашаатай зэрэгцүүлж, барьцаж иргэд хашаа барихаар зэхэж байна гэсэн шүүмжийн дагуу
 - f. Газрын хэмжээг багасгах, эсвэл хашааг өөр газар барих хэрэгтэй
 - g. “Сумын наадам үздэг талбайг улам багасгаж, нийтийн эрх ашиг зөрчсөн хуулийг илтэд хүндэтгэж үзээгүй тул шийдвэрийг хүчингүй болгох шаардлагатай” гэж санал, тогтоол гаргаж, Сумын ИТХ, Засаг даргад хандсан
- 4) Б сумын ИТХ 2013.12.16-ны өдөр хуралдаж, 42 дугаар тогтоол гаргаж, “хашааны хэмжээг анх олгосон хэмжээнээс хэтрүүлсэн тул багасгах” шаардлагыг Т байгууллагад хүргүүлсэн
- 5) ИТХ-ын тогтоолын дагуу арга хэмжээ аваагүй буюу Т байгууллага тайлбарлахдаа
- a. Т байгууллага 2012 онд байгуулагдаж, захиргааны байрыг улсын төсвөөр 2013 онд баригдах болсон, үүнийг сумын Засаг дарга мэдэж байх учиртай
 - b. Сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд оруулах (Сумын ИТХ 2013.01.13-нд хуралдаж, уг төлөвлөгөөг баталсан) нь Засаг дарга, Газрын даамлын ажил үүрэг, тусгагдсан эсэхийг манай байгууллага мэдэх үүрэггүй
 - c. Газрын даамлын хэмжиж, бичиж өгсөн 1 га газрыг л бид хашаалсан
 - d. Онгоц буудаг талбайг нэгэнт ашиглахаа больсон, морин уралдаанд саад болох зүйлгүй
 - e. Хашаа өнгө үзэмж сайн бөгөөд хашаандаа 108 мод, бут сөөгийг тарьж ургуулж, ногоон байгууламж хийсэн
 - f. I багийн ИНХ 2013.10.05-ны өдөр хуралдаагүйг нотолно, түүний тогтоол гэдэг хуурамч буюу 2016.02.18-ны өдөр (2 жил, 4 сарын дараа) гэнэт гарч ирсэн баримт
 - g. Эдгээр нь Т байгууллагын үйл ажиллагааг эсэргүүцсэн хэсэг хүмүүсийн ажил.
- 6) Б сумын Засаг даргын 2015.05.29-ны өдрийн А/60 дугаар захирамжаар “газар эзэмших эрхийг цуцалж”, А/07 захирамжийг хүчингүй болгосон
- ~ *Засаг даргын шийдвэрээр хашааны хэсгийг албадан буулгасан*

- 7) Б сумын ИТХ 2015.07.04-ны өдөр хуралдаж, 42 дугаар тогтоолыг хэвээр баталсан
- 8) А аймгийн Засаг даргын 2015.07.02-ны өдрийн А/251 дүгээр захирамжаар Сумын Засаг даргын А/60 дугаар захирамжийг хүчингүй болгосон:
 - а. Сумын Засаг дарга “Газрын тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.3, 57.4 дахь заалтыг зөрчсөн гэж захирамж гаргасан” боловч “57.3.4” гэж бичилтийн алдаа гаргасан тул захирамжийг хүчингүй болгосон
 - б. Сумын Засаг даргад арга хэмжээ авсан
- 9) Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1-д заалтыг зөрчсөн тул “А аймгийн Б сумын Засаг даргын 2013.01.28-ны өдрийн А/07 дугаар захирамжийг хүчингүй болгуулах” нэхэмжлэлийг Захиргааны хэргийн шүүхэд өгсөн
- 10) А аймгийн Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2016.05.11-ны өдрийн .. дугаар шийдвэрээр “Газрын тухай хуулийн 4 дүгээр¹⁷ зүйлийн 4.1.3, 21 дүгээр зүйлийн 21.4.3, 22 дугаар зүйлийн 22.1.1, 22.1.2, 22.1.3, 27 дугаар¹⁸ зүйлийн 27.1, 33 дугаар зүйлийн 33.1.1, ЗЗНДНТУ-ын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.9-д заасныг баримтлан А аймгийн Б сумын I багийн ИНХ-ын “А аймгийн Б сумын Засаг даргын 2013.01.28-ны өдрийн А/07 дугаар захирамжийг хүчингүй болгуулах” шаардлага бүхий нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ”
- 11) А аймгийн Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2016.06.22-ны өдрийн .. дугаар шийдвэрээр “А аймгийн Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2016.05.11-ны өдрийн .. дугаар шийдвэр”-ийг хэвээр үзэж,
 - а. Маргаан бүхий газар нь бусдын эзэмшил газартай давхцаагүй, орц, гарцыг хаагаагүй бөгөөд нэхэмжлэлд дурдсан “авто зам, улсын баяр наадмын хурдан морины уралдааны замын зарим хэсэгт саад болсон, сумын төвийн өнгө үзэмж, эмх цэгцэд сөргөөр нөлөөлж, нийтийн эрх ашиг зөрчсөн” гэдэг нь шүүхийн үзлэгийн тэмдэглэл, гэрэл зургаар үгүйсгэгдэж (нотлогдохгүй) байна.
 - б. Т байгууллагад 1 га газар эзэмшүүлсэн нь “I багийн иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн” болох нь тогтоогдоогүй болно.

Хэлэлцүүлэг:

1. Энэ асуудал үүсэх болсон шалтгаан нь юу вэ?
2. Сумын ИТХ-ын үүрэг, хариуцлагатай холбож тайлбарлана уу?
3. Багийн ИНХ-ын үүргийг тодруулна уу?
4. Багийн ИНХ-аар тухайн асуудлыг нөхөн хэлэлцэж болох уу? Хэрэв болох бол хуралдсан хугацааг ямар он сараар бичих хэрэгтэй вэ?
5. Сумын Засаг даргын үүрэг, хариуцлагатай холбож тайлбарлана уу?
6. Газрын даамлын үүрэг, хариуцлагатай холбож тайлбарлана уу?
7. Аймгийн Засаг даргын үүрэг, хариуцлагатай холбож тайлбарлана уу?

¹⁷ Газрын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 4.1.3. газар өмчлөх, эзэмших, ашиглахад шударга ёс, тэгш байдлыг хангах;

¹⁸ Газрын тухай хуулийн 27 дугаар 27.1. Газрыг энэ хуульд заасан зориулалт, хугацаа, болзолтойгоор гэрээний үндсэн дээр зөвхөн эрхийн гэрчилгээгээр эзэмшүүлнэ.

8. Сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний ач холбогдол юу вэ? Түүнд оролцогчдын үүрэг, хариуцлага ямар байдаг вэ?
9. Т байгууллага ямар буруутай вэ?
10. Сумын ИТХ-ын шийдвэрийг Т байгууллага яагаад хэрэгжүүлээгүй вэ?
11. Танай суманд үүнтэй төсөөтэй асуудал үүсдэг үү?
12. Энэ асуудлыг оролцогч талуудын сонирхол эрх ашигт нийцүүлэн шийдэх боломж байсан уу? Байнга гомдол, санал тасрахгүй байхаар шийдэх ямар арга байна вэ?

Эх сурвалж: (www.shuukh.mn сайт 2016)

Кейс 3. Дүүргийн ИТХ-ын тогтоол, Засаг даргын захирамж юуны учир буруудав?

Дүүргийн ИТХ-ын тогтоол, Засаг Даргын захирамжаар аж ахуйн нэгжид 5 жилийн хугацаагаар газар эзэмшүүлээд, түүнийгээ хүчингүй болгосон тохиолдол олон гарч байна. Энэ нь зөв шийдвэр үү?

Үйл явдлын хураангуй¹⁹:

1. Дүүргийн Засаг даргын 2008.07.28-ны өдрийн “Хур хог цэвэрлүүлж, газрын зөвшөөрөл олгох тухай” 303 дугаар захирамжаар К-д аж ахуйн зориулалтаар 0.3 га газрыг эзэмшүүлсэн;
2. Дүүргийн Засаг даргын 2012.10.25-ны өдрийн “Газар ашиглах эрхийн нэршилжүүлэх, гэрээ сунгах, баталгаажуулах, зориулалт, талбай, байршил өөрчилөх тухай” А/437 дугаар захирамжаар тус газрын хэмжээг 0.28 га болгож, байршил өөрчилж, 5 жилийн хугацаатайгаар аж ахуйн зориулалтаар эзэмшүүлсэн;
3. Газрын албатай К нь 2013 онд гэрээ байгуулж, гэрчилгээ авч, кадастрын мэдээллийн санд бүртгүүлж, газрын төлбөрийг төлж, уг газарт хашаа барьж, аж ахуйн зориулалтаар ашигласан;
4. Дүүргийн ИТХ-ын 2013.04.24-ний “Газрын хууль тогтоомжийн хэрэгжилтийн тухай” 8/02 дугаар тогтоол, Дүүргийн Засаг даргын 2013.05.23-ны өдрийн А/287 дугаартай захирамжаар “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29.3-т заасны дагуу, инженерийн шугам сүлжээ давхацсан” гэсэн үндэслэлээр К-ийн газар эзэмших эрхийг хүчингүй болгосон;
5. К нь газар эзэмших эрхээ сэргээлгэхээр Захиргааны хэргийн шүүхэд 2015 оны 5 сард хандаж, Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2015.05.29-ний өдрийн 01 дугаар шийдвэрээр “К-ийн нэхэмжлэл гаргах хөөн хэлэлцэх хугацааг сэргээсэн”;
6. Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2015.11.05-ны өдрийн 02 дугаар хурлаар: Газрын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1, 40 дүгээр зүйлийн 40.1, 61 дүгээр зүйлийн 61.1 дэх хэсэгт заасныг баримтлан нэхэмжлэгч К-ийн нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж, Дүүргийн ИТХ-ын 2013.01.24-ний өдрийн 8/02 дугаар тогтоол, Дүүргийн Засаг даргын 2013.05.13-ны өдрийн А/287 дугаар захирамжийн К-д холбогдох хэсгийг тус тус хүчингүй болгож шийдвэрлэжээ (ө.х эрхийг сэргээсэн).
7. Анхан шатны шүүхийн шийдвэрийг Дүүргийн Засаг дарга эс зөвшөөрч, завж заалдах шатны шүүхэд гомдол гаргасан байна.

¹⁹ 2016-09-18 -нд www.shuukh.mn сайтаас татаж авав.

- a. 2013 оны А/437 тоот захирамж нь Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5.3, 31 дүгээр зүйлийн 31.1.2, 33 дугаар зүйлийн 33.4 дэх заалтыг зөрчин тухайн оны дүүргийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй, газар эзэмшүүлэх шийдвэр гаргах журам, хуулиар тогтоосон хязгаарлалт, зохицуулалтыг зөрчиж, хуульд заасан бүрэн эрхээ хэтрүүлэн, захиргааны акт гаргах эрх зүйн үндэслэлгүй газар эзэмших эрх олгосон;
 - b. Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.6 дахь заалтыг зөрчин газрыг хуульд заасан хугацаанд К нь 2008 оноос хойш зориулалтын дагуу ашиглаагүй тул Дүүргийн Засаг даргын шийдвэр хүчинтэй тул нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож өгнө үү.
8. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2016.01.13-ны өдрийн 03 дугаар магадлалаар: Анхан шатны шүүхийн 2015.11.05-ны өдрийн 02 дугаар шийдвэрийг хэвээр үлдээж, Дүүргийн Засаг даргын итгэмжлэгдсэн төлөөлөгчийн давж заалдах гомдлыг хангахгүй орхиж шийдвэрлэжээ.
9. Дүүргийн ИТХ-ын итгэмжлэгдсэн төлөөлөгч: Засаг даргын 2008 оны 303 тоот захирамж, 2013 оны А/437 тоот захирамжаар К-д газар эзэмшүүлэхдээ
- a. Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5.3, 31 дүгээр зүйлийн 31.2 “Хүсэлт гаргасан газрын байршил нь аймаг, нийслэл, сум, дүүргийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлж болохоор заагдсан байна”, 33 дугаар зүйлийн 33.1.2, дугаар зүйлд “газар эзэмших хүсэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмшүүлэх асуудлыг тухайн шатны Засаг дарга дуудлага худалдаа, төсөл шалгаруулах зарчмаар шийдвэрлэнэ” гэж заасан байхад тухайн заалтыг ноцтойгоор зөрчин газар эзэмшүүлсэн байна.
 - b. Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.4 дэх хэсэгт “Аймаг, нийслэл, сум, дүүргийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд эзэмшүүлж болохоор зааснаас бусад газар эзэмшүүлэхийг хориглоно” гэж заажээ.
 - c. Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.6 дахь заалтыг зөрчиж газрыг хуульд заасан хугацаанд, гэрээнд заасан зориулалтын дагуу ашиглаагүй, газар эзэмшүүлэх шийдвэр гаргах журам, хуулиар тогтоосон хязгаарлалт, зохицуулалтыг зөрчиж, захиргааны акт гаргах эрх зүйн үндэслэлгүй газар эзэмших эрхийн гэрчилгээ олгосон байна.
 - d. Иймд Дүүргийн ИТХ Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1, 57 дугаар зүйлийн 57.1 дэх заалтыг үндэслэн дүүргийн ИТХ-ын ээлжит ...-р хуралдаанаас Дүүргийн Засаг даргын 2008 оны 303, 2012 оны А/437 дугаар захирамжийн К-д холбогдох хэсгийг хүчингүй болгохыг дүүргийн Засаг даргад даалган шийдвэрлэсэн. Иймд Нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэж өгнө үү.
10. Засаг даргын итгэмжлэгдсэн төлөөлөгч:
- a. Дээд шүүхийн хяналтын шатны Захиргааны хэргийн шүүхэд “Газрын тухай болон бусад хууль тогтоомжийг зөрчин газар эзэмшиж байсан К-ийн газар эзэмших эрхийг хүчингүй болгож, Монгол Улсын Засаг

захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухайн хуулийн дагуу гаргасан Дүүргийн Засаг даргын захирамжийг хүчингүй болгон шийдвэрлэж, дээрх хуулиудын хэрэгжилтийг хязгаарласан, газар эзэмшигчийн хууль бус ажиллагааг дэмжин гарсан Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2015.11.05-ны өдрийн 02 дугаар шийдвэр, түүнд давж заалдан гаргасан Дүүргийн Засаг даргын гомдлыг хянан хэлэлцэж гаргасан Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2016.01.13-ны өдрийн 03 дугаартай магадлалыг хууль зөрчсөн болохыг тогтоон хүчингүй болгож шийдвэрлэж өгнө үү” гэжээ.

11. Дээд шүүхийн хяналтын шатны Захиргааны хэргийн шүүхийн 2016.03.14-ны 04 дугаар шийдвэр:


- a. Дүүргийн ИТХ-ын хуралдааны 2013.04.24-ний өдрийн “Газрын хууль тогтоомжийн хэрэгжилтийн тухай” 8/02 дугаар тогтоолоор нэхэмжлэгч К-ийн газар эзэмших эрхийг хүчингүй болгохыг Дүүргийн Засаг даргад даалгаж шийдвэрлэсэн нь Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал газрын харилцааны талаар дараах нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 20.1.1-д “газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, гаргасан шийдвэрийнхээ биелэлтэд хяналт тавих, энэ талаарх Засаг даргын тайланг хэлэлцэж дүгнэх”, 20.1.2-т “тухайн шатны Засаг даргын өргөн мэдүүлсэн аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, түүнд нийцүүлэн боловсруулсан сум, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хэлэлцэн батлах” гэж Дүүргийн ИТХ-ын газрын харилцааны талаарх бүрэн эрхийг тодорхойлсон хуулийн заалтад нийцээгүй, нэхэмжлэгчийн газар эзэмших, ашиглах эрхийг зөрчсөн болох нь тогтоогджээ.
- b. Дүүргийн ИТХ нь хуулиар өөрт олгогдоогүй чиг үүргийг хэрэгжүүлж, хууль бус тогтоол гаргасныг үндэслэн тус дүүргийн Засаг дарга 2013.05.23-ны өдрийн А/287 дугаар захирамж гаргаж нэхэмжлэгчид газар эзэмших эрхийг олгосон тус дүүргийн Засаг даргын 2008 оны 303, 2012 оны А/437 дугаар захирамжийн нэхэмжлэгчид холбогдох хэсгийг тус тус хүчингүй болгосон нь дараах байдлаар хуульд нийцээгүй байна.
- c. Тодруулбал хариуцагч Дүүргийн Засаг дарга нь газар эзэмшигчийн хүсэлтийг хүлээн авч 2012.10.25-ны өдөр А/437 дугаар захирамжаар эзэмшүүлсэн газрын хэмжээ, байршлыг өөрчлөн эзэмших хугацааг сунгасан, үүнд тулгуурлан гэрээг шинээр байгуулж, гэрчилгээ шинээр олгосон атлаа 2013.05.23-ны өдөр маргаан бүхий А/287 дугаар захирамжийг гаргаж нэхэмжлэгч нь газрыг зориулалтын дагуу ашиглаагүй, Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.6-д заасныг зөрчсөн хэмээн хуанлийн тооллоор 2 жил болоогүй байхад дээрх үндэслэл зааж хүчингүй болгосон нь буруу болжээ.
- d. Түүнчлэн нэхэмжлэгчид газар эзэмшүүлсэн захирамж нь Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5.3, 31 дүгээр зүйлийн 31.1.2, 33 дугаар зүйлийн 33.4 дэх заалтыг зөрчин тухайн оны дүүргийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй, газар эзэмшүүлэх шийдвэр гаргах журам, хуулиар тогтоосон хязгаарлалт, зохицуулалтыг зөрчиж

хуульд заасан бүрэн эрхээ хэтрүүлэн, захиргааны акт гаргах эрх зүйн үндэслэл байхгүй байхад газар эзэмшүүлэх эрх олгосон, инженерийн шугам сүлжээ давхацсан үндэслэлээр Компанид эзэмшүүлсэн захирамжийн холбогдох хэсгийг хүчингүй болгосон гэж тайлбарлаж байгаа нь үндэслэлгүй юм.

Хэлэлцэх асуулт

1. Энэ асуудал үүсэх болсон шалтгаан нь юу вэ?
2. Дүүргийн ИТХ-ын үүрэг, хариуцлагатай холбож тайлбарлана уу?
3. Дүүргийн Засаг даргын үүрэг, хариуцлагатай холбож тайлбарлана уу?
4. Дүүргийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний ач холбогдол юу вэ? Түүнд оролцогчдын үүрэг, хариуцлага ямар байдаг вэ?
5. К байгууллага ямар буруутай вэ?
6. Танай дүүрэгт үүнтэй төсөөтэй асуудал үүсдэг үү?
7. Энэ асуудлыг оролцогч талуудын сонирхол эрх ашигт нийцүүлэн шийдэх боломж байсан уу?

Кейс 4. Малчид, тариаланчдын үйл ажиллагааны зохицуулалт



“Сэлэнгэ аймгийн ИТХ-ын малчид, тариаланчдын үйл ажиллагааны зохицлыг хангах журам” (2013), (Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлуудын сайн туршлагын эмхтгэл 2016, 55-56) ийг хэлэлцэж, өөрийн аймаг, сумынхаа онцлогтой уялдуулж журам боловсруулна уу. Журмыг хавсгаргав.

Малчид, тариаланчдын үйл ажиллагааны зохицлыг хангах журам

*Сэлэнгэ аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2013 оны 10 дугаар сарын 18-ны
өдрийн 25 дугаар хурлын тогтоолын
хавсралт*

Нэг. Журмын зорилго

Энэхүү журам нь таримал ургамал, тариалангийн талбайг мал, тэжээвэр амьтдаас хамгаалахын тулд малчид, тариаланчдын үйл ажиллагааны зохицлыг ханган, тэдгээрийн үүрэг хариуцлагыг тодорхой болгож таримал ургамал тариалагч, малчин, мал бүхий иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Ерөнхий зүйл

- 2.1. Таримал ургамлыг мал, амьтдаас хамгаалах журмыг хэрэгжүүлэхдээ Монгол Улсын холбогдох хуулийн заалтыг баримтлан гүйцэтгэнэ.
- 2.2. Үр тариа, тэжээлийн ургамал, таримал хадлан, жимс, жимсгэнэ, төмс, хүнсний ногоо, олон наст ургамал болон ойг нөхөн сэргээх зориулалтаар тарьсан ба хашиж хамгаалсан мод, бут, сөөг, хот тосгоны ногоон байгууламжийн ургамлуудыг таримал ургамалд хамааруулна.
- 2.3. Энэ журамд Газрын тухай хууль, Тариалангийн тухай хууль, Таримал ургамлын тухай хууль, Таримал ургамлын үр сортын тухай хуулинд заасны дагуу тарьж эхэлснээс ургац хураан авч дуусах хүртэл хугацаа хамаарна.

- 2.4. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн таримал ургамал тариалсан талбайгаа хашаажуулах, тэмдэг-жүүлэх, харуул хамгаалалттай байлгах үүрэг хүлээнэ.
- 2.5. Малчин, мал бүхий иргэд, байгууллага, аж ахуйн нэгж нь өөрсдийн мал, тэжээвэр амьтдыг байнгын хариулга, маллагаатай, хараа хяналттай байлгах үүрэг хүлээнэ.
- 2.6. Зөрчил гаргасан тохиолдолд Иргэний хууль, Газрын тухай хууль, Захиргааны хариуцлагын тухай хууль болон энэ журамд заасны дагуу хохирлыг төлүүлэх асуудлыг шийдвэрлэнэ.

Гурав. Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага болон сум, багийн Засаг даргын үүрэг

3.1. Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үүрэг

- 3.1.1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал бүрэн эрхийнхээ хүрээнд малчин, мал бүхий иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын малд төлбөр, хураамж ногдуулах хэмжээг тогтоох.
- 3.1.2. Малчид, тариаланчдын үйл ажиллагааг зохицуулсан журам батлах, өөрчлөх.
- 3.1.3. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь сумын Засаг даргын дэргэдэх үнэ тогтоох комиссын санал, тухайн зах зээлийн үнэ ханшийг үндэслэн малын жишиг үнэлгээг тогтоох.
- 3.1.4. Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тариаланчид, ногоочид, малчдын саналыг өргөн тусгаж өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржааны газрыг багийн иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

3.2. Сумын Засаг даргын үүрэг

- 3.2.1. Таримал ургамал тариалсан газрын нэр, байршил, тариалалт эхлэх, ургац хурааж дуусах хугацааны талаар шийдвэр гаргаж нийтэд зарлан мэдээлнэ.
- 3.2.2. Малчид, мал бүхий иргэдийн хаваржих, зусах, намаржих газар болон эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бус нутгийн газрыг малын тоо, газар тариалангийн талбайн байршилыг харгалзан тогтоож, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.
- 3.2.3. Холбогдох мэргэжилтнүүд, малчид, тариаланчдын төлөөлөл оролцсон хохирол тогтоох сумын комисс байгуулна. Сумын Засаг даргын орлогч, багийн Засаг дарга, Байгаль орчны байцаагч, Газрын даамал, Хөдөө аж ахуйн тасгийн дарга болон Газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн, иргэний төлөөлөл гэх мэт
- 3.2.4. Таримал ургамлын талбайд мал тэжээвэр амьтад орж хохирол учирсан тохиолдолд хохирлыг сумын комисс тухайн таримал тариалсан эзэн, тарианд орсон мал, тэжээвэр амьтны эздийг байлцуулан тогтоож баталгаажуулна.
- 3.2.5. Тариалангийн талбайд мал орж хохирол учруулсан мэдээлэл ирсэн тохиолдолд сумын комисс 2 хоногт багтаан газар дээр нь очиж, хоёр талын төлөөлөгч, хөндлөнгийн гэрчийг байлцуулан хохирлын акт тогтооно. Сумын комиссын зардлыг таримал ургамал тариалагч хариуцна.
- 3.2.6. Хохирол учруулсан нь тогтоогдвол холбогдох хууль тогтоомжийн дагуу эрх бүхий улсын байцаагч захиргааны хариуцлага тооцно.
- 3.2.7. Сумын комиссын тогтоосон хохирлын актыг талууд эс зөвшөөрвөл гомдлоо шүүхэд гаргана.
- 3.2.8. Малын өвөлжөө, хаваржаа, намаржааны болон сумын төв, суурин газрын ойролцоо таримал ургамал тариалсан талбайг хашаажуулах арга хэмжээг орон нутгийн хөгжлийн сан, төсөл, хөтөлбөр аж ахуйн нэгж, малчид байгууллагын хөрөнгөөр хамтран шийдвэрлэнэ.
- 3.2.9. Малчид, тариаланчдын зөвлөгөөн, уулзалтыг жил бүр зохион байгуулж малчид, тариаланчдыг мэдээ, мэдээллээр ханган ажиллана.
- 3.2.10. Таримал ургамлын талбайгаас 500 метрийн дотор өвөлжөө, хаваржааны газар шинээр олгохгүй байна.
- 3.2.11. Хамтын хөдөлмөрөөрөө хоршин, бүлэг хоршооны зохион байгуулалтад орж, мал аж ахуйгаа эрчимжүүлсэн малчдад нутаг бэлчээрээ зүй зохистой ашиглахад дэмжлэг үзүүлж тэжээлийн ургамал тариалах талбай олгож болно.

3.3. Багийн Засаг даргын үүрэг

- 3.3.1. Энэхүү журмыг нийт тариаланч малчин, мал бүхий иргэд аж ахуйн нэгж, байгууллагуудад таниулах сурталчлах ажлыг зохион байгуулна.
- 3.3.2. Сумын төв, суурин газрын малыг тариалалт эхлэхээс дуусах хүртээх хугацаанд байнгын хариулга, маллагаатай байлгах талаар зохион байгуулалтын арга хэмжээг авна.
- 3.3.3. Багийн Засаг дарга хаваржаа, намаржаа, өвөлжөө, зуслан болон сумын төв, суурин газрын ойролцоо таримал ургамал тариалсан иргэн, аж ахуйн нэгж, тэнд нутаглаж буй малчид, мал бүхий иргэдтэй гурвалсан гэрээ байгуулж харилцан үүрэг хүлээж, журмын хэрэгжилтийг зохион байгуулж ажиллана.

Дөрөв. Таримал ургамал тариалагчийн үүрэг

- 4.1. Тариалан эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь өмчөө хамгаалах зорилгоор тариалсан талбайнхаа ойролцоо нутагладаг мал бүхий иргэн, айл өрх, аж ахуйн нэгжтэй тарианд мал оруулахгүй байх, оруулсан нөхцөлд хохирлыг хэрхэн тооцох талаар тохиролцон гэрээ байгуулна.
- 4.2. Таримал ургамал бүхий талбайд орж хохирол учруулсан мал, тэжээвэр амьтны эзэн нь тогтоогдоогүй нөхцөлд мал амьтныг зориулалтын хашаанд хашиж энэ тухай сумын комиссод мэдэгдэн эзэн нь тогтоогдсон үед хашиж малласан хугацаанд гарсан зардал учруулсан хохирлыг нөхөн төлүүлнэ.
- 4.3. Таримал ургамал бүхий талбайд мал орж хохирол учруулсан бол орсон малын тоо, зүс, ээмэг, тамга, малын мөр, таримал ургамлыг сүйтгэсэн байдлыг фото зураг, видео камераар баталгаажуулан баримтжуулна.
- 4.4. Тариалан эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага таримал ургамлаа мал, тэжээвэр амьтдаас хамгаалж хашаа барих, харуул сахиул гаргах замаар байнгын хамгаалалтад байлгана,
- 4.5. Тариалсан талбайг тэмдэгжүүлж 500 хүртэл га тутамд нэг манаач, сахиул байхаар тооцон унаа, холбооны хэрэгслээр хангаж ажиллана.
- 4.6. Сумын төв, суурин газрын ойролцоо таримал ургамал тариалсан аж ахуйн нэгж, байгууллага, иргэд нь талбайгаа өөрийн хүч хөрөнгөөр хашаажуулна.
- 4.7. Таримал ургамал тариалагч, иргэн аж ахуйн нэгж, байгууллага тариалсан талбайд орсон мал, тэжээвэр амьтдыг тусгайлан хашиж, сумын комисс болон эзэнд нь мэдэгдэж тоо толгой, аюулгүй байдлыг бүрэн хариуцна.
- 4.8. Сумын комиссыг өөрсдийн унаа, зардлаар авч хохирлоо тогтоолгоно.
- 4.9. Таримал ургамалд мал, тэжээвэр амьтад хохирол учруулсан нөхцөлд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс тогтоосон жишиг үнэлгээнд үндэслэн учирсан хохиролд дүйцэхүйц мал, тэжээвэр амьтдыг барьцаалан авч төлбөрөө барагдуулсан нөхцөлд буцаан олгоно.
- 4.10. Малчдын өвөлжөө, намаржааны ойролцоо байрлах үр тарианы бригад болон төмс хүнсний ногоо тариалж буй аж ахуйн нэгж, иргэд малчдын өвөлжөөг харж хамгаалах талаар гурвалсан гэрээнд тусган хэрэгжүүлж болно.
- 4.11. Таримал ургамлаа эрсдэлийн даатгалд хамруулна.
- 4.12. Гэрээгээр хүлээсэн үүргийнхээ дагуу буюу зайлшгүй тохиолдолд харилцан тохиролцсоны дагуу зарим талбайгаас сүрэл, технологийн хаягдлаа талбайн захад гаргаж өгч болно.
- 4.13. Сумын төвийн ойролцоо таримал ургамал тариалсан иргэд, аж ахуйн нэгж нь ургац хураалтын үед мал бүхий иргэдийн малыг нэгдсэн хариулгатай болгох ажилд тусалж малчны цалин урамшуулалд дэмжлэг үзүүлж болно.
- 4.14. Эрчимжсэн мал аж ахуйг дэмжих зорилгоор тариалангийн талбайн орчмын малчдын хүсэлт захиалгаар тариалангийн сэлгээндээ тэжээлийн ургамал тариална.

Тав. Малчин мал бүхий иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын үүрэг

- 5.1. Малчин, мал бүхий иргэд сум багаас гаргасан хуваарьт газарт хаваржиж, зусаж, намаржина.
- 5.2. Малчин, мал бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь таримал ургамал тариалсан, уриншилсан талбайд мал бэлчээхгүй, оруулахгүй байх үүрэг хүлээнэ.

- 5.3. Тариалангийн талбайн ойролцоо нутаглаж буй малчин, мал бүхий иргэд малаа ургац хураалт дуустал байнгын хариулгатай байлгах буюу алсын, отрын бэлчээрт гаргах арга хэмжээ авна.
- 5.4. Сум орон нутгаас зааж өгсөн бэлчээрт гараагүйгээр таримал ургамалд хохирол учруулсан нөхцөлд хохирлыг тухайн малчин, мал бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага 100 хувь хариуцна.
- 5.5. Таримал ургамал бүхий талбайн ойролцоо байгаа малчин, мал бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага бод малаа хаших хашаатай байж, шөнийн цагаар малаа хашиж байна.
- 5.6. Таримал ургамал хамгаалах журам зөрчигдөж байгааг мэдсэн иргэн сумын комисст нэн даруй мэдэгдэнэ.
- 5.7. Таримал ургамал тариалсан талбайд мал, тэжээвэр амьтан орсноос учирсан бодит хохирлыг сумын комиссын тогтоосон актыг үндэслэн энэ журамд заасны дагуу нөхөн төлнө.
- 5.8. Таримал ургамалд учруулсан хохирлоо 5 хоногийн дотор ямар нэгэн хэлбэрээр барагдуулна.
- 5.9. Хохирлын хэмжээ, хохирол төлөхтэй холбогдсон гомдлоо шүүхэд гаргаж болно.
- 5.10. Сумын заасан нутагт хаваржиж, зусаж, намаржиж байгаа малчин, мал бүхий иргэн, байгууллага, аж ахуйн нэгжийн мал нь таримал ургамал тариалсан талбайд өдрийн цагаар орвол хохирлыг малын эзэн, тариан талбайн эзэн 50/50 хувь, шөнийн цагаар орвол малын эзэн хохирлыг бүрэн хариуцна. Шөнийн цаг гэдгийг оройн 22.00 цагаас өглөөний 06.00 цаг гэж ойлгоно.
- 5.11. Малчин, мал бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага эрчимжсэн хагас эрчимжсэн мал аж ахуй хөгжүүлэх бодлого чиглэлийг түлхүү барьж өндөр ашиг шимтэй цөөн тооны малаар сүргийн бүтцээ бүрдүүлэхийг эрхэмлэнэ.
- 5.12. Сумын төвийн болон суурин газрын мал бүхий иргэд хамтран багийн Засаг даргын зохион байгуулснаар малаа байнгын хариулгатай болгож шөнийн цагаар хашиж байна.

Зургаа. Журам зөрчигчид хүлээлгэх хариуцлага

- 6.1. Газрын тухай хуулийн 52.2, 53.3, 54.3-т заасан заалтыг зөрчсөн бол энэ хуулийн 63.1.8-д заасны дагуу Байгаль орчны хяналтын улсын байцаагч нь учруулсан хохирлыг үндэслэн иргэнийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэгээс дөрөв дахин, байгууллага, аж ахуйн нэгжийг арваас хорь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож хохирлыг нөхөн төлүүлнэ.
- 6.2. Таримал ургамал тариалсан талбайд мал амьтан оруулж устгаж гэмтээсэн болон Захиргааны хариуцлагын тухай хуулийн 46 дугаар зүйлд заасан зөрчил гаргасан бол сум, багийн Засаг дарга энэ хуулийн 10.2, 12.5-ыг үндэслэн арга хэмжээ авна.
- 6.3. Өдрийн цагаар таримал ургамлын талбайд орсон малын учруулсан хохирлын 50 хувийг мал, тэжээвэр амьтны эзэн, 50 хувийг таримал ургамал эрхлэгч хариуцах ба шөнийн цагаар учруулсан хохирлыг 100 хувь малчин, мал бүхий иргэд, байгууллагаар төлүүлнэ.
- 6.4. Таримал ургамлын хөгжлийн үе шат /соёололт, бутлалт, гол хатгалт, түрүүлэлт, цэцэглэлт, үрийн бүрдэлт, цутгалт, сүүн болц, аарцан болц/ бүрийн хохирлыг үйлдвэр, санхүүгийн төлөвлөгөө буюу технологийн картад тусгагдсан ургацаар тооцно.
- 6.5. Таримал ургамал бүрэн боловсорч хураалтын үе явагдаж байгаа үед учруулсан хохирлыг биологийн ургацаар /ургац тогтоолтоор нэг га-гаас авахаар тогтоосон ургацаар/ тооцож барагдуулна.
- 6.6. Төв суурин газрын иргэн, аж ахуйн чэгж, байгууллага мал тэжээвэр амьтдаа нэгдсэн хариулгад хамруулаагүйгээс таримал ургамалд хохирол учруулсан бол хохирлыг тухайн мал, амьтны эзэн бүрэн хариуцаж төлнө.
- 6.7. Таримал ургамлыг хашиж хамгаалсан талбайн хашаа, байгууламжийн эвдэж устгасан этгээдээр түүнийг сэргээн босгоход гарах зардлыг 2 дахин нугалж төлүүлнэ.
- 6.8. Хохирол учруулсан этгээд хохирлыг санаатайгаар барагдуулаагүй бол хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг сум, багийн Засаг дарга, Байгаль орчны хяналтын улсын байцаагч, хохирогч нар шүүхэд гомдол гаргаж шийдвэрлүүлнэ.

оОо

Багийн Засаг дарга, Малчид, Тариаланчдын гурвалсан гэрээ

.... оны ... сарын ... өдөр

№ ...

Нэг дэх талаас: Таримал ургамал тариалагч иргэн /аж ахуйн нэгж/ –ийг төлөөлөн овогтой эцгийн нэр нэр РД:

Хоёрдагч талаас: Малчин /мал бүхий иргэн/ –ийг төлөөлөн овогтой эцгийн нэр нэр РД:

Гуравдагч талаас: аймгийн сумын багийн Засаг дарга –ийг төлөөлөн овогтой эцгийн нэр нэр РД:
 . нар харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Гэрээний зорилго

Таримал ургамал тариалагч иргэн, аж ахуйн нэгж, малчин, мал бүхий иргэдийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, малчид, тариаланчдын үүрэг хариуцлагыг тодорхой болгоход оршино.

Хоёр. Ерөнхий зүйл

- 2.1 Энэхүү гэрээг боловсруулахдаа Монгол Улсын холбогдох хуулийн заалтууд, аймгийн ИТХ-ын 2013 оны 25 дугаар тогтоолоор баталсан "Малчид тариаланчдын үйл ажиллагааны зохицлыг хангах журам"-ыг баримтлан гүйцэтгэнэ.
- 2.2 Газрын тухай хуулийн 54 3 1 заасны дагуу Тариалангийн талбайд өмчлөгч, эзэмшигч, ашиглагчийн албан ёсны зөвшөөрөлгүйгээр мал амьтан оруулах, бэлчээхийг хориглоно" гэсэн заалтыг биелүүлэхэд гурван талт гэрээний үйл ажиллагааг чиглүүлнэ
- 2.3. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн таримал ургамал тариалсан талбайгаа хашаажуулах, тэмдэгжүүлэх, харуул хамгаалалттай байлгах үүрэг хүлээнэ.
- 2.4. Малчин, мал бүхий иргэд, байгууллага, аж ахуйн нэгж нь өөрсдийн мал тэжээвэр амьтдыг байнгын хариулга, маллагаатай, хараа хяналттай байлгах үүрэг хүлээнэ.

Гурав. Багийн Засаг даргын эрх үүрэг

- 3.1. "Малчид тариаланчдын үйл ажиллагааны зохицлыг хангах журам"-ыг нийт тариаланч, малчин, мал бүхий иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад таниулах, сурталчлах ажлыг зохион байгуулна.
- 3.2. Сумын төв, суурин газрын малыг тариалалт эхлэхээс дуусах хүртэлх хугацаанд байнгын хариулага, маллагаатай байлгах талаар зохион байгуулалтын арга хэмжээг авна
- 3.3. Хаваржаа, намаржаа, өвөмжөө, зуспан болон сумын төв суурин газрын ойролцоо таримал ургамал тариалсан иргэн, аж ахуйн нэгж, тэнд нутаглаж буй малчид, мал бүхий иргэдтэй гурвалсан гэрээ байгуулах ажлыг зохион байгуулна.
- 3.4. Таримал ургамал тариалсан талбайд мал, тэжээвэр амьтан орсон тохиолдолд багийнхаа малчин, мал бүхий иргэдэд хурдан шуурхай мэдээллэнэ.

Дөрөв. Таримал ургамал тариалагчийн үүрэг

- 4.1. Тариалан эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь өмчөө хамгаалах зорилгоор тариалсан талбайнхаа ойролцоо нутагладаг малчин, мал бүхий иргэд, айл өрх, аж ахуйн нэгжтэй тарианд мал оруулахгүй байх, оруулсан нөхцөлд хохирлыг хэрхэн тооцох талаар тохиролцон гэрээ байгуулна
- 4.2. Таримал ургамал бүхий талбайд орж хохирол учруулсан мал тэжээвэр амьтны эзэн нь тогтоогдоогүй нөхцөлд мал амьтныг эориулалтын хашаанд хашиж энэ тухай сумын комисст мэдэгдэн эзэн нь тогтоогдсон үед хашиж малласан хугацаанд гарсан зардал учирсан хохирлыг нөхөн төлүүлнэ.
- 4 3. Таримал ургамал бүхий талбайд мал орж хохирол учруулсан бол малын тоо, зүс, ээмэг, тамга, малын мөр, ургамлыг сүйтгэсэн байдлыг фото зураг, видео камераар баталгаажуулан баримтжуулна

- 4.4. Тариалан эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага таримал ургамлаа мал, тэжээвэр амьтдаас хамгаалж хашаа барих, сахиул томилж өглөөний 05 цагаас оройн 22 хүртэл ажиллуулна.
- 4.5. Тариалсан талбайг тэмдэгжүүлж, 500 хүртэл га тутамд нэг манаач, сахиул байхаар тооцон унаа, холбооны хэрэгслээр хангаж ажиллана
- 4.6. Сумын төв, суурин газрын ойролцоо таримал ургамал тариалсан аж ахуйн нэгж, байгууллага, иргэд нь талбайгаа өөрийн хүч хөрөнгөөр хашаажуулна.
- 4.7. Таримал ургамал тариаланч, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага тариалсан талбайд орсон мал, тэжээвэр амьтдыг тусгайлан хашиж, ажлын хэсэг, багийн Засаг дарга нар болон эзэнд нь мэдэгдэж тоо толгой, аюулгүй байдлыг бүрэн хариуцна.
- 4.8. Таримал ургамалд мал, тэжээвэр амьтад хохирол учруулсан нөхцөлд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс тогтоосон жишиг үнэлгээнд үндэслэн учирсан хохиролд дүйцэхүйц мал, тэжээвэр амьтдыг барьцаалан авч төлбөрөө барагдуулсан нөхцөлд буцаан олгоно.
- 4.9. Хаваржаа, намаржаа, өвөлжөө, зуслан болон сумын төв суурин газрын ойролцоо таримал ургамал тариалсан иргэн, аж ахуйн нэгж, тэнд нутаглаж буй малчид, мал бүхий иргэдтэй гурвалсан гэрээ байгуулах ажилд оролцон харилцан үүрэг хүлээж, журмын хэрэгжилтийг ханган гэрээг байгуулан ажиллана.
- 4.10. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан журмыг хэрэгжүүлэн, гурвалсан гэрээгээ сайн биелүүлсэн мал, тэжээвэр амьтдаа таримал ургамал тариалсан талбайд оруулаагүй малчин, мал бүхий иргэнийг тодорхой нөхцөлөөр урамшуулна.

Тав. Малчин, мал бүхий иргэний хүлээх үүрэг

- 5.1. Малчин, мал бүхий иргэд нь сум, багаас заасан хуваарьт газар хаваржиж, зусаж, намаржина.
- 5.2. Малчин, мал бүхий иргэн, аж ахуй нэгж, байгууллага нь таримал ургамал тариалсан, уриншилсан талбайд мал бэлчээхгүй, оруулахгүй байх үүрэг хүлээнэ.
- 5.3. Тариалангийн талбайн ойролцоо нутаглаж буй малчин, мал бүхий иргэд малаа тариалалтын үед болон 08 дугаар сарын 25-наас 10 дугаар сарын 15 хүртэл өдрийн цагаар байнгын хариулага, маллагаатай байлгаж шөнийн цагаар хашина.
- 5.4. Сум орон нутгаас зааж өгсөн бэлчээрт гараагүйгээр таримал ургамалд хохирол учруулсан нөхцөлд хохирлыг тухайн малчин, мал бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага 100 хувь хариуцна.
- 5.5. Таримал ургамал бүхий талбайн ойролцоо байгаа малчин, мал бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага бод малаа хаших хашаатай байж. шөнийн цагаар малаа хашиж байна.
- 5.6. Таримал ургамал тариалсан талбайд мал, тэжээвэр амьтан орсноос учирсан бодит хохирлыг сумын комиссын тогтоосон актыг үндэслэн журамд заасны дагуу нөхөн төлнө.
- 5.7. Таримал ургамалд учруулсан хохирлоо 5 хоногийн дотор ямар нэгэн хэлбэрээр барагдуулна.
- 5.8. Хохирлын хэмжээ, хохирол төлөхтэй холбогдсон гомдлоо шүүхэд гаргаж болно.
- 5.9. Сумын заасан нутагт хаваржиж, зусаж, намаржиж байгаа малчин, мал бүхий иргэн, байгууллага, аж ахуйн нэгжийн мал нь таримал ургамал тариалсан талбайд өдрийн цагаар орвол хохирлыг малын эзэн, тариан талбайн эзэн 50/50 хувь, шөнийн цагаар орвол малын эзэн хохирлыг бүрэн хариуцна.
- 5.10. Сумын төвийн болон суурин газрын мал бүхий иргэд хамтран багийн Засаг даргын зохион байгуулснаар малаа байнгын хариулгатай болгож шөнийн цагаар хашиж байна.

Зургаа. Гэрээг зөрчигчид хүлээлгэх хариуцлага

- 6.1. Газрын тухай хуулийн 52.2, 53.3, 54 3-т заасан заалтыг зөрчсөн бол энэ хуулийн 63.1.8-д заасны дагуу Байгаль орчны хяналтын улсын байцаагч нь учруулсан хохирлыг үндэслэн иргэнийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэгээс дөрөв дахин, байгууллага, аж ахуйн

нэгжийг арваас хорь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож хохирлыг нөхөн төлүүлнэ.

- 6.2. Таримал ургамал тариалсан талбайд мал амьтан оруулж устгаж гэмтээсэн болон Захиргааны хариуцлагын тухай хуулийн 46 дугаар зүйлд заасан зөрчил / Бэлтгэсэн хадлан тариалангийн талбайд мал тэжээвэр амьтан оруулан гишгүүлэх, идүүлэх зэргээр таримал ургамал, жимс жимсгэний болон бусад суулгац, тарьц устгасан гэмтээсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол учруулсан хохирлыг шүүхийн журмаар нөхөн төлүүлж 500-25000 төгрөгөөр торгох/ гаргасан бол сум, багийн Засаг дарга энэ хуулийн 10.2.12.5-ыг үндэслэн арга хэмжээ авна.
- 6.3. Өдрийн цагаар таримал ургамлын талбайд орсон малын учруулсан хохирлын 50 хувийг мал, тэжээвэр амьтны эзэн, 50 хувийг таримал ургамал эрхлэгч хариуцах ба шөнийн цагаар учруулсан хохирлыг 100 хувь малчин, мал бүхий иргэд байгууллагаар төлүүлнэ.
- 6.4. Таримал ургамлын хөгжлийн үе шат / соёлолт, бутлалт, гол хатгалт, түрүүлэлт, цэцэглэлт, үрийн бүрдэлт, цутгалт, сүүн болц, аарцан болц / бүрийн хохирлыг үйлдвэр, санхүүгийн төлөвлөгөө буюу технологийн картад тусгагдсан ургацаар тооцно.
- 6.5. Таримал ургамал бүрэн боловсорч хураалтын үе явагдаж байгаа үед учруулсан хохирлыг биологийн ургацаар /ургац тогтоолтоор нэг га-гаас авахаар тогтоосон ургацаар/ тооцож барагдуулна.
- 6.6. Төв суурин газрын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага мал тэжээвэр амьтдаа нэгдсэн хариулгад хамруулаагүйгээс таримал ургамалд хохирол учруулсан бол хохирлыг тухайн мал, амьтны эзэн бүрэн хариуцаж төлнө.
- 6.7. Таримал ургамлыгт хашиж хамгаалсан талбайн хашаа, байгууламжийн эвдэж устгасан этгээдээр түүнийг сэргээн босгоход гарах зардлыг 2 дахин нугалж төлүүлнэ
- 6.8. Сумын ажлын хэсгийн тогтоосон хохирлын актыг талууд эс зөвшөөрвөл гомдолоо шүүхэд гаргана.
- 6.9. Хохирол учруулсан этгээд хохирлыг санаатайгаар барагдуулаагүй бол хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг сум, багийн Засаг дарга, Байгаль орчны хяналтын улсын байцаагч, хохирогч нар шүүхэд гомдол гаргаж шийдвэрлүүлнэ.

Гэрээ байгуулсан

Ургамал тариалагчийг төлөөлж:

Багийн Засаг дарга:

Малчиныг төлөөлж:

Хаяг:

Утас:

Гарын үсэг:

Кейс 5. Дархан цаазат Богдхан уулын тусгай хамгаалалттай газрын хил заагийн тухай

Богд хан уулаа бидний өвөг дээдэс эртнээс дархлан хамгаалж, XII-XIII үед Монголын Хэрэйд аймгийн Ван хаан тахиж Хан уул хэмээн нэрлэсэн бөгөөд 1778 онд дархалсан хэмээдэг. 1954 оны УИХ-ын Тэргүүлэгчдийн 31-р тогтоолоор Чойбалсан уул нэрээр, 1974 оны АИХ-ын Тэргүүлэгчдийн 248-р зарлигаар дархан цаазат газар болгожээ. УИХ-ын 1995 оны 26-р тогтоолоор "Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай" хуулийн дагуу дархан цаазат газрын (ДЦГ) ангиллаар баталгаажуулсан байна.



Манай орны төдийгүй дэлхийн ууган дархан газар болохыг бататгаж, 1997 онд "Дэлхийн шим мандлын нөөц газрын сүлжээ"-нд хамрагдсан байна. Богд хан уул нь Хэнтийн нурууны өмнөд хэсэг, ойт хээрийн бүсийн зааг, шинэсэн ойн өмнөд хязгаар бөгөөд нийслэл орчмын нутгийн таатай уур амьсгалыг бүрдүүлэхэд онцгой нөлөө үзүүлдэг.

Дархан цаазат уулын хамгийн өндөр оргил нь далайн түвшинээс 2268.0 өндөрт өргөгдсөн Цэцээ гүн юм. Богдхан ууланд эмчилгээний ач холбогдолтой хэд хэдэн рашаан булгууд бий. Зарим газар хушин ой, хойд ба зүүн өмнөд хэсгээр нь шинэсэн ой зонхилон тархдаг нь тус уулын хэсэг бүрт экологийн нөхцөл өөр байдгийг гэрчилнэ. Богдхан уулан 70 овгийн 256 төрлийн 588 зүйл дээд ургамал ургадаг. Ургамалын аймаг нь экологийн 18 бүлэгт хамаарах бөгөөд эдгээрээс уулын тайгын экологийн бүлгүүд 80 хувийг, хээрийн ургамлууд 72 хувийг эзэлдэг. Хэнтийн тайгын голлох элемент болон олон зүйлийн хөхтөн амьтны тархалтын урд хил Богдхан уул болно. Богдхан ууланд монгол орны хөхтөн амьтны 35 хувь буюу 6 баг, 17 овог, 36 төрөл 54 зүйлд хамаарах хөхтөн амьтан нутагладаг. 174 овог, 270 гаруй төрөлд хамаарах 1660 зүйл шавж. 259 зүйлийн мезофаун, 93 микрофаун. 14 баг, 36 овогт багтах 194 зүйл шувуу бүртгэгдсэн.

УБ хотын Ардын Депутатуудын хурлын гүйцэтгэх захиргааны 1988 оны 63/98 тоот захирамжаар байгуулагдсан. 61.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй, 35 ажиллагсадтай, 41651 га талбайд хамгаалалтын үйл ажиллагаа явуулдаг. Улаанбаатар хотод ШУА-ийн Геоэкологийн хүрээлэнгийн байранд байрладаг.

Түүхийн сурвалжаас авч үзвэл 1809 онд Богдхан уулын 28 амыг цагдаатай болгож нутаг дэвсгэрт орох зөвшөөрлийг Богд хаан гардан олгодог журам тогтоож байсан байна.

Нэг. УИХ-ын гишүүн Ц.Оюунгэрэл, Л.Болд нарын санаачлан боловсруулсан “Зарим нутаг дэвсгэрийг тусгай хамгаалалттай газрын хилийн заагаас чөлөөлж, өөрчлөлт оруулах тухай” УИХ-ын тогтоолын төсөлд заагдсан ХУД-ын 11-р хорооны Зайсан, Богины ам, ХУД-ын 4-р хорооны Арцат, Нүхтийн амны өгөгдсөн хэмжээсийг (координат) нарийвчлан зурагт буулгаж тулгахад дараах байдалтай байна. Үүнд:

- А. Дээрх нутаг дэвсгэрт баригдсан барилга байгууламжийг “цонх” үүсгэх байдлаар чөлөөлүүлэх;
- В. Дээрх нутаг дэвсгэрийг бүхэл “амаар” нь чөлөөлүүлэх 2 хувилбарыг ирүүлсэн байна.

Тусгай хамгаалалттай нутаг дэвсгэрийн хилийн цэсийг өөрчлөх саналыг энэхүү аль ч хувилбараар шийдэхийн өмнө дараах асуудлуудыг цогцоор нь БХБЯ, БОНХЯ, ГХГЗЗГ, Нийслэлийн болон Эрдэм шинжилгээний байгууллага, Тусгай хамгаалалтын газар зэрэг хамтран шийдвэрлэх зайлшгүй хэрэгцээ үүсэж байна.

Хоёр. Тусгай хамгаалалттай нутаг дэвсгэрийн ашиглалт, хилийн цэсийн асуудлын хүрээнд шийдвэрлэх тулгамдсан асуудлууд.

1. **Хилийн цэсийг нэгдсэн аргачлалаар шинэчлэн тогтоох тухай.** УИХ-ын 1996 оны 26 дугаар тогтоолоор батлагдсан Богдхан уулын хилийн тэмдэглэгээг БОНХЯ, НӨХГ тус бүр зөрүүтэй хийсэн байна. Жишээлбэл:
 - a. ХУД-ын Шинэ яармаг хороолол, Буянт-Ухаа хорооллын төлөвлөлтийн бүсийг үзвэл БОНХЯ-ны тогтоосон хил заагт багтаж, харин НӨХГ-ын тогтоосон хилийн бүсэд ороогүй байна. Энэхүү зөрүүтэй байдлаас НБХБТГ-ын /хуучин нэрээр/ боловсруулсан төлөвлөгөөг БХБЯ-ны батлах ажил хүлээгдэж байна. Гэтэл бодит байдалд тус бүсэд барилга байгууламж барьж эхэлсэн байна.
 - b. БОНХЯ-ны тогтоосон хилийн урт 88.2 км, талбай 42192.4 га, НӨХГ-аас тогтоосон хилийн урт 83.7 км, талбай 41122.3 га байгаа бөгөөд 4.2 км урт, 1070.1 га талбайгаар зөрүүтэй байна. Богдхан уулын ДЦГ-ын хамгаалалтын захиргааны 41651 га талбайтай харьцуулбал БОНХЯ-наас 541.4 га-аар дутуу, НӨХГ-аас 528,7 га-аар илүү байна.
 - c. Сансрын зурагтай харьцуулахад ч хамгийн бага зөрүүтэй хэсэг буюу Яармагийн “Viva city” хорооллын урд талд 150 метр зурвас газарт туршилтын хэмжилт хийхэд 0.48 га (4866.464м²) талбайн зөрүүтэй байна.
2. **Хот төлөвлөлтийг хэрэгжүүлэх тухай.** Тусгай хамгааллын нутаг дэвсгэрт хуулийн заалтын дагуу Зайсан, Богины ам, Арцат, Нүхт, Шинэ яармагийн хот төлөвлөлт БХБЯ, НӨХГ-ын аль ч төвшинд батлагдахгүй шийдэл хүлээгдэж байна. Гэтэл БОНХЯ-ны зөвшөөрлөөр эдгээр нутаг дэвсгэрт хэд хэдэн хороолол баригдсан нь “хуулийн гадуурхи хот” буюу “силос” үзэгдэл үүссэн байна. Эдгээр суурьшил, барилга байгууламжууд нь дархан цаазат газрын хязгаарлалтын бүсээс хэтэрч хамгаалалтын бүст зарим хэсэг газар нэвтэрсэн байна. Энэ нь Монгол Улсын Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 9.1, 9.2-ийг зөрчихөд хүрээд байна.
3. **Газар ашиглалтыг хэрэгжүүлэх тухай.** Монгол Улсын Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн дагуу газар ашиглуулах зохицуулалттай бөгөөд дээрх нутаг дэвсгэрт дунджаар 50-75 жилийн насжилт бүхий барилга байгууламж бариулсан нь газар эзэмшлийн хэлбэр болж байна. Ийнхүү хууль зөрчсөн үйлдлээс хариуцлага хэлэлцэх, эсвэл холбогдох хуулиудад өөрчлөлт оруулах асуудал хөндөгдөж байна.
4. **Газрын ашиглалтын стандартыг хэрэгжүүлэх тухай.** Газрын ашиглалтын стандарт, нормитив, ялангуяа Тусгай хамгаалалттай нутаг дэвсгэрийн ашиглалтын стандартыг нэн тэргүүн сайжруулан боловсруулан, батлуулж хэрэгжүүлэх шаардлага үүсэж байна.
5. **Засаг захиргаа нутаг дэвсгэрийн хуваарийг тодруулах тухай.** Богд хан уулын тусгай хамгаалалттай газрын хил дотор орших Манзушир хийд орчмын нутаг дэвсгэр Баянзүрх дүүрэг, Бөхөгийн ам, Ахмадын сувилал орчмын нутаг дэвсгэр Хан уул дүүрэгт тус тус байгааг анхаарч Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт шилжүүлэх асуудал шийдэл хүлээж байна.
6. **Байгаль орчины болон газрын суурь судалгаа мониторингийг хэрэгжүүлэх тухай.** Тус нутгийн “байгалийн бүс, бүслүүрийн онцлог, өвөрмөц тогтоц, ховор, ховордсон ургамал, амьтан бүхий газар, түүх, соёлын дурсгалт болон үзэсгэлэнт газрын хэв шинжийг хадгалах, хувьсаж өөрчлөгдөх зүй тогтлыг судлах”, хүний санаатай санамсаргүй үйлдлээр эвдрэл өөрчлөлт орж, ан амьтан, хөрс, ургамлын

тогтоц эрс өөрчлөгдсөнийг мэргэжлийн байгууллагууд 2005 он хүртэл судалсан дүнг сөрөг үзүүлэлт ихтэй байгааг дүгнэсэн байна. Иймд эдгээр судалгааны дүнг нэгтгэх, газрын мониторингийг ойрын жилд хийх хэрэгцээ үүсэж байна.

7. **Хил заагт өөрчлөх асуудлыг мэргэжлийн байгууллагын хамтран шийдвэрлэх тухай.** УИХ-ын 2012 оны 38 дугаар тогтоолоор БЗД-ийн 11 хорооны Туул зөрлөгт 33,5 га газрыг улсын тусгай хамгаалалтаас гаргасан байна. Энэ мэт хот төлөвлөлтөөр батлаагүй газар нутагт барилга байгууламж баригдсаны дараа нь хилийн цэсийг өөрчлөх аргыг хэрэгжүүлээд байх нь тусгай хамгаалалтад авсан утга агуулга алдагдаж, хуулийг хэрэгжүүлэхэд бэрхшээлтэй болно. Иймд холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран шийдвэрийн хувилбар боловсруулж УИХ-д өргөн мэдүүлж байх саналыг дэвшүүлж байна.

Гурав. БХБЯ-ны сайдын өгөгдсөн үүргийн дагуу БЗД-ийн гэр хороолол, V станц барихаар төлөвлөсөн газар, цанын бааз зэргийг судалж үзэхэд:

1. БЗД-ийн 11-р хороо, Туул зөрлөгийн орчмын газрыг 2012 онд “улсын тусгай хамгаалалттай газраас чөлөөлж” суурин үүсгэсэн байна.
2. V станц барихаар төлөвлөсөн газар нь тусгай хамгаалалтын бүсэд хамрагдаагүй байна.
3. Цанын баазыг аялал жуулчлалын зориулалтаар олгосон байна.

Хэлэлцүүлэг – дүрд орж ажиллах

1. Дүр буюу оролцогч талууд: Байгаль орчны яам, Тусгай хамгаалалтын захиргаа, Нийслэлийн Газрын алба, Дүүргийн газрын алба, компани, иргэн, иргэдийн төлөөлөгч (УИХ-ийн гишүүн)
2. Оролцогч тус бүр өөрийн эрх ашигт нийцсэн хуулийг баримталж, хоорондоо мэтгэлцэнэ үү.
3. Манай улсын хуулиудыг хэрэглэх боломж юу байна вэ?
4. Энд хохирогч нь хэн бэ? Яагаад “хохирогч”-гүй байна вэ?
5. “Цонх” гаргах байдлаар шийдэх нь ямар үр дүн, үр дагавартай вэ?

Кейс 6. Орон нутгийн тусгай хамгаалалтад авахад гарсан алдаа, сургамж



А аймгийн Б сумын I багийн иргэдийн саналыг тусгаж, сумын ИТХ, аймгийн ИТХ-аар 319158 га газрыг “Орон нутгийн тусгай хамгаалалтад авах” шийдвэр гаргасан нь 3 шатны шүүхэд хэлэлцээд хүчингүй болов.

Үйл явдлын дараалал, тодотгол

- 1) А аймгийн Б сумын I багийн иргэдийн саналыг тусгаж, сумын ИТХ-ын 2012 оны 25 тогтоолоор ... нутгийг “Орон нутгийн тусгай хамгаалалтад авах” тогтоол гаргаж, аймгийн ИТХ-д уламжлав.
- 2) А аймгийн ИТХ 2012.11.26-ны 1/5 дугаартай “Зарим газар нутгийг орон нутгийн тусгай хамгаалалтад авах” тухай тогтоол гаргав.
 - а. Байгалийн унаган төрх, хэв шинжийг хадгалах зорилго бүхий байгалийн иж бүрдэл нөөц газраар орон нутгийн тусгай хамгаалалтад авахаар шийдвэрлэжээ.

- b. Энэхүү нутгийн хил хязгаар дотор Х компанийн тогтоосон ашигт малтмалын талбай (Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг 2007 оноос эзэмшин, хайгуул хийж, 2011 онд тогтоосон нөөцийг бүртгүүлж, ашиглалтын өмнөх гэрээг 3 жилээр байгуулсан), Y компанийн хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайн (тусгай зөвшөөрлийн хугацаа 2041 онд дуусах) зарим хэсэг орсон байна.
- 3) Захиргааны хэргийн шүүхэд Х компани “Аймгийн ИТХ-ын 2012.11.26-ны өдрийн А/5 дугаар тогтоолын 1 дэх заалтыг хүчингүй болгож өгнө үү” гэсэн нэхэмжлэл гаргасан
- a. А/5 дугаар тогтоолын үндэслэх хэсэгт Аймгийн ЗД-аас тогтоолд дурдагдсан 319158 га газрыг орон нутгийн тусгай хамгаалалтад авах санал гаргасан эсэхийг дурдаагүй байгаа нь ЗЗНДНТУ-ын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 “к” заалтыг зөрчсөн байна.
- b. Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д газрыг тусгай хэрэгцээнд авах тухай асуудлыг газар эзэмшигч болон тухайн шатны Засаг даргатай тохиролцсоны дагуу ИТХ-д өргөн мэдүүлэхээр заасан байна. ИТХ тогтоол гаргахын өмнө тус компанитай уулзаж, тодорхой шийдэлд хүрсэн байх хуулийн заалтыг үл анхаарсан байна.
- c. Ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.23, 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалтуудыг тус тус зөрчсөн гэж нэхэмжилжээ.
- 4) Захиргааны хэргийн шүүхэд Y компани “Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2012.07.02-ны өдрийн хүчингүй болсон тогтоолыг 2012.11.26-ны тогтоол хуулбарлан давтсан” гэж нэхэмжлэл гаргасан
- a. Байгалийн иж бүрдлийн нөөц газраар орон нутгийн тусгай хамгаалалтад авах зайлшгүй шаардлагатай гэдгийг баталгаажуулсан судалгаа, шинжилгээ хийхгүйгээр зохих мэргэжлийн байгууллагын дүгнэлт байхгүйгээр шийдвэр гаргаж тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хууль ёсны эрхийг хөндсөн.
- b. Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4-ийг тус тус зөрчсөн.
- c. Газрыг тусгай хэрэгцээнд авах тухай саналыг тухайн шатны Засаг дарга боловсруулж, газар эзэмшигчтэй харилцан тохиролцоод саналаа ИТХ-д өргөн мэдүүлэхээр заасан Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.5, 20.2.5-г зөрчсөн гэж нэхэмжилжээ.
- 5) А аймгийн Захиргааны хэргийн шүүхийн 2012.12.26-ны хуралдааны .. дугаар шийдвэрээр “Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3, 20.1.4, 20.2.5 дахь хэсэгт заасныг баримтлан нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж, А аймгийн ИТХ-ын 2012.11.26-ны өдрийн 1/5 дугаар тогтоолын 1 дэх заалтыг хууль бус” гэж тооцон хүчингүй болгожээ.
- 6) Хариуцагч буюу Аймгийн ИТХ-ын гомдол, тайлбартаа
- a. Б сумын I багийн нутаг, Н сумын нутаг дэвсгэрийн 319158 га газрыг орон нутгийн тусгай хамгаалалтад авахдаа ямар нэгэн хууль зөрчөөгүй бөгөөд Газрын тухай хуульд заасан үндэслэл журмыг баримталсан.
- b. Тус газрыг орон нутгийн тусгай хамгаалалтад авах асуудлыг Аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтсээс ИТХ-д 2012 онд хэлэлцүүлж, тогтоол гарсан. ЗЗНДНТУ-ын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэгт “Засаг даргын

алба нь Тамгын газар байна... гэж заасан. Засаг даргын бодлого шийдвэрийг хэрэгжүүлдэг Тамгын газрын Хөгжлийн бодлогын хэлтсээс уг асуудлыг хуралдаанд оруулж шийдвэрлүүлсэн нь Засаг дарга оруулаагүй гэх үндэслэл болохгүй”

- c. Энэхүү газрыг орон нутгийн тусгай хамгаалалтад авах асуудлыг 2013 оны Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгасан бөгөөд 4 дүгээр сарын 25-нд хуралдах аймгийн ИТХ-аар хэлэлцэнэ.
 - d. Орон нутгийн сонгууль оройтож болсонтой холбогдуулан аймгийн ИТХ-аар хэлэлцэн батлах асуудлууд тодорхой нөхцөл байдлын улмаас хойшлогдож, Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө батлагдаагүй байгаа учраас хэрэгт нотлох баримтаар гаргаж өгөх боломжгүй байна.
- 7) Захиргааны хэргийн давж заалдах шүүхийн 2013.02.28-ны хуралдааны .. дугаар магадлалаар “ИТХ 2012.11.26-ны 1/5 дугаартай тогтоолын 1 дэх заалтын нэхэмжлэгч нарын эзэмшиж буй,... дугаартай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл бүхий талбайд хамаарах хэсгийг хүчингүй болгон өөрчилж, шийдвэрийн тогтоох хэсгийн бусад заалтыг хэвээр үлдээв.
- a. Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2.”з”,
 - b. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2,
 - c. Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3, 25 дугаар зүйлийн 25.1.5,
 - d. Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Газар зохион байгуулалт хийх журам”-ын 9, 11 дэх хэсэгт заасныг тус тус зөрчсөн
 - e. Нэр бүхий газрыг орон нутгийн тусгай хамгаалалтад авах асуудлыг тусгасан аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө нь аймгийн ИТХ маргаан бүхий захиргааны актыг хэлэлцэж батлахаас өмнө батлагдаж хүчин төгөлдөр болоогүй байх тул уг актын хувьд эрх зүйн үндэслэл болж чадахгүй
 - f. Аймгийн Засаг дарга санал боловсруулж оруулаагүй, ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтэс уг асуудлыг хуралдаанд оруулж шийдвэрлүүлсэн нь уг захиргааны актыг гаргах талаар тусгайлан заасан журам зөрчсөн байна гэдэг үндэслэлээр хариуцагчийн давж заалдах гомдлыг хангахгүй байна гэж шийдвэрлэсэн байна.
 - g. Ашигт малтмалын тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг орон нутгийн тусгай хэрэгцээнд авах асуудал нь хуулиар хориглогдоогүй, цаашид энэ талаар шийдвэр гаргах А аймгийн ИТХ-ын эрх шүүхийн энэ шийдвэр болон бусад эрх зүйн актаар хязгаарлагдаагүй тул холбогдох хууль тогтоомжид заасан журмын дагуу асуудлаа шийдвэрлэх боломжтой болно.

Хэлэлцүүлэг

- 1) Сумын ИТХ-ын шийдвэрийн ололт, алдаа юу байв?
- 2) Аймгийн ИТХ-ын шийдвэрийн ололт, алдаа юу байв?
- 3) Аймгийг Засаг дарга, ЗДТГ-ын хэлтэст төлөөлүүлэн гүйцэтгүүлэх буюу эрх шилжүүлэх үү?
- 4) Х компани, Y компанийн давуу тал юу байна вэ?
- 5) Танай суманд газар нутгийг орон нутгийн тусгай хэрэгцээнд авах асуудал үүсдэг үү? Хэрхэн шийдэж байна вэ?

- б) Ашигт малтмалын тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг орон нутгийн тусгай хэрэгцээнд авахад үүсдэг бэрхшээлүүд юу байна вэ? Энэ талаарх хуулийн зохицуулалтыг тодорхой ярилцана уу?

Дасгал 1: Мал аж ахуй: бэлчээр, усалгаа, өвөлжөө, хаваржаа, намаржаа, зуслангийн хуваарийг хийж буй арга ажиллагаа, туршлага

Кейс 7. Бэлчээрийн менежмент - иргэдийн оролцоо

Булган аймгийн Хишиг-Өндөр сумын “Бэлчээрийн менежментийг иргэдийн оролцоотой шийдвэрлэх нь” (Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг дэмжих тэтгэлэг 2016, 172-174) төслийн хэрэгжилт, үр дүн, үр дагаврыг хэлэлцэж, өөрийн аймаг, сумандаа хэрэгжүүлэх төсөл, журмыг боловсруулна уу. /Шийдвэр, журам, үйл ажиллагааны фото зураг, сурвалжилга/

Кейс 8. Нөөц бэлчээр ашиглалт

Дорнод аймгийн Халх гол сумын “Нөөц бэлчээр ашиглалтын нийтлэг журам” түүний хэрэгжилт, (Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлуудын сайн туршлагын эмхтгэл 2016, 64), үр дүн, үр дагаврыг хэлэлцэж, өөрийн аймаг, сумандаа хэрэгжүүлэх төсөл, журмыг боловсруулна уу. /Журам, үйл ажиллагааны фото зураг, сурвалжилга/

Кейс 9. Өвөлжөө, хаваржааны нутаг хуваарилсан

Багийн ИНХ-аар өвөлжөө, хаваржааны нутаг хуваарилсан туршлага

Дасгал 2: Газар тариалан: хөрсний элэгдэл, хамгаалал, сэлгэлт, химийн бордооны хэрэглээ, эерэг болон сөрөг нөлөөлөл, туршлага

Кейс 10. Нишингэ, рапс тариалахыг дэмжсэн шийдвэр /ИТХ-ын тогтоол, Засаг даргын захирамж, тариалсан талбай, ургац, хөрс газарт үүссэн өөрчлөлт/

Кейс 11. Нишингэ, рапс тариалахыг хориглосон шийдвэр /ИТХ-ын тогтоол, Засаг даргын захирамж, тариалсан талбай, ургац, хөрс газарт үүссэн өөрчлөлт/

Кейс 12. Химийн бордооны хилээр орох хяналт, хэрэглээ, бордоог хэрэглэх стандарт, бороо хэрэглэсэн үеийн ургац, бордоог хэтрүүлэн хэрэглэсэн үеийн ургац зэргийг баримтжуулж, хэлэлцэх

Дасгал 3: Хот байгуулалт: хот суурингийн төлөвлөлт, хог хаягдлын асуудлыг шийдэж буй туршлага, арга ажиллагаа, үр дүн

Кейс 13. Малтай өрхийн талаар баримтлах бодлого

Дорнод аймгийн Хэрлэн сумын “Чойбалсан хотод малтай өрхийн талаар баримтлах бодлогыг иргэдийн оролцоотой шийдвэрлэх нь” (Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг дэмжих тэтгэлэг 2016, 156-162) төслийн хэрэгжилт, үр дүн, үр дагаврыг хэлэлцэж, өөрийн аймаг, сумандаа хэрэгжүүлэх төсөл, журмыг боловсруулна уу. Сүхбаатар аймгийн Баруун урт хотоос туршлагаас суралцсан. /Тогтоол, журам, үйл ажиллагааны фото зураг, сурвалжилга/

Кейс 14. Ногоон байгууламжийн ашиглалт, хамгаалалт

“Ногоон байгууламжийн ашиглалт, хамгаалалт түүнийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах журмын төсөл” (Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлах зарим журам, дүрмийн төслүүд 2016, 50-60) жишиг загварыг хэлэлцэж, өөрийн аймаг, сумынхаа онцлогтой уялдуулж журам боловсруулна уу.

Кейс 15. Хог тээвэрлэлт, ангилах, устгах үйл ажиллагаа

Өмнөговь аймгийн Даланзадгад сумын /хот/ “Хог тээвэрлэлт, ангилах, устгах үйл ажиллагааны тухай” /агуулга/ журам, түүний хэрэгжилт, үр дүн, үр дагаврыг хэлэлцэж, өөрийн аймаг, сумандаа хэрэгжүүлэх төсөл, журмыг боловсруулна уу. / Журам, үйл ажиллагааны фото зураг, сурвалжилга/

Кейс 16. Хог хаягдлын цэгийн менежмент - иргэдийн оролцоо

Говьсүмбэр аймгийн Шивээ говь сумын “Хог хаягдлын цэгийн менежментийг иргэдийн оролцоотой шийдвэрлэх нь” (Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг дэмжих тэтгэлэг 2016, 29-35) төслийн хэрэгжилт, үр дүн, үр дагаврыг хэлэлцэж, өөрийн аймаг, сумандаа хэрэгжүүлэх төсөл, журмыг боловсруулна уу. / Журам, үйл ажиллагааны фото зураг, сурвалжилга/

Дасгал 4: Тусгай хамгаалалт, ойжуулалт, түймэр, нөхөн сэргээлтийн ажил, туршлага

Иргэний яриа. Говь нутгийн цаг уурын хуурай, байгаль орчин эмзэг тогтоцтой байдаг. Аймгийн нутаг дэвсгэрийн 40 шахам хувь нь ашигт малтмалын лицензтэй, уул уурхайн замбараагүй үйл ажиллагааны нөлөөллөөс экологийн тэнцвэрт харьцаа алдагдаж хуурайших, цөлжих явц улам эрчимжиж байна. Энэ нь иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх зөрчигдөж, дахин давтагдашгүй байгалийн үзэсгэлэнт газрууд болон усны нөөц газруудын ай савыг хамгаалалтад авах бодлого хэрэгжүүлж, говь нутгийнхаа унаган төрхийг авч үлдэх хэрэгтэй байна.

Кейс 17. Ойн хамгаалалт, ашиглалт, цэвэрлэгээ, нөхөн сэргээлт

Төв аймгийн Жаргалант сумын Ойн хамгаалалт, ашиглалт, цэвэрлэгээ, нөхөн сэргээлтийн нөхөрлөлийн үйл ажиллагаа, журам, түүний хэрэгжилт, үр дүн, үр дагаврыг хэлэлцэж, өөрийн аймаг, сумандаа хэрэгжүүлэх төсөл, журмыг боловсруулна уу.

Кейс 18. Ойн сан бүхий газраас цэвэрлэгээний журмаар мод ашиглуулах

Ойн сан бүхий газраас цэвэрлэгээний журмаар мод ашиглуулах зөвшөөрөл олгох хүсэлтийг сумын ИТХ-д иргэдээс ирүүлжээ. Гэтэл байгаль хамгаалах ТББ-аас ойгоос цэвэрлэгээний журмаар түлшний мод ашиглуулахгүй байхыг хүссэн байна. ИТХ аль талыг дэмжвэл дээр вэ?

Шийдвэрлэх арга зам: Ойн сан бүхий газраас хэрэглээний журмаар мод авч ашиглах зөвшөөрлийг иргэн хүнд олгох хуулийн заалт байхгүй. Харин тодорхой зохион байгуулалтад орж иргэдийн бүлэг, нөхөрлөл байгуулсан тохиолдолд “Ойн тухай” хуулийн 21.8-д заасан үндэслэлийг баримтлан байгаль хамгаалах бүлэг, нөхөрлөлийн саналыг харгалзан ИТХ шийдвэрээ гаргах нь зөв юм.

Кейс 19. Тусгай хамаалалтад авах

Сумын ИТХ-аас ойн сан бүхий 19 га газрыг сумын тусгай хэрэгцээнд авсан шийдвэр гаргаад байтал аймгийн ИТХ-аас дээрх газар орчмын 45 га газрыг аймгийн тусгай хамгаалалтад авсан байна. Сумын иргэдэд аль шийдвэр нь хүчинтэй вэ?

Шийдвэрлэх арга зам: Аймаг, сумын ИТХ-ууд аль аль нь ойн сан бүхий газрыг тусгай хамгаалалт, хэрэгцээнд авах эрхтэй. Иймд аймаг, сумын ИТХ-ын аль алиных нь шийдвэрийг хүчинтэйд тооцно. Харин тусгай хэрэгцээ, хамгаалалтаас гаргах тохиолдолд аль алинаас нь зөвшөөрөл авч байж ойн сан бүхий газрыг эзэмших эрх үүснэ.

Кейс 20. Орон нутгийн тусгай хамгаалалтад авах

Аймгийн ИТХ-ын ээлжит Хуралдаанаар “А” сумын Бугат орчмын 2199 га газрыг хотын ус чийгийн балансад эрс өөрчлөлт оруулах онцгой нөлөөтэй, экологийн хувьд туйлын эмзэг ой мод, ургамал, усны горим, байгалийн унаган төрхийг алдагдуулахгүй байлгах зорилгоор “Бугат” нэрээр газрыг 25 жилийн хугацаатайгаар хилийн цэсийг тэмдэгжүүлж орон нутгийн тусгай хамгаалалтад авч байгаль орчныг хамгаалах талаар хууль тогтоомжоор олгогдсон эрх үүргээ хэрэгжүүлжээ.

Дасгал 5: Уул уурхай: хайгуул, олборлолт, нөхөн сэргээлтийн ажил, үр дүн

Кейс 21. Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул, ашиглалт

Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгоход санал өгөх журмын төсөл (Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлах зарим журам, дүрмийн төслүүд 2016, 45-49) жишиг загварыг хэлэлцэж, өөрийн аймаг, сумынхаа онцлогтой уялдуулж журам боловсруулна уу.

Кейс 22. Уул уурхай ашиглалт, нөхөн сэргээлт

Төв аймгийн Заамар суманд уул уурхай ашиглалт (Алтны уурхай), нөхөн сэргээлт хийж буй компаниудын үйл ажиллагаа, орон нутгийн хөгжилд хамтран ажиллаж буй “Нийгмийн хариуцлагын гэрээ”-ний (Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлуудын сайн туршлагын эмхтгэл 2016, 104-106) хэрэгжилт, үр дүн, үр дагаврыг хэлэлцэж, өөрийн аймаг, сумандаа хэрэгжүүлэх төсөл, журмыг боловсруулна уу.

Кейс 23. Уул уурхайн нөхөн сэргээлт хийх

2014 онд аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн Хурлаар Увс аймагт “Хөндөгдсөн газарт нөхөн сэргээлт хийх аж ахуйн нэгж, нөхөрлөлийг сонгон шалгаруулж, үйл ажиллагаанд нь хяналт тавих” журмыг хэлэлцэн баталсан. Журмын зорилго нь: Уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанаас эвдэгдэн орхигдсон болон хувиараа ашигт малтмал олборлогчдын хууль бусаар хөндсөн талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх мэргэжлийн байгууллага, иргэдийн нөхөрлөлийг сонгон шалгаруулах, нөхөн сэргээлт хийх үйл ажиллагаанд нь хяналт тавих, нөхөн сэргээсэн талбайг актаар хүлээн авах гол зорилготой юм.

Кейс 24. Түгээмэл тархацтай ашигт малтмал

Сумын ИТХ нь тухайн нутаг дэвсгэр дээрээ элс, хайрга дайрганы хүсэлт ирүүлсэн аж ахуй нэгжүүдийн үйл ажиллагаа явуулах хүсэлтийг хүлээн авах боломжгүй гэж үзэн

тогтоол гаргажээ. Уг тогтоолыг эсэргүүцэн аж ахуй нэгжүүд нийлж захиргааны хэргийн шүүхэд гомдол гаргажээ. Тухайн ИТХ нь эрх зүйн хувьд албан ёсны нэхэмжлэгч мөн эсэх, тусгай зөвшөөрлийг хууль зүйн хувьд хэрхэн шийдвэрлэх талаар санал солилцох.

Нэмэлт дасгал

Дасгал 1. Байгалийн нөхөн сэргэх нөөцийн ашиглалт

- 1) Бэлчээрийн мал аж ахуйд бодлого зохицуулалтын ямар арга хэрэглэх боломж байна вэ?
- 2) Малын хөлийн татварын хэрэгжилт ямар байна вэ?
- 3) Ойн нөхөрлөл, аж ахуйн үйл ажиллагааг бүрэн удирдаж, хянаж чадаж байна уу?

Дасгал 2. Байгалийн нөхөн сэргэхгүй нөөцийн ашиглалт

- 1) Өөрийн амьдарч байгаа нутгийнхаа сэргэхгүй нөөцийн жагсаалтыг гаргаж, хамгаалж, ашиглаж байгаа байдлыг хэлэлцэнэ үү?
- 2) Байгалийн нөхөн сэргэхгүй нөөцийг одоо болон ирээдүйд ашиглахын аль илүү өгөөжтэй байхыг орон нутгийн жишээгээр тайлбарлана уу?

Дасгал 3. Байгалийн нөхөн сэргэх нөөцийг орон нутагт ашиглах

Байгалийн нөхөн сэргэх нөөцийг орон нутагт ашиглахын давуу, сул талыг хэлэлцэж, бичнэ үү?

Жич: Өнгөрсөн хугацаанд байгалийн нөхөн сэргэх нөөц ашиглаж ирсэн туршлагаа санаж, түүнд тулгуурлаж болно.

Дасгал 4. Байгалийн нөхөн сэргэх нөөцийг орон нутагт ашиглах санал боловсруулах

Байгалийн нөхөн сэргэх болон сэргэхгүй нөөцийг орон нутагт ашиглах, хамгаалахад тохиромжтой 3-5 аргыг тодорхойлж, үндэслэлээ тайлбарлана уу?

Тохиромжтой арга	Тайлбар

Дасгал 5. Байгалийн нөөц ашигласны төлбөр

- 1) Байгалийн нөөц ашигласны төлбөрийг ИТХ-аар хэлэлцүүлэхэд юуг анхаарах шаардлагатай вэ?
- 2) Байгалийн нөөцийн төлбөрийн тухай хуулийг хэрэгжүүлэхэд үүсдэг хүндрэл, бэрхшээл
- 3) Байгалийн нөөцийн төлбөрийн үнэлгээний аргачлал, тариф практикт нийцдэг эсэх?

- 4) Байгалийн нөөцийн төлбөрийг орон нутгийн төсөвт тусгаж, байгаль хамгаалах ажилд зарцуулахад үүсдэг бэрхшээлийн тухай хэлэлцэнэ үү?
- 5) Тусгай хамгаалалттай газар нутагт ямар байгалийн нөөцийг ашиглуулж болох талаар ярилцана уу?

Нэмж уншиж судлах эх сурвалж

- Peter F. Dale, John D. McLaughlin. Land Administration. New York: Oxford University Press, 1999.
- Raleigh, Barlowe. Land Resource Economics. New Jersey: Michigan State University, 1978.
- UNECE. land administration principles. 2005.
- www.shuukh.mn сайт. УБ, 2016.
- Амарсанаа.Ж, Баянбилэг.Д. Захиргааны хэрэг. 2013: УБ, Захиргааны хэрэг.
- Батсүх.Ш, Долгоржав.Я, Ганцоож.Б. Шууд ардчилал - Иргэдийн оролцоо. УБ: Конрад-Аденауэр сан, Удирдлагын Академи, 2014.
- Долгоржав.А, Гуннар Андерссон, Золзаяа.Л, Лувсанжамц.Л. Монгол Улсад Нутгийн өөрийн удирдлагын чадавхийг бэхжүүлэх нь. УБ: МНУХ, ШТЗИ-SIPU, SALA IDA, 2003.
- Жаргал.Г. Манлайлалд алхам алхмаар суралцах нь. УБ: Арилдал, 2016.
- Монгол Улсын Газрын бодлого, удирдлага. УБ, 2013.
- Жаргал.Г, Солонго.Д, Уянга.М. Газар баялгаас өмч үүсгэх арга: Газрын эрх зүй. УБ, 2014.
- Лхагва.Т. Экологи. УБ, 2009.
- Мягмарсүрэн Д., Намхай А.,. Монгол улсын тусгай хамгаалалттай газар нутгууд. УБ: Мөнхийн үсэг, 2012.
- Сэлэнгэ аймгийн ИТХ-ын малчид, тариаланчдын үйл ажиллагааны зохицлыг хангах журам. Сүхбаатар, 2013.
- Хамтын Идэрпүрэв.А болон. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлуудын сайн туршлагын эмхтгэл. УБ: МОН 13/101 төсөл, ОНХХ, 2016.
- Хамтын О.Тунгалаг болон. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлах зарим журам, дүрмийн төслүүд. УБ: МОН-13/101 төсөл, Тунгаамал төв, 2016.
- Хамтын Цэгмэд.С болон . Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг дэмжих тэтгэлэг. УБ: МОН-13/101 төсөл, 2016.
- Ханс-Георг Петерсен. орч Намсрай Б, Энхбаяр Г, Амартүвшин, Ариунаа Л, ред Энхтайван Л. Төрийн эдийн засаг. УБ, 2008.
- Хулдорж.Б, Бум-аюуш.М, Дагва.Ш, Мягмар.Д, Шомбодоон.Д. Монголын тогтвортой хөгжлийн хөтөлбөр: ахиц, дэвшил, бэрхшээл, хэтийн зорилт. УБ: ЗГ, НҮБ, 2012.
- Чимид.Б. Багийн өнгөрсөн, одоо, ирээдүй. УБ : Удирдлагын Академи, 2002.
- Чимид.Б, Жаргал.Г, Отгончимэг.Х. Сум, дүүргийн эрх зүйн байдалд холбогдсон хуулийн системчилсэн эмхтгэл. УБ: ХЗҮТ, УА, 2005.
- Ыханбай.Х. Нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөцийн хамтын менежмент. УБ: БОАЖЯ, ОУХСТ төсөл, 2010.